



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр, Пүрэв гараг

| | |
|--|------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга | 1 |
| Хуралдааны товч тэмдэглэл: | 2-7 |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 8-75 |

| | |
|---|-------|
| 1. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 78 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 8-52 |
| 2. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал | 53-55 |
| 3. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх | 56-75 |

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 27-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 77 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баттулга, П.Батчимэг, Ж.Баясгалан, А.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганмаа, Х.Ганхуяг, М.Ганхүлэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, Ч.Номин, У.Отгонбаяр, Г.Очирбат, Ц.Туваан, Б.Түвшин, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, Д.Цогтбаатар, Ж.Чинбүрэн, Л.Энхнасан;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Х.Булгантуяа, М.Нарантуяа-Нара;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Л.Гантөмөр, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, М.Сарнай, Б.Тулга;

Тасалсан: Ж.Батсуурь, Б.Жавхлан, Д.Жаргалсайхан, Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: Н.Алтаншагай-16 минут, Ч.Анар-3 цаг 55 минут, О.Батнайрамдал-15 минут, Э.Батшугар-16 минут, Б.Бейсен-3 цаг 52 минут, Э.Болормаа-38 минут, Ж.Ганбаатар-03 минут, Д.Ганбат-18 минут, Т.Доржханд-1 цаг 40 минут, Б.Жаргалан-25 минут, Г.Лувсанжамц-07 минут, С.Лүндэг-26 минут, П.Наранбаяр-10 минут, Э.Одбаяр-10 минут, О.Саранчулуун-41 минут, А.Ундраа-06 минут, Г.Уянгахишиг-42 минут, Л.Энх-Амгалан-09 минут, Б.Энхбаяр-3 цаг 38 минут, М.Энхцэцэг-17 минут.

Нэг.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын 78 гишүүн 2025.09.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Т.Ариунтуяа, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирал Н.Алтанзул, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн газрын ахлах мэргэжилтэн Т.Анхбаяр, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх албаны хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Д.Будзаан, мөн газрын Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны чиглэлийн ахлах байцаагч Э.Саруул, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын байцаагч Б.Отгонбаяр, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Чойсүрэн, мөн яамны Нийслэлийн боловсролын газрын хүүхэд хөгжил, хамгаалал хариуцсан

ахлах мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Болормаа, Хүний их эмч, Нийгмийн эрүүл мэндийн судлаач Б.Лхам-Эрдэнэ, хуульч Б.Алтантуяа, Э.Сэлэнгэ, Эдийн засагч Т.Баасанжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, А.Ариунзаяа, Б.Пүрэвдорж, С.Одонтуяа, А.Ганбаатар, Т.Мөнхсайхан, Д.Батбаяр, Б.Жаргалан нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Ж.Золжаргал, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх албаны хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Д.Будзаан, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Б.Мөнхсоёл, Да.Цогтбаатар нар үг хэлэв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 25 минут үргэлжилж, 12 цаг 37 минутад өндөрлөв.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 13 минутад Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх санал хураалтаар үргэлжлэв.

Н.Учрал: 1.Байнгын хорооны саналаар Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 34

Бүгд: 89

61.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 37

Бүгд: 89

58.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 36

Бүгд: 89

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 35

Бүгд: 89

60.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 36

Бүгд: 89

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 41

Бүгд: 89

53.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 36

Бүгд: 89

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг

дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 32
Бүгд: 90

64.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 36
Бүгд: 89

59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 34
Бүгд: 89

61.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа байлцав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Н.Учрал: “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 43
Бүгд: 90

52.2 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /14:34/

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос, бүтээгдэхүүний хэлтсийн дарга Ч.Чулуунбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Баянмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Энхтүвшин, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Б.Пунсалмаа, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир үг хэлэв.

Н.Учрал: Байнгын хорооны саналаар Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 42

Бүгд: 91

53.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 00 минут үргэлжилж, 126 гишүүнээс 91 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 12 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж, мэндчилье ээ. Их хурлын гишүүдийн ирцийг танилцуулъя.

126 гишүүнээс 68 гишүүн ирсэн 54 хувийн ирцтэй байна аа. Ингээд чуулганы 11. Дүгээр сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Таван жилийн чиглэл Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж дуусаагүй байна. Тэгэхээр 5 жилийн чиглэлийг шуурхайлъя. Хуулиараа маргааш батлах ёстой. Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо тэгээд Сэддорж дарга 5 жилийн чиглэлийг нэгдсэн хуралдаанд бэлтгэмээр байна. Ингээд Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэж эхлээгүй учраас 1 дүгээр асуудал Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг нарын 78 гишүүн 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Асуулт хариулт 120 минут байна.

Хоёрдугаар асуудал. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. 2 дахь өдөр Чуулганы нэгдсэн хуралдаанаар нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхийг Их Хурлын гишүүдийн олонх дэмжсэн. 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нэн яаралтайгаар хэлэлцэхээр ЗГ-аас өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна аа. Индэрт урья.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

2012 онд ЭМЯ-аас санаачилж батлуулсан Тамхины хяналтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт сайн эрх зүйн орчныг бий болгож бодит үр дүн гаргасныг бид бүгд мэднэ ээ. Тухайн үед бид тамхи гэдгийг нэг ижил зүйлээр ойлгож төсөөлдөг байсан. Харин өнөөдөр тамхины хэлбэр хэрэглээ шинэ хэв маягт орсноор мөрдөгдөж байгаа хууль шинэ сорилттой нүүр тулаад байна аа.

Улсын Их Хурал өмнө гаргасан амжилт дээрээ тулгуурлаж, хүндээ ээлтэй, хүн төвтэй хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд нийгэмд шинээр үүсээд буй сорилт буюу хүүхэд өсвөр үеийнхний тамхины хэрэглээг бууруулах нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зүй ёсны шаардлага үүссэн.

Иймд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг олон улсын сайн туршлага Монгол Улсынхаа нөхцөл байдалд тулгуурласан тооцоо судалгаанд үндэслэж боловсрууллаа.

Нэгдүгээрт хуулийн төслөөр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хуулийн зохицуулалтад оруулж хяналт тавина аа. ДЭМБ-ын 2022 оны тооцооллоор Монгол Улсад тамхины хэрэглээ нийт хүн амын 28.4 хувьд хүрч Ази Номхон далайн бүсийн орнуудын дунд хамгийн өндөр тархалттай орны 7 дугаарт жагсаж байна. 2024 онд импортолсон 3.5 тэрбум ширхэг янжуур тамхийг нийт хүн амын тоонд харьцуулахад нэг хүнд нялхас, өтгөсөө оруулаад жилд дунджаар мянган ширхэг янжуур тамхи буюу 50 хайрцаг тамхи ноогдож байна. ГЕГ-ын мэдээгээр 2024 онд импортолсон янжуур тамхины хэмжээ 2012 оноос 2 дахин ихэсжээ. Мөн 2020 онд 47 мянган ширхэг электрон тамхи Монгол Улсын гаалиар орж ирж байсан бол 2024 онд энэ тоо 8.2 сая ширхэг болж 4 жилийн дотор 175 дахин өссөн байна. ЭМЯ болон ДЭМБ-ын Монгол Улсад хийсэн судалгаагаар 2019 онд 13-аас 15 насны сурагчдын 14 хувь нь утаат тамхи, 3.5 хувь нь шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн хэрэглэдэг байсан бол 2023 онд энэ үзүүлэлт 20 хувь, 25 хувь болж огцом өссөн дүнтэй судалгаа гарчээ.

Үүнийг энгийнээр хэлбэл 13-аас 17 настай 5 сурагч тутмын нэг нь янжуур, 4 сурагч тутмын нэг нь электрон тамхи хэрэглэж байгааг харуулж байна. Шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн болох электрон тамхи нь хүн ам зүйн хүрээнд хор багатай гэдэг нь нотлогдоогүйгээр үл барам хүүхэд залуусын дунд өргөн дэлгэрч ирээдүйн хорт зуршлуудад хөтөлдөг нь олон судалгаагаар нотлогдсоор байна.

Олон улсын судалгаагаар электрон тамхин бүтээгдэхүүн нь хорт бодис агуулдаг амьсгалын замын үрэвсэл үүсгэх, зүрх, судасны системд сөргөөр нөлөөлөх, никотин донтуулах эрсдэл өндөртэй болохыг тогтоосон. Мөн электрон тамхи нь тамхинаас гарах үр дүнтэй хэрэгсэл биш бөгөөд өсвөр үеийнхэн залуус донтох шинэ зам болж байгаа талаар дурдсан байна. Ийм ч учраас Сингапур, Норвег, Чили, Энэтхэг, Турк зэрэг дэлхийн 46 улс электрон тамхийг бүрэн хориглосон. 82 улс хууль тогтоомжоор эдийн засгийн болон эдийн засгийн бус зохицуулалт хийсэн. Үүний дотор Эстони, Финланд, Австрали, Шинэ Зеланд, Дани, Герман, АНУ Канад, Бүгд Найрамдах Хятад Ард улс, Нидерланд зэрэг 19 улс хүүхэд залуус татагдах амт үнэрийг нь хориглосон байна. Гэтэл Монгол Улс ямар ч хуулийн зохицуулалтгүй байгаа цөөн хэдэн улсын нэг хэвээр байна аа. Иймд бид электрон тамхи ба янжуур тамхи гэж ялгалгүйгээр ижил хуулийн зохицуулалтад оруулахыг эрмэлзсэн нь энэ хуулийн төслийн чухал зорилтын нэг юм.

Хоёрдугаарт Тамхин бүтээгдэхүүний татварыг үе шаттай нэмэгдүүлж хүүхэд өсвөр үеэ хамгаална аа. Тамхи татах нь хувь хүний сонголт ч үр дагаврыг нь нийгэм хүртдэг. Нийгмийн эрүүл мэндийн асуудал юм. Нийгмийн эрүүл мэндийг төрийн бодлогоор хамгаалж хуулиар зохицуулах шаардлагатай. Үүний үндсэн бөгөөд хамгийн үр дүнтэй хэрэгсэл нь эдийн засгийн арга болохыг тамхидалтын түвшнээ амжилттай бууруулж байгаа дэлхийн олон улсаас бид харж болно. Тиймээс янжуур, халаадаг, дүнсэн болон электрон тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг

2026-2030 оны хооронд үе шаттайгаар өсгөх зохицуулалтыг тусгалаа. Ингэснээр тамхидалт 14 хувь буурна. Манай улсын хувьд нэг хайрцаг янжуур тамхины дундаж үнэ 3850 төгрөг. Энэ үнийн 40 орчим хувь нь татвар эзэлж байгаа нь дэлхийн хамгийн хямд янжуур тамхитай улсын жагсаалтад багтаж улмаар тамхины хэрэглээг дэмжих нөхцөл бүрдэж байна. Тамхины хяналтын суурь конвенцид дурдсанаар тамхины хэрэглээг бууруулах хамгийн үр дүнтэй бодлогын нэг нь тамхинд ноогдуулах татварыг нэмэгдүүлэх юм. ДЭМБ-ын судалгаагаар тамхины үнийг 10 хувиар нэмэхэд хэрэглээ 4 хувь, хөгжиж буй орнуудад 5-аас 7 хувь буурдаг бөгөөд ялангуяа өсвөр насныхан илүү амархан татгалздаг байна.

Энэ хууль гарснаар тамхины үнэ нэмэгдэнэ ээ. Гэхдээ энэ нь төсвийн орлогыг бүрдүүлэх зорилго өвөртлөөгүй. Нийгмийн эрүүл мэнд тэр дундаа өсөн нэмэгдэж байгаа хүүхэд өсвөр үеийнхний тамхидалтыг бууруулж эрүүл мэндийг нь хамгаалахад чиглэж байгаа гэдгийг онцгойлон дурдъя. Маш товчоор хэлэхэд тамхины онцгой татварыг тамхины эсрэг тэмцэлд зарцуулна. Үүнд сурагчдын үдийн хоолны шим тэжээлийг дээшлүүлэх хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд буюу спортын дугуйлан хөтөлбөр барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулна. Мөн тамхинаас урьдчилан сэргийлэх гаргах бодитой тогтвортой арга хэмжээг санхүүгийн эх үүсвэрээр хангах эрх зүйн орчин бүрдэнэ ээ. Хуулийн төслийн гол зорилго бол хүүхэд өсвөр насныхны тамхидалтыг бууруулахад чиглэж байгаа. Тамхи татах нь хувь хүний сонголт гэж бид ярьдаг аа. Гэвч хувь хүн болж төлөвшиж амжаагүй хүүхэд өсвөр үеэ бид хувь хүний сонголт гэдэг нэрийн доор орхигдуулж болохгүй. Насанд хүрсэн тамхи татагчдын 90 хувь нь 18 нас хүрэхээсээ өмнө тамхи хэрэглэж эхэлсэн байдаг. 99 хувь нь 26 нас хүрэхээсээ өмнө тамхины хэрэглэгч болсон байдаг гэсэн судалгаа бий.

Өөрөөр хэлбэл хүүхэд өсвөр үеэ тамхидалтаас хамгаалах нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах тамхидалтыг бууруулах хамгийн үр дүнтэй арга зам юм. Та бидний заримд нь байгаа хор багатай гэсэн ташаа ойлголт нь элдэв төрлийн үнэр амттай хослохоороо өнөөдөр дөнгөж 10 настай балчрууд хүртэл электрон тамхины хэрэглэгч болж байгаа сэтгэл эмзэглүүлэн баримтуудыг багш, аав, ээжүүд ярьж байна. Электрон тамхи хэрэглэгч хүүхэд янжуур тамхины хэрэглэгч болох магадлал 3-аас 5 дахин ихэсдэг нь судалгаагаар нотлогдсон. Иймээс хуулийн төсөлд тусгасан зохицуулалтын арга хэмжээнээс дурдвал янжуур болон электрон тамхины амт үнэрийг хязгаарлана. Тамхи бол жимсний амттай зайрмаг биш. Тамхи бол эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүн. Бүх төрлийн тамхийг ил байршуулж худалдаалахыг зогсооно. Хүүхэд ордог хүнсний дэлгүүр тамхи сурталчилдаг үзэсгэлэн биш ээ. Тамхийг гудамж талбайд алхангаа ил татахыг хориглож дам тамхидалтын хор хөнөөлөөс иргэдээ хамгаална.

Эдгээр зохицуулалт нь янжуур болон электрон тамхинд ижил үйлчилнэ. Ингэснээр огт зохицуулалтгүй байсан тамхины шинэ тутам хэлбэрүүдэд хуулийн зохицуулалт үйлчилж эхлэх нөхцөл бүрдэнэ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бидний өнөөдөр хэлэлцэх хуулийн төсөл зөвхөн Номинчимэгийн эсвэл ажлын хэсгийн гишүүдээс дэвшүүлж байгаа санаачилга биш юм аа. Энэ бол иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах тангараг өргөсөн эмч нар, сурагчдынхаа ирээдүйд санаа зовоод хичээлийн завсарлагаанаараа сургуулийн ариун цэврийн өрөөнд манаа хийж байгаа багш нар электрон тамхи үнэртдэггүй болохоор хүүхдийн

төлөө хүүхдийнхээ төлөө санаа зовж халаасыг нь тэмтчиж байгаа аав ээж нар болон асран хамгаалагчдын хүсэл зориг нийгмийн захиалгаас төрсөн хуулийн төсөл юм. Олон 10 мянган эцэг эх эмч, багш нар энэ хуулийг батлагдахыг итгэл тавин хүлээж байна. Чөлөөт нийгэмд хуулиар хориглоогүй бизнес эрхэлж ашиг олох нь эдийн засгийн эрх чөлөөний үндэс гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэхдээ төгс бус зохицуулалт өрсөлдөөнгүй зах зээлийн үр дүнд онцгой хортой бүтээгдэхүүнээс огцом олох ашгийн төлөө ирээдүй хойч үеийнхээ эрүүл мэнд амь насыг золиосолж болохгүй ээ.

Нийгмийн эрүүл мэнд бол нэг хэсгийн бизнесийн орлогоос эрхэм зүйл юм. Янжуур тамхины татварыг нэмэгдүүлэхгүй байх нь жилд 4300 хүн буюу бүхэл бүтэн 1-ээс 2 сумын иргэдээ үхэл рүү түлхэж байгаатай адил зүйл юм. Электрон тамхийг хуулиар зохицуулахгүй байх нь хүүхэд залуусаа бүх төрлийн хорт зуршилд донтох эрсдэл рүү бид сайн дураараа хөтөлж байгаатай ижил явдал юм.

Эцэст нь хэлэхэд ямар ч төрлийн тамхи хортой нь үнэн, хортой бүтээгдэхүүн, зохицуулалттай байх ёстой нь ч үнэн. Харин тамхины эсрэг тэмцлийг бид хожимдож эхлүүлж байна. Гэхдээ үүнийг засаж залруулах арга хэмжээ авах нь улс үндэстэн үр хүүхдийнхээ өмнө хүлээсэн ард иргэдийн төлөөлөл болсон та бидний үүрэг юм аа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Энэхүү хуулийн төслийг Улсын Их Хурлын нэр бүхий 78 гишүүн буюу парламентын олонх гишүүд санаачилж өргөн барьсан нь өмнө байгаагүй санаачилга өргөн хүрээтэй дэмжлэг юм аа. Ирээдүйн хойч үеийнхээ эрүүл мэнд, Монгол хүний эрүүл амьд явах эрхэд санаа чилээж яваа гишүүддээ мөн ажлын хэсгийнхэнтэй талархал илэрхийлж байна.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дэмжиж өгөхийг та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Баярлалаа. Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг нарын 78 гишүүн 2025 оны 9 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүн амын эрүүл мэндийг хамгаалах тэр дундаа өсвөр үе, хүүхэд, залуучуудыг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, тамхины хэрэглээг бууруулах, Тамхины хяналтын тухай хуулийн зохицуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Дээрх хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын ди парламент цахим сайтад байршуулсан. Байнгын хорооны

хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа электрон тамхи болон түүний дагалдах хэрэгслийн онцгой албан татвар, гаалийн албан татварын хувь хэмжээг хэдэн хувь болгож ямар үе шаттай нэмэгдүүлэх мөн гаа болон жимсний амт үнэр оруулагчтай байх байхыг хориглож байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг ДЭМБ-аас гаргадаг олон улсын хэмжээнд ашиглаж буй нас баралтын статистик мэдээлэл манай улсынхтай нийцдэг эсэх, тамхи хэрэглээ нь хувь хүний сонголтын асуудал бус нийгэм эдийн засгийн нөхцөл байдал түүнтэй холбоотой асуудлаас хамааралтай эсэх, үүнд ОУБ-аас зөвлөмж өгч байсан эсэх мөн бусад улс орнуудад зөөлөн аргаар хэрхэн тамхитай тэмцэж байгаа туршлагын талаар, онцгой албан татвар болон гаалийн албан татвар нэмэгдсэнээр улсын төсөвт хэр хэмжээний хуримтлалд үүсэж байгаа, үүнийгээ юунд зарцуулах талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан электрон тамхи болон янжуур тамхинд ногдуулах татварын ялгаа нь юутай уялдаж ямар зохицуулалтын хүрээнд тогтоогдсон талаар, тамхины худалдаа нь далд эдийн засагт шилжих эрсдэл болон түүнд тавих хяналтын зохицуулалтын талаар, татвар нэмэгдсэнээр үүсэж байгаа хуримтлалын 50 хувийг ЭМД-ын санд төвлөрүүлэх талаар, мөн Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар тамхины татварыг нэмэгдүүлж буйтай холбогдуулан бизнес эрхлэгчид бэлтгэл хангасан эсэх үүнээс үүдэн сөрөг үр дагавар гарах эрсдэлийн талаар электрон тамхины никотин бус төхөөрөмжид татвар ногдуулж байгаа нь дүнсэн тамхийг татахдаа ашигладаг гаансанд татвар ногдуулна гэж ойлгох эсэх талаар, гаа болон үнэр амт орлуулагчийг хамтад нь нэг мөр хориглох эсхүл хориг тавихгүйгээр зөвхөн татварын хэмжээг нэмэгдүүлэх зохицуулалт хийж болох талаар, ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метр дотор тамхи худалдаалахыг хориглосон хууль хэрэгжихгүй байгаа. Үүний хяналтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат электрон тамхины гаднах үзэмж сав баглааг хүүхдийн анхааралд өртөхгүй болгож хор хөнөөлийн талаар сурталчилгааг олон нийтэд идэвхжүүлэх, мөн орон нутгийн бага төвлөрөлтэй аймаг сумдад хүүхдийн орчинд тамхи худалдаалахыг хориглосон хууль нь уялдахгүйгээс болж хууль бус худалдаа явагдаж байгааг хэрхэн зохицуулах талаар, электрон тамхины хор хөнөөлийн талаар ДЭМБ-аас баталгаажуулсан судалгаа, нотолгоо бий эсэх, олон нийтийн газар тамхи татах, зөрчилд ногдуулах, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа Улс орнуудын тамхины хуулийн зохицуулалт болон харьцуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Шижир манай улсын гаалийн байгууллагад импортолж буй тамхин бүтээгдэхүүнд шинжилгээ хийдэг эрх бүхий лаборатори байдаг эсэх, хийсэн шинжилгээний хариу нь шинжилгээний бичигтэй таардаг эсэх, мөн хуулийн төсөл яригдаж эхэлснээс хойш тамхины импортын татан авалт хэд дахин нэмэгдэж байгааг хэрхэн зохицуулж байгаа талаар асуулт асууж хариулт авсан болно оо.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Монголд орж ирж байгаа янжуур тамхины 45 хувь, электрон тамхины 95 хувь нь үнэр амттай байдаг. Үүнийг хорьсноор тамхийг бүхэлд нь хорьж байгаатай адил талаар, насанд хүрсэн хүмүүсийн сонголтын асуудлыг бус хүүхдийг цаашид тамхинаас хол байлгахыг зохицуулах нь хуулийн гол үзэл баримтлал болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа хуулийг яаралтай баталж ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн хэрэглээний асуудалд онцгой анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Болормаа тамхины онцгой албан татвараас орж ирэх орлогоос хүүхэд залуучууд, эрүүл мэнд болон бусад хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх талаар тусгахыг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун электрон тамхинд донтуулах, сэтгэл гутрал, түгших эмгэгийг нэмэгдүүлэх сэтгэцийн шалтгаантай холбоотой байдлыг авч үзвэл сургуулийн хүүхдүүдийн сэтгэл гутрал дээрэлхэлтийн асуудал үүнтэй холбоотой

гэсэн олон улсын судалгааны талаар, сэтгэл зүйн асуудлыг хэрхэн даван туулах талаар бид хүүхдүүддээ огт сургадаггүй. Үүнийг ерөнхий боловсролын хөтөлбөрт оруулах хэрэгтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Галбадрах хүүхэд залууст хор хөнөөлийн талаар илүү сурталчлах мөн хууль бус худалдаа газар авах тал дээр анхаарах шаардлагатай. 2030 он гэхэд тамхины хэрэглээг 30 хувь бууруулна гэснийг хангахын тулд илүү бодитой арга хэмжээнүүдийг төлөвлөж хийх ёстой талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхнасан 21 нас хүрээгүй хүнд худалдаалахыг хориглож татвараас орж ирэх орлогыг хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд зарцуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг гаа болон бусад үнэр амтыг бүрэн хориглох нь зүйтэй талаар, хуулийн хэрэгжилт хариуцлагын тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар гаалийн байгууллага онцгой анхаарах шаардлагатай. Мөн Монголбанк энэ төрлийн худалдаа эрхлэх гэж байгаа хүмүүст зээл олгох боломжгүй гэсэн журам гаргах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Найдалаа хуулийн үзэл санаа нь янжуур, электрон тамхи ялгахгүйгээр зохицуулалтыг тэгш хийх татварын орлогыг ЭМД-ын санд төвлөрүүлэх нь зүйтэй талаар санал хэлсэн болно оо.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 86.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЭМД-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдэгтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, тогтоолын төслийг хэлэлцсэн эсэх талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар болон байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуух ёстой.

Ингээд ажлын хэсгийн гишүүдийг та бүхэнд танилцуулъя. Батмөнхийн Цэцэгсайхан ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Лхагваагийн Баттөр НЭМҮТ-ийн захирал, Түвдэндоржийн Ариунтуяа

АШУҮИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга анагаах ухааны доктор, Нармандахын Алтанзул СЭМҮТ-ийн дэд захирал, Лодойсамбуугийн Дэлгэрзул Орчны эрүүл мэнд судлаач, хүний их эмч, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Түвшинтөрийн Анхбаяр Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Сүхбаатарын Болормаа ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрын Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт хяналтын асуудал хариуцсан мэргэжилтэн. Сэд-Очирын Цэрэнчимэд ГЕГ-ын төв лабораторийн дарга, Чойдоржийн Чимгэрэл ГЕГ-ын барааны ангилал үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга, Бямбаагийн Отгонбаяр Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын татварын улсын байцаагч, Бүрэнтөгсийн Алтантуяа хуульч, Эрдэнийн Сэлэнгэ хуульч, Төмөрийн Баасанжав Эдийн засагч, Эрдэнийн Чойсүрэн Боловсролын яамны Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Батжаргалын Мөнх-Эрдэнэ НБГ-ын Хүүхэд хөгжил, хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн, Бямбадоогийн Лхам-Эрдэнэ Хүний их эмч, Нийгмийн эрүүл мэнд судлаач, Даваасамбуугийн Будзаан ЦЕГ-ын урьдчилан сэргийлэх албаны Хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа, Энхбаатарын Саруул ЦЕГ-ын Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна аа.

Ингээд намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Бүгдээрэнд нь өглөөний мэнд хүргэе. Монголчууд тамхи 5 нас, архи 10 нас гэж хэлдэг. Энэ бас учиртай. Гол асуудал бол юуны өмнө бас Лувсангийн Эрдэнэчимэг Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан Эрдэнэчимэг гишүүний бас санаачлан батлуулж байсан тамхитай холбоотой энэ эрх зүйн зохицуулалт бас тухайн үедээ бас шуугиан дэгдээж байсан авч яг урт хугацаандаа бол Монголын нийгэмд бас маш том эерэг соёлыг бий болгосон гэдгийг онцлон хэлэх ёстой. Тэр утгаараа бол бас Улсын Их Хурлын гишүүн асан Эрдэнэчимэгт бас онцгойлон талархмаар байгаа.

Ер нь бол ингээд соёл бол цаашаа ингээд ахиад нөхцөл байдал, технологи, нийгмийн ойлголт, танин мэдэхүй гээд ингээд явдаг аа. Энэ зүгээр яах вэ маш өргөн хүрээтэй сэдэв байгаа. Энийг тодорхой хэмжээнд бас зохицуулах гээд байгаа учраас иргэдийн дунд маш өөр өөр төрлийн ойлголтууд байгаа. Ямар ч байсан энэ Интермед эмнэлгийн эмч Б.Аззаяа гэж дүрс оношилгооны эмчийн бас ингээд судалгаа байгаа юм аа. Электрон тамхинаас шалтгаалж уушгинд гарах өөрчлөлт шинжилгээнд хэрхэн илрэх вэ гээд. Тэгээд яг энэ ингээд бодит энэ юуг харахаар гэрэл зургуудыг одоо энэ цээжний хөндийн зургууд болон энэ зөвхөн Монголын нөхцөл биш яг дэлхий дээр гарч байгаа. Ийм судалгаануудын баримт байгаад байгаа юм. Ингээд харахаар бол яалт ч арга байхгүй бусад улсуудад явж байгаа энэ зохицуулалтыг манай улс хийх зайлшгүй шаардлагатай болчихоод байгаа. Ялангуяа электрон барааны халхавч доор нэр доор татваргүй орж ирж байгаа энэ шингэн тамхи буюу бид нарын хэлээд байгаа веп дээр бол маш яаралтай маш хурдтай зохион байгуулалт зохицуулалтыг хийх ёстой. Энэ бол үнэхээр хяналтад орох цаашлаад энэ өвчлөлийн асуудал, хамрах хүрээ, үр дүн магадгүй асуудалтай байгаа. Ер нь бол цар тахлын үеэс өгсүүлээд энэ вептэй холбоотой судалгааг олон улсад маш их хэмжээгээр хийж эхэлсэн бөгөөд хэрэглэдэггүй хүмүүсийн дэргэд бол

маш их өвчлөмтгий өртөмтгий байгаа нь бол ингээд нотлогдсон судалгаа байж байгаа. Энэ утгаараа бол би энэ хуулийн үзэл санааг бол дэмжиж байгаа. Гэвч нөгөө талд нь бас сая бас АН-ын бүлэг дээр энэ хуулийг хэлэлцэх асуудлаар бас хэлэлцүүлэг хийж танилцуулга авсан л даа.

Тэгэхээр 1 ийм асуудал байгаад байгаа. Иргэдийн дунд байгаа эргэлзээ байгаад байгаа. Энийг ажлын хэсгээс тодруулъя. Номинчимэг гишүүнээс.

Юу вэ гэхээр таны түрүүний танилцуулга дээр хэлсэнчлэн татвар нэмэгдэнэ гэж байгаа юм. Дүнсэн тамхи нөгөө янжуур тамхи утаат тамхи гэсэн үг. Гал асааж цог гаргаж татдаг тамхийг би ялгаж онцолж хэлээд байгаа юм шүү. Тэгээд энэ бүлэг дээрх танилцуулгаас харж байхад бол 800 төгрөгийн татвар нь ингээд үе шаттайгаар 4, 5 жилийн дотор ингээд 18 мянга руу хүрчих юм байна аа. 18 мянга гээд. Тэгээд энэ маань эргээд ямар гэдэг юм болгоомжлол байна. Нөгөө хуурай хууль гэдэг шиг дахиад бүрд илүү чанар муутай тамхи хууль бусаар орж ирэх нөхцөл байдал үүсэх үү? Энэ дээр ер нь яг энэ эрх зүйн талаасаа ер нь яг ямар зохицуулалт байх юм? Ямар урьдчилан сэргийлэх бодлого байх юм бэ? Мэдээж бид нар архийг тамхийг гоё сайхан ингэж сурталчлах хүн олдохгүй л дээ. Гэхдээ яг бодит байдал дээр энэ эргээд энэ татварын бодлогоо ингээд огцом нэмэгдүүлэх нь эргээд ер нь ямар үр дүн гаргах вэ? Энэ тал дээр эрх зүйн хувьд ямар эрсдэл учирч болох вэ гэдэг дээр ямар нэгэн урьдчилсан судалгаа байна уу? Энэ талаар тодруулга өгөөч.

Хоёрдугаарт ер нь бол энэ татварыг нэмэх аль болохоор л нэмэхээс бид нар ингээд болгоомжилж байгаа шүү дээ. Ер нь бол иргэдийн нуруун дээр татварыг олон талаар нэмснээрээ энэ үр дүн асар хүнд нөхцөл байдал тэгээд энэ нь эргээд логикийн хувьд ямар нэгэн зөрчил байна уу үгүй юу?

Н.Учрал: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулъя.

О.Номинчимэг: Эрдэнэболд гишүүнд баярлалаа. Энэ хуулийг бас үзэл баримтлалын хүрээнд дэмжиж гарын үсгээ зурж, хамтарч бас ажиллаж байгаад хувь гишүүний өмнөөс талархал илэрхийлж байна. Энэ хуультай холбогдуулаад бол нэлээн анхны ажлын хэсэг байгуулагдсанаас хойш л янз бүрийн мэдээлэл бас явж байгаа. Тэгээд тамхины асуудал ярихаар ерөнхийдөө дэлхий дахинаа ч гэсэн зөвхөн Монголын асуудал биш янз бүрийн байдлаар айлгах тактикууд бас хэрэглэдэг юм байна лээ. Тэгээд 2012 онд Эрдэнэчимэг гишүүн үүнийг хүртэл дотор орчин тамхи татахаа болино оо гэдэг хуулийг ахлаад явж байхад нь тамхи татахаа больчих юм бол баар рестораны орлого байхгүй болно бид нар дампуурна аа гэдэг асуудлыг тавьж байсан. 2017 онд гаалийн албан татвар янжуур тамхин дээр тавхан хувь байсныг нь IMF-ээс та нар эрүүл мэндийн бодлогоо хийж чадахгүй байна аа. Наадах чинь татвараа нэм гээд 5 хувийг одоогийн байгаа 30 хувь болгосон. 25 хувиар огцом нэмэгдүүлсэн. Тэгээд 2017 оноос хойш дахиад үе шаттайгаар онцгой албан татварыг нэмэгдүүлсэн.

Тэр үед ч гэсэн хуурамч тамхи үерлэж орж ирнэ болохгүй гэдэг зүйлийг нэлээн явуулж байсан юм байна лээ. Гэхдээ одоо бид нар мэдрэмжээрээ биш тоо судалгаан дээр тогтож ярих ёстой. Үүний дараа 2020 онд Австралийн эрдэмтэд Монгол Улсын эрдэмтэн хамтраад үнэхээр ингэж гаалийн албан татварыг онцгой албан татварыг нэмснээр хуурамч тамхи орж ирж үү гэдэг судалгааг хийсэн байна лээ. Тэгээд энэний үр дүн нь харин ч энэ татварыг нэмснээс хойш хуурамч тамхи багассан гэдэг ийм судалгаа гарсан байгаа юм. Тэгээд бид бас энэ татварын

тооцооллыг хийхдээ нэлээн ул суурьтай хандаж хичээсэн. Энэ дээр манай мэргэжлийн баг, Сангийн яам, Гааль ДЭМБ-ын татварын бодлогынхон эрүүл мэндийнхэн маань гээд хамтдаа суусан.

Энэ бол өөрөө татварыг мэдээж ул суурьтай байхын тулд Монгол Улсын иргэдийн хүн амын орлого, худалдан авах чадвар, хэрэглээний үнийн индексийн өсөлт инфляц гээд олон зүйлийг бид тооцож энэ зохицуулалтыг хийсэн. Тэгээд энэ зохицуулалтаа өөрөө тамхин дээр манай Монголд талхнаас хямдхан тамхитай болоод байгаа. Үүнийг ямар үнэтэй болохыг манай ажлын дэд хэсгээс бас нарийн тооцоолол хийсэн хүмүүс маань танилцуулаасай гэж бодож байна. Ер нь манай Монгол Улсын хувьд бол өмнө нь 2012 онд Эрдэнэчимэг гишүүн маань энэ хуулийг ахлаад онцгой албан татвар нь доллароор илэрхийлэгддэг байсан юм байна лээ. Тухайн үед бол нэг хайрцаг янжуур тамхинд 1700-аас 1800 төгрөгтэй тэнцэх онцгой албан татвар оногддог байсан. Тэгтэл одоо бол нэг 830 хэдхэн төгрөг байгаа.

Тэгээд бид нар бол энийг мэдээж огцом нэмчихгүй. Жил болгон үе шаттайгаар нэмнэ. Энэ үе шаттай нэмж байж бид нар олон улсын сайн туршлагын дагуу тамхидалтаа бууруулна. Үе шаттай нэмж энэ 14 хувь бууруулна гэдэг зорилтын маань гол тооцоолол нь яг л энэ хүн амын амьжиргаа бүх тооц эдийн засгийн судалгаан дээрээ бол үндэслэсэн байгаад байгаа юм аа. Тэгэхээр энэ бол төсөв бүрдүүлэх гэж байгаа зорилго биш энийг эргээд хүүхэд залуучууддаа бас зориулна гэдэг энэ зорилтыг.

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Т.Баасанжав: Сайн байна уу? Эдийн засагч Баасанжав байна. Татвар нэмэгдэхтэй холбоотойгоор энэ хууль бус худалдаа дэлгэрэх үү гэдэгт энэ асуултад 2 талаас нь хариулах ёстой байгаад байгаа юм.

Нэгдүгээрт. Энд хууль хяналт, нөгөө гааль, хууль хяналтын байгууллагууд Хэр ажлаа ингээд зөв зохистой явуулж чадах вэ? Нөгөө талд иргэд маань яг энэ хууль бус тамхи, үнэ нэмэгдэхтэй холбоотойгоор хууль бус тамхийг хэр их хүсэх вэ хэр их нөгөө авах сэдэл нь нэмэгдэх вэ гэдэг талаас нь тайлбарлах ёстой байгаад байгаа юм.

Энд хариулахад бол нэг хамгийн чухал судалгаа энэ. Сая гишүүн дурдлаа. Энэ 2017 онд бол манай Монгол Улсад бол гаалийн татварыг 5-аас 30 хувь, 2018 оны нэг сараас онцгой татварыг 10 хувиар нэмэгдүүлсэн байгаа юм. Энэ үед юу болж байсан талаар эдгээр судлаачид маань судалсан байгаа юм. Яасан бэ гэхээр Улаанбаатар хот болон хил орчмын аймгууд тэгээд томоохон аймгууд дээр хэрэглэсэн тамхинд.

Н.Учрал: Энэ ажлын хэсгийнхэн энийг энэ иргэд олон нийтэд зөв мэдээлэл өгнө шүү. Тийм 4 дүгээр микрофон.

Т.Баасанжав: Хэрэглэсэн тамхины татварын акцыг шалгасан байгаа юм. Энэ дээр бол татвар нэмэгдэхээс өмнө бол нийтдээ хууль бус тамхины хэмжээ бол 13 хувьтай байсан бол татвар нэмэгдсэний дараа энэ тоо багасаж 6.3 буюу 2.5 дахин буурсан байгаа юм. Өөрөөр хэлбэл хууль хэрэгжүүлэх байгууллагад тийм ажиллагаа бол энд нөлөөлж татвар нэмэгдсэнээр хууль бус худалдаа бол газар аваагүй гэдгийг нотолж байгаа юм. Мөн түүнчлэн иргэдийн худалдан авах чадвар

талаас нь тайлбарлах ёстой. Иргэдийн худалдан авах чадвар тухайн үед 2017 онд ямар байсан бэ гэхээр дундаж голч цалин маань 700 мянган төгрөг байсан байгаа юм. Энэ үед голч цалин 700 мянга байхад дундаж тамхины үнэ янжуур тамхины үнэ нэмэгдээд тухайн тамхины блок буюу 200 ширхэгтэй тамхины эзлэх үнэ нь бол 6 хувьтай байсан бол манай улс улсад энэ тоо бол 1.5 хувьтай болчихоод байгаа юм.

Н.Учрал: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн тодруулна.

С.Эрдэнэболд: Энэ уг нь би аягүй тодорхой юмнууд асуугаад байгаа байхгүй юу. Яагаад гэхээр энэ тодорхой мэдээллүүдийг иргэддээ өгч байж энэ чинь ойлголт зөв явах гээд байгаа юм. Нийгмийн дэмжлэгийг ч гэсэн авах гээд байгаа юм. Би бол шулуухан хэлэхэд бол гаальд эргэлзэж байгаа. Гаальтай холбоотой маш олон гомдол Хүний эрхийн дэд хороон дээр ирдэг. Бусад улсын гааль маш аягүй нарийн тооцоолоод ингээд явуулдаг. Манай улсад ороод ирэхээрээ гааль нь үзэмжээр асуудалд хандаад тэр контейнероос авч байгаа юмаа үзэмжээр хандаад байдаг гэж. Өөрөөр хэлбэл би ямар нэгэн байдлаар энд далд эдийн засгийг гааруулж нөгөө Сухой закон гэж хуурай хууль гэж Америкт 1930-аад оны үед болж байсан архийг хорьчихонгуут маш их хэмжээний хуурамч бүтээгдэхүүн илүү хортой бүтээгдэхүүн өөр аргаар орж ирдэг шиг юм болох вий дээ. Энэ дээр эрх зүйн хувьд ямар судалгаа хамгаалалт байгаа юм бэ гэж би асуугаад байгаа байхгүй юу. Энэ дээр нь тодорхой хариулт надаа хэрэгтэй байгаад байгаа юм. Энэ нь надад биш.

Н.Учрал: Манай Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн бол өөрөө хууль санаачлагч. Тийм тэгээд 78 гишүүн энэ хуулийг санаачилсан шүү. Тэгэхээр өнөөдрийн энэ мэтгэлцээн бол 78 гишүүн. 20 үлдсэн гишүүдийн асуултад хариулна. Үгүй ер нь зарчим нь тэр шүү. Тэгээд тэрнээс биш та нар тэр хуулиа санаачилчхаад энд орж ирээд ингээд бие биеэсээ асуугаад байж болохгүй тийм биз дээ? Ажлын хэсгийнхэн. 78 гишүүн санаачилсан гэж итгээд энэ ажлын хэсгийнхэн та бүхэнтэй ажилласан шүү дээ өнгөрсөн хугацаанд. Ер нь тэгээд манай хууль санаачлагч нар өөрсдөө дотроо сайн ярилцаарай л гэж байгаа юм. Ажлын хэсгээс хариулъя Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. 4 дүгээр микрофон. Аан за Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ мэдээж энэ асуудлыг шийдэх ёстой гэсэн 78 гишүүний үзэл санаан дээр нэгдэж өргө өргөн баригдсан байгаа. Тэгээд Эрдэнэболд гишүүний яг тодорхой асуултад бид нар энэ хуурамч тамхинаас сэргийлэх тамхины хяналтын эргэлтийн хянах мэдээллийн сантай болно. Энэ амжилттайгаар архи архин бүтээгдэхүүн дээр хэр хэрэгжээд явж байгаа. Дахин давтагдашгүй онцгой албан татварын акцтай болсноор хаана үйлдвэрлэсэн, хэн оруулж ирсэн, хаана зарж байгаа гэдэг мэдээллийн сантай болно. Үүгээрээ бид нар хуурамч тамхинаас сэргийлэх том эрх зүйн ийм хөшүүрэг гарч байгаа. Мэдээж бид нар хэрэгжилт дээрээ харах ёстой. Гэхдээ бид нар энийг тооцоо судалгаатай харах ёстой эдийн засгийн хувьд бид нарын өрхийн орлого болон түүнд эзлэх тамхины нөлөөгөөр бид нар хамгийн бага улсуудын нэг. Энэ ингэлээ гээд хуурамч тамхи хөрш орнууд маань манайхаас янжуур тамхины хувьд 3-аас 4 дахин өндөр үнэтэй, хямдхан байх тусам ерөөсөө контра бондын асуудал байхгүй. Манай одоогийн зах зээл ч гэсэн хуурамч тамхины асуудал байхгүй байна аа гэдэг тооцоо судалгаа нь бол гарчихсан байгаа гэдгийг давтаж хэлье ээ.

Н.Учрал: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Хуулийг дэмжиж байгаа. Өргөн барьсан гишүүдийн нэг. Ийм учраас Улсын Их Хурлын дарга Учралын хэлсэн анхааруулгад нийцүүлж яагаад дэмжиж байгаа болон иргэдэд яг тодорхой мэдээллийг хүргээч гэж хүсэхээр байна. Тэр нь юу юм бэ гэхлээр яг тамхины үнэ хэдэн төгрөг болох гээд байгаа юм бэ гэдэг яг тодорхой хэлээд өгөөч гэдгийг л хүсээд байгаа юм. Одоо бол янжуур тамхи жишээлбэл нэг хайрцаг нь дунджаар 3850 төгрөг байна аа гээд. Тэгээд одоо бол онцгой албаны татвар бол нэг 5-аас 20 хувь байгаад байгаа шүү дээ. Энийг 30 хувь болгоно гэж байгаа юм.

Тэгэхээр 3 жилийн дараа энэ 3850 гэдэг мөнгөн дүн хэдэн төгрөг болох гээд байгаа юм бэ? 30 мянган төгрөг болох гээд байгаа юм уу? 20 мянган төгрөг болох гээд байгаа юм уу? Хэдэн төгрөг болох юм бэ гэдгийг яг тодорхой үнийн дүнгээр нь хариулаад өгөөч гэдгийг л хүсээд байгаа юм. Тэгэхгүй бол энэ дээр чинь сууриалаад тамхины хайрцаг тамхины үнэ 30 мянган төгрөг болох гэнэ. Янжуур тамхины лобби явж байна гэнэ гэсэн ийм харлуулах ажиллагаа яваад байна шүү дээ. Цахилгаан тамхины хувьд бол адилхан хортой. Энэ нэг янжуур тамхи хортой нөгөөдөх нь бага хортой юм шиг юм ярих гээд байгаа юм. Үгүй шүү дээ адилхан хортой. Тэгээд адилхан хортойг нь мэдэж байгаад мэдэхгүй байгаа юм уу, мэдээд байгаа юм уу? Ямар ч байсан нөгөө янжуур тамхийг утаат тамхийг тамхи татах цэгт л татдаг. Гэтэл нөгөө цахилгаан тамхийг нөгөө вепийг бол хаа дуртай газраа татаад байгаа байхгүй юу.

Тэгээд наадах чинь муухай үнэргүй, хувцсанд чинь шингэхгүй, чамд ямар ч хоргүй гээд. Гэтэл үгүй шүү дээ тэр чинь агаар дуслар дамжаад жижигхэн химийн элементүүд дам тамхидалтыг бас үүсгэж байгаа адилхан хортой. Энэ ердөөсөө аль нь бага хортой вэ гэдэг асуудал огтоос биш. Ийм учраас аль алийг нь тамхи тамхин бүтээгдэхүүн гэдгийг бол хүлээн зөвшөөрч аль алинаас нь гаалийн онцгой албан татвар авах ёстой. Ингэж байж сая бид нар энэ үнэ дээр чинь нөлөөлнө. Эргээд тамхидалтын эсрэг авах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Мөн түүнчлэн ЗГ-ын тусгай сангаас зарцуулах тэр Онцгой албан татварын дүнг нь эргүүлээд хүүхдүүддээ зарцуулах энэ боломжийг нь бол бүрдүүлнэ ээ. Ийм учраас яг үүн дээр тодорхой үнийн дүнгээр хариулж өгөхийг хүсэж байна аа.

21 наснаас доош хүнд ямар ч төрлийн архи тамхийг борлуулж болохгүй шүү дээ. Тэгээд үүнийг мэдсээр байж худалдаачид өнөөдөр юу гэдэг вэ гэхлээр цахилгаан тамхи веп болоод энэ электрон тамхинууд бол хуулийн зохицуулалт байхгүй учраас хуулиа аваад ир. Тэр хүртэл зохицуулалтгүй байгаа учраас би хэндээ борлуулах вэ яах вэ гэдэг нь бол бараг миний дур гээд суугаад борлуулж байгаа байхгүй юу. Ингэж болохгүй шүү дээ тэгээд уг нь бол тодорхой аймгийн засаг дарга нар тодорхой дүүргийн Засаг дарга нар тодорхой хүмүүс энэ хүүхдүүдэд аюул учруулж байгаа учраас зохицуулахыг оролдож байгаа нь сайн хэрэг. Та нарт бас талархлаа дэвшүүлэх ёстой түрүүлээд хөдөлж байна. Бид нар бол дэндүү хойрго дэндүү удаан байгаа байхгүй юу. Ийм учраас энэ хуулийг бол хэдүүлээ бас зөв ойлголттой байгаад зөвөөр бас дэмжээд батлах нь бол гарцаагүй шаардлагатай байна аа.

Ийм учраас гишүүдийгээ бас дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Нийгэмд хортой буруу мэдээллийг бүү түгээгээч ээ. Тамхи бол тамхи адилхан хортой, адилхан татвар авах ёстой гэдгийг бол онцгойлж хэлмээр байна. Тэгээд ажлын хэсгээс яг хэдэн төгрөг болох гээд байгаа юм бэ гэдгийг тодорхой хариулж өгөхийг хүсье.

Н.Учрал: Ажлын хэсэг хариулъя. Утаат тамхи яг хэдэн төгрөгөөр зарагдаж эхлэх гээд байгаа юм бэ. Энэ нийгэмд зөв мэдээлэл өгөөч гэдэг асуулт асууж байна шүү дээ? Тодорхой. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Т.Анхбаяр: Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Анхбаяр байна. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Жижиглэнгийн тамхины дундаж үнийн өсөлт 2026 онд 12-оос 17 хувь орчмоор нэмэгдэхээр, 2027 онд 30-40 хувь, 2028 онд 20-30, 2029 онд 15-аас 22 хувиар, 2030 онд харин 15-аас 18 хувиар нэмэгдэхээр ийм тооцоолол гаргасан байгаа. Шинэ яг хэд байсан тамхи хэдэн төгрөгийн үнэтэй байсан тамхи хэдэн төгрөг болох вэ гэдэг ийм бас тооцооллыг хийж гүйцэтгэсэн байгаа.

Үүнээс үзэхэд бол 2025 оны байдлаар импортын янжуур тамхины дундаж үнэ 3742 төгрөг байгаа бол 2026 онд 4366 төгрөг болж нэмэгдэхээр байгаа. тэгэхээр энэ тооцооллыг хийхдээ нэлээн олон индексүүд нэлээн олон үзүүлэлтүүдийг бас үндэслэж энэ тооцоолол хийсэн байгаа. Жишээ нь борлуулагч, үйлдвэрлэгч, борлуулагч, тамхи импортлогч гэх зэрэг энэ оролцогч талуудын холбогдох тооцоо судалгаа, тооцоо тоонууд дээр үндэслэж энэ тооцооллыг хийж гүйцэтгэсэн байгаа.

2027 онд 4366 байсан янжуур тамхи маань 7082 төгрөг болох ийм тооцоолол байна. 2028 онд 9815 төгрөг, 2029 онд 12567 мянган төгрөг, 2030 онд харин 15339 төгрөг болно оо гэсэн үг. Ийм тооцоолол байна аа.

Н.Учрал: Тодруулах уу? Ариунзаяа гишүүн. Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Гишүүдийг бол манай Монгол Улсыг олон улстай бас харьцуулж үзэхийг хүсэж байгаа. Та нар хаана ч очсон бай ямар дүнгээр тамхи авдаг билээ ер нь тамхи худалдан авахад бол бас ямар хүндрэлтэй байдаг билээ гэдгийг бас ойлгох хэрэгтэй. Тэгээд зүгээр насанд хүрсэн хүмүүсийн асуудал огтоос биш. Энд бол бас дахиад өсвөр насны хүүхдүүдийг хэрхэн яаж хамгаалах вэ өсвөр насны хүүхдүүдийг энэхүү аюулаас хэрхэн яаж автуулахгүй байх вэ гэдэг дээр л хамгийн гол хуулийн зорилго байгаа юм аа гэдгийг дахин давтаж хэлье ээ.

Н.Учрал: Баярлалаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асууна.

Б.Пүрэвдорж: Л.Эрдэнэчимэг гишүүн 2012 онд батлуулаад 2013 оны 3 сарын 1-ээс хэрэгжсэн Тамхины хяналтын тухай хуулиар тамхи татах зөвшөөрсөн цэгийг тодорхойлж өгсөн.

Баар цэнгээний газар тамхи худалдаалахыг хориглож өгсөн. Дээрээс нь үе шаттайгаар тамхины татварыг нэмэгдүүлэх энэ асуудлыг шийдэж өгсөн. Үүний үр дүнд хамгийн их олон баярласан хүмүүс бол айлын эзэгтэй нар эмэгтэйчүүд юм аа. Яагаад гэвэл тэр их нэгширсэн тамхины үнэртэй хувцсыг цэвэрлэхээс өгсүүлээд ажил их гардаг, дээрээс нь гэр оронд нь зардал гээд л маш их юм гардаг байсныг шийдэж өгсөн. Тэгээд энэ дээр бас нэг асуудлыг шийдвэрлэсэн нь бол ЕБС-аас болон дотуур байрнаас 500 метрт тамхи дотогш тамхи худалдахгүй гэдэг ийм заалт. Тэгээд мэдээж энэ заалт өнөөдөр тодорхой хэмжээгээр үр дүнд хүргэсэн. Гэвч өнөөдөр, нөхцөл байдал, бас энэ хууль, энэ заалтыг бас тодорхой хэмжээгээр харж үзэхээс өөр аргагүй болчихоод байна.

Улаанбаатар хотын барилгажсан хэсэг болон сумын төв дээр энэ хэрэгжихгүй. Жишээ нь энэ хуулийг хэрэгжих явцад нэг сумын даргыг нөгөө сургуулийн дотуур байрнаас нь хэмжээд болохгүй болох дээр нь сургуулийн байрнаас нь хэмжиж байгаад 500 метрийн дотор оронгуут нь хуулиар далайлгаж байгаад ажлаас нь чөлөөлөөд бараг шоронд явуулчхав уу яав тийм л юм гарсан гарсан шүү дээ. Тэгэхээр сум болгонд энэ ийм нөхцөл байдалтай байгаа. Тэгээд бүх тамхи бүгдээрээ далд хэлбэрт орсон. Тэгээд энийг нь хэрэгжүүлэх ажил нэг их тийм үр дүнтэй болохгүй байгаа. Тэгээд Учрал гишүүн энэ 2025 онд Ерөнхий сайдад тавьсан асуулгад ЦЕГ-ын дүгнэлт, дээрээс нь Парламентын тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлангаар энэ хэрэгжиж байгаа юм уу хэрэгжихгүй юм уу гэдэг ийм асуулга тавьж байсан байна лээ. Энэ бол ерөөсөө олон олон байгууллагуудаар энэ огт хэрэгжихгүй байгаа нь тодорхой болоод байгаа.

Тэгэхээр ер нь энэ тамхи худалдаалах энэ 500 метрийн асуудал далд хэлбэрт орсноос болоод өнөөдөр буцаагаад нөгөө 21 нас хүрээгүй хүүхдэд тамхи ху худалдахгүй гэдэг тэр дүрэм журам чинь ерөөсөө хуучин хэрэгжихгүй болчихоод байгаа юм. Далд хэлбэрт орж байгаа учраас шууд л ерөөсөө ямар ч хяналт тавихгүйгээр 21 насыг шалгахгүйгээр шууд тамхиа худалдаад яваад байх ийм боломжтой болчихсон. Тэгээд энийг нь манай цагдаагийнхан амьдралд нийцээгүй хууль учраас цагдаагийнхан маш бага торгууль тавьдаг, маш бага зөрчлийн хэрэг энэ ард түмэндээ бас нэг жоохон ээлтэй хандаад ийм зүйл хийдэг.

Тэгээд энэ тал дээр бас цагдаагийн байгууллага ямар асуудал байгаа юм тэрэн дээр нь тодорхой 5 минут дээр нь хариулаад өгчхөөрэй. Тэгэх юм бол илүү үр дүнтэй байх гэж бодож байна. Тэгэхээр ер нь энэ асуудлыг шийдвэрлэх өнөөдөр технологийн боломжууд маш их бий болчихсон. И Монголиагаар дамжуулаад иргэдийн жишээ нь утсан дээр байгаа иргэний үнэмлэхээр нь шууд уншуулаад 21 наснаас дээш бол шууд тамхиа борлуулаад явах ийм боломжтой. 21-ээс доош бол ерөөсөө борлуулахгүй. Дээрээс нь хууль нь тэртээ тэргүй 21-ээс доош борлуулахгүй гээд ингээд заачихсан байж байхад тэр 100 метр байна уу, 150 метр байна уу ерөөсөө ялгаагүй байхгүй юу даа. Тэгээд ийм асуудал гарчхаж байна. Тэгэхээр ер нь Эрдэнэчимэг гишүүн бас тухайн үедээ зөв хууль гаргаж байсан байх.

Тэгэхдээ өнөөдрийн энэ амьдралын нөхцөл байдал дээр энэ хууль бүрэн хэрэгжихгүй байна аа. Өнөөдрийг хүртэл энэ хууль цагдаагийн байгууллага дээр ч тэр.

Н.Учрал: Тамхины хяналтын хуулиар энэ чинь 2018, 2019 онд билүү асуулга тавиад энэ орон зайнаас хамааруулаад нөгөө тамхины хяналтын хууль дээр чинь нэмэлт, өөрчлөлт оруулъя гээд. Энэ сургуулиуд чинь хоорондоо ойрхон. Тэгээд сургуулийн орон зайнаас ойрхон нөгөө тамхи зарахыг хориглочихсон ийм амьдралд хэрэгжихгүй заалт байна аа гээд асуулга тавьж байсан. Тэгээд Будзаан дарга хариулмаар байна. Тэгээд энэ хууль батлагдаад танай цагдаагийн байгууллага энэ хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллаж чадах уу? Одоо бид нар энэ нийгмийн энэ тахал болчихоод байгаа нөгөө цахим мөрийтэй тоглоомыг хориглох хуулийг парламент баталсан. Одоо тэгээд энэ цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг хориглохгоод байхад нөгөө бүх төрлийн ви пи эн ашиглаад тоглуулдаг тэгээд олон айл гэр бүлийг амьдралыг аваад явчихлаа шүү дээ.

Тэгээд хэрэгжүүлэх гэхээр яг хүн хүч боломж бололцоо тун тааруу байна аа л гэдэг ийм тайлбар өгдөг. Гэхдээ мэдээж ахиц дэвшил гарч байгаа. Би тэр статистик авсан. Тэгэхээр энэ хууль батлагдлаа гээд цагдаагийн байгууллага хуулийг хэрэгжүүлж чадах уу гэдэг дээрээ л яг үнэнээ л хэлэх хэрэгтэй.

Д.Будзаан: Та бүгдийн амрыг эрье. Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Би ЦЕГ-ын урьдчилан сэргийлэх албаны Хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга цагдаагийн дэд хурандаа Будзаан байна аа.

Тамхины хяналтын хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цагдаагийн байгууллага Зөрчлийн тухай хуульд зааснаар харьяалан шалгах зөрчлийн хүрээнд Тамхины хуулийн 6 дугаар зүйл худалдах үйлчлэхтэй холбоотой энэ харьяаллын зөрчлийг цагдаагийн байгууллага хянан шалгах үйл ажиллагааг явуулдаг. Үүний хүрээнд жилд бол цагдаагийн байгууллага 300-аас 500 орчим зөрчлийг илрүүлнэ. Иргэн ААНБ-д торгуулийн шийтгэл оногдуулах хэлбэрээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг ингэж илрүүлэн ажилладаг. Ийм зүйл байдаг аа.

500 метртэй холбоотойгоор хяналт шалгалт явуулахад 500 метрийн радиуст орсон дэлгүүр байгууллага энэ хууль ёсны бичиг баримт эрх олгогдоогүй байхад хууль бусаар лангуун доороосоо худалдаалдаг бас ийм зөрчлүүд бас илэрч шалгагддаг. Үүнийг бас цагдаагийн байгууллага илрүүлээд ингээд шалгадаг байж байгаа ажиллах хүн хүчний хувьд болохоор яг цагдаагийн байгууллага, төв, орон нутаг, нийслэлийн хэмжээнд 4 мянга орчим цагдаагийн албан хаагч сум дүүрэг, баг, хороон дээр бас үйл ажиллагаа явуулж цагдаагийн байгууллагын хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Нөгөө талаараа ААНБ ямар нэгэн байдлаар татвар төлөхгүй, хууль бусаар худалдаалагдаж ийм зөрчил бас илэрч байгааг нь энэ нийт зөрчлийн бас 50 орчим хувийг яг энэ 500 метртэй холбоотой зөрчил гарч шалгагдаж байгаа ийм зүйл байгаа. Танилцаж дууслаа.

Н.Учрал: Пүрэвдорж гишүүн тодруулъя. Номинчимэг гишүүн нэмж тайлбар хийнэ. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Бас хууль санаачлагчдын маань нэг болж дэмжиж ажиллаж байгаад маш их талархал илэрхийлье. Хүүхэд өсвөр үе энэ хуулийн маань гол зорилт бол хүүхэд өсвөр үеийнхнийхээ л тамхидалтыг бууруулах. Ингэж байж л бид нар нөгөө тамхины үеэ багасгах нийт иргэдийнхээ тамхидалтыг бууруулах хамгийн үр дүнтэй. Угаасаа сегмент бол хүүхэд өсвөр үе. Тэгэхээр энэ хуулийн яах вэ Эрдэнэчимэг гишүүн 2012 онд энэ хуулийг бас ахалж явж байхдаа яг л энэ зорилгоор сургууль орчин буюу хүүхдүүд их байдаг газар тамхины хүртээмжийг багасгах зорилгоор л энийг оруулсан юм байна лээ. Тэгээд энэ ч утгаараа бас манай хуулийн хувьд бол ялангуяа өсөн нэмэгдэж байгаа энэ тамхидалтын үе их ихсэж байгаа үед бол энэ дээр онцгой анхаарах ёстой гэдэг байр суурьтайгаар.

Тэгээд яг энэ дээр тэр электрон тамхи гэдэг бүтээгдэхүүн чинь тамхи гэж үзэгддэггүй болохоор 500 метр хамаагүй сургуулийн бараг үүдэнд зарагдаж байгаа. Энэ хуулийг харин баталснаар энэ электрон тамхинд ороод байгаа хүүхдүүдийн маань тэр хүртээмж бас багасна.

Н.Учрал: Энэ 500 метрээ бараг хөндөөд ороод ирэх байсан юм даа. Тэгээд 1 хэрэгждэггүй нэг заалттай. Будзаан бас үнэнээ хэлэх хэрэгтэй.

Пүрэвдорж гишүүн та бас хууль санаачлагч шүү дээ. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ер нь бол яг энэ хууль 2013 оны 3 сарын 1-ээс хойш хэрэгжсэнээс хойш энэ 500 метрийн асуудал жишээ нь хэрэгжсэнээс хойш хэдэн 100 сургууль, өргөтгөл, хэдэн 100 дотуур байр барьсан Монголын төр.

Тийм учраас яг энэ 500 метр дотор нөгөө иргэн ААН дэлгүүрээ ажиллуулаад явж байхад нь тэрний дараа тэр үл хөдлөх хөрөнгөө барьсны дараагаар нөгөө дотуур байр ойртоод ирж байгаа юм. Юу нь ойртоод ирж байгаа юм сургууль нь ойртоод ирж байгаа юм. Тэгэхээр өнөөдрийг хүртэл ерөөсөө худалдан авах болгондоо л тэр дэлгүүр хууль зөрчиж гэсэн үг байхгүй юу даа. Тэгэхээр энэ дөнгөж гурван зуухан 300-аас 500 зөрчлийн хэрэг нээж байна гэдэг чинь ерөөсөө амьдрал дээр хэрэгжихгүй байна гэсэн үг.

Тийм учраас энэ 500 метрийг 150 метр болгож бас огт хязгаар.

Н.Учрал: Пүрэвдорж гишүүн хууль санаачлагч байгаад байдаг. Асуултад хууль санаачлагчийг төлөөлж Лодойсамбуу гишүүн хариулна.

Ч.Лодойсамбуу: Сая Будзаан дарга бол маш тодорхой хэлж байна л даа. Ингээд 2012 онд хууль батлагдсанаас хойш жил болгон 300-аас 500 зөрчил.

Арван хэдэн жил жил болгон 300-аас 500 зөрчил гэдэг чинь энэ хууль хэрэгжихгүй байна гэсэн үг. Жил болгон 300-аас 500 газар очоод л торгууль бичээд л байж байдаг л гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ бол анх бүр батлагдсан цагаасаа хойш шүүмжлэл дагуулж байгаа. Энэ 500 метртэй холбоотой. Ер нь бол нэг 500 метр, 50 метрт хүн тамхи татахыг хараад эс үгүй бол тамхины дэлгүүр лангуун дээр тамхи байхыг хараад хүний сэдэл төрөөд тэгээд тамхи татдаг гэдэг бол зүгээр бид нарын өөрсдийн эцэг эхчүүдийн томчуудын төсөөлөл. Эрүүл гэр бүлээс эрүүл хүүхэд төрнө. Одоо жишээлбэл юу гэдэг юм тамхи хараад сэдэл нь төрдөг бол Монголын бүх хүүхэд тамхи татаж байгаа. Тамхи татдаггүй хүүхдүүд асар олон байгаа.

Тэгэхээр бид нар энэ хууль тогтоогчид бид нар өөрсдөө төсөөллөөрөө өөрсдийнхөө хүссэнээр биш бас сайн судалгаатай жоохон гүн агуулгатай бас асуудалд хандах хэрэгтэй гээд саяын Будзаан даргын асуудал дээр нэмж тайлбар хэлэхэд.

Н.Учрал: Хууль санаачлагч нар асуулт асуухыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар хориглосон байгаа шүү. 78 гишүүн асуулт асуухгүй. Үлдсэн гишүүд 78 гишүүнээс асууж болох ийм л хуультай. Дээрээс нь чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37.1, 37.2, 37.3-д заасан буюу энэ хэлэлцэх эсэхийг дэмжсэний дараа ажлын хэсэг байгуулна аа. Энэ үед ажлын хэсэгт хууль санаачлагч орохгүй. Энэ хууль шүү.

Тэгэхээр 78 гишүүний хэн ч энэ хуулийг ахлахгүй. Ажлын хэсэгт орохгүй. Үлдсэн гишүүд хэн нэг нь ахална. Ажлын хэсэгт орно. Ингээд олон нийтийн хэлэлцүүлгийг хийгээд хуулиа батлах ийм л хуультай. Тэгэхгүй одоо хэдүүлээ энэ чинь нэг хуулийн төсөл санаачилсан гээд гарын үсгээ зурчхаад үүнийг би мэдээгүй зурчихсан юм аа гэдэг ийм үйлдлүүд өнгөрсөн хугацаанд ажиглагдаж харагдаж байсан шүү. 78 гишүүн хуулиа санаачилсан юм бол 78-уулаа кнопдоод 78-уулаа хатуу итгэл үнэмшилтэй байгаад хуулиа баталцгаа. Хэрвээ итгэл үнэмшлээрээ энд

зурсан бол. Тэрнээс биш энд орж ирж нийгмийг ингээд төөрөгдүүлээд байх хэрэггүй шүү. Ингээд Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Анх удаа бас ийм олон гишүүн хууль санаачилж байгаа юм байна. Тэгэхээр үзэл баримтлалын хувьд дэмжиж байна. Харин яаралтай хэлэлцэнэ гэдэг дээр дэмжихгүй байгаа. Энэ хуулийг маш нухацтай хэлэлцэх шаардлагатай. Зарим хуулийг бид нар нэг жил 2 жил ингээд л алдаагүй л болох ёстой энэ хууль. Нэг зүйлийг бас Их Хурлын гишүүддээ хандаж л хэлмээр байна. Ажлын хэсгийн ахлагч болон гишүүдийг ямар нэгэн лоббид ордоггүй компанийн ашиг сонирхолгүй хүмүүсээр сонгох ёстой шүү Номинчимэг гишүүн ээ. Эндээс маш их алдаа гардаг. Тэгээд л чичирч байгаад л орчихдог. Ороод л нөгөө компанийнхаа юмыг л яриад байдаг. Өнгөрсөн парламентад хуурамч шатахууны тухай хууль орж ирэхэд Тэмүүлэн, Пүрэвдорж гишүүн бид 3 эсэргүүцээд дийлээгүй юм шүү дээ. Одоо улсаараа энэ хохирлыг нь амсаж байна. Ерөөсөө гишүүд бүгд лоббинд автчихсан. Тэгэхээр энэ Их Хурлын гишүүдэд их учир байдаг шүү гэдгийг хэлмээр байна.

Хоёр дахь асуудал бол энэ өнгөрсөн парламентад би энэ чихэр ихтэй ундаанд бас онцгой татвар ноогдуулах хуулийг батлуулж байсан, бас амаргүй л байсан. Гэхдээ энэ бол татвар цуглуулах биш эрүүл мэндийн хууль байсан энэ бол батлагдсан. Ингээд ямар нэг алдаа гаргахгүйн тулд 2026 онд бүх журам нөлөөллийн ажлуудыг хийгээд энэ хууль хэрэгжихээр ингэж жоохон тавиу тавьж өгсөн байгаа.

Тэгэхээр энэ бэлтгэл ажлыг бол бас хангах шаардлагатай байдаг аа. Нэг хууль гаргачихдаг журам дүрэм нь байдаггүй ингээд л баахан гацаадаг. Энэ 3.5 сая хүнээс яг тамхи татаж байгаа хүмүүсээ хасаад эндээс бага насны хүүхдүүдийг бас онцолж аваад ингээд нөлөөллийн ажлыг маш сайн хийх ёстой юм аа. Энэ бол тамхины татварын тухай хууль биш шүү. Тамхины хяналтын тухай хууль. Тэгэхээр яаж хяналтаа тавих вэ гэдэг дээр ямар үг үсэг орсон юм бэ гэдгийг тодорхой асуумаар байна.

Энэ Эрдэнэчимэг гишүүний хуулийн нэг чухал заалт юу байсан бэ гэхээр зөвхөн татварын хууль биш байсан. Яг тэр татдаг хүмүүс татдаггүй хүмүүсийн эрх ашгийг бүгдийг нь хангаж энийг бас их ухаалгаар зохицуулсандаа энэ хуулийн гол амин сүнс нь байгаа шүү дээ. Тамхины өрөөтэй болсон тэрнээс биш бүгдийг нь хориод ингээд яасан зүйл байхгүй. Тэгэхээр хяналтаа яаж тавих юм бэ? Батбаяр гишүүний би ярилцлагыг бас үзлээ санал нийлж байна. Тэр юу вэ гэхээр ийм автомат маш машин больж болдоггүй юм уу хурууны хээгээр. Ингээд энэ нь тэр и монголиадаа бүртгэгдээд хэт их донтоод байгаа хүмүүст бас нөлөөллийн ажил хийдэг. Энэ гар утсан дээр мэдээлэл ирдэг шүү дээ. Та хэтэрхий их гар утас оролдож байна гэдэг ч юм уу тэрэн шиг ийм энэ нэг хэдхэн хүндээ хэдхэн залуучууддаа ийм нөлөөллийн ажлыг хийх ийм зүйлүүд орсон уу гэдгийг асуумаар байна.

Тэгээд энэ сүүлийн 2 жил бас энэ онцгой татвар ер нь юунд зарцуулсан юм бэ гэдгийг ийг би бас Байнгын хороон дээр тусгайлан сонсьё оо гэж бодож байна. Нэг чухал зүйл асуумаар байна. Энэ бол энэ хууль дээр ангиллыг нь буруу хэрэглэсэн зүйл байна. Жишээлэхэд дэлхийн гаалийн байгууллагын ангилалд нийцүүлэх зайлшгүй шаардлагатай ийм зүйлийг ангиллыг нь буруу хэрэглэсэн зүйл байна аа.

Тийм учраас энэ асуудлыг хэрхэн анхаарч үзсэн юм бэ гэдгийг асууя. Ер нь бол энэ АНУ-ын Хүнс, эмийн агентлаг дээр гарсан бүтээгдэхүүний судалгаагаар

уламжлалт шатаадаг тамхитай харьцуулахад үлэмж бага хорт бодис агуулж байна аа гэсэн дүгнэлт гарсан байна аа гэж байна. Тэгэхээр хүмүүсийн болгоомжлол юу вэ гэхээр энэ тамхины чинь татварыг хэт их нэмчихээр хүмүүс буцаад нөгөө янжуур тамхи руугаа орчих юм биш юм уу? Янжуур тамхи руу чинь компанийн лобби гэж тэрийг л хэлээд байх шиг байна л даа. Тэгэхээр энэ үнийн зүйлээ та нэг бас тайлбарлаж өгнө үү гэж хүсэж байна.

Н.Учрал: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Одонтуяа гишүүнд баярлалаа. Бас энэ 2012 онд энэ сайн дэвшил авчирсан хуульд бас анхаарч энэ үед баталж байсан энэ өөрчлөлт шинэчлэлийг бас авчирсан хүмүүсийн нэг байгаа. Гишүүний асуусан тодорхой асуултад хариулъя гэж бодож байна. Ер нь бол хууль зөвхөн гаргаад байдаг юм уу үр дүн дангаараа хуулиар мэдээж гарахгүй. Яг таны хэлж байгаа шиг энэ нөлөөллийн ажил компани ажлыг маш сайн хийх ёстой юм байна лээ. Бид нар ТХСК-д 2005 онд нэгдэж орсон. Тэгээд түүнээс хойш нэг 4 жил тутамдаа энэ суурь конвенцын хэрэгжилттэй холбоотой энэ газраас бид нарт зөвлөмжүүдийг хүргэдэг. Тэгээд энэ дээр 2 юман дээр л Монгол Улс маш сайн анхаараач маш муу байна аа гэдэг зөвлөмжийг хамгийн сүүлд 2024 онд өгсөн.

Тэрний нэг нь болохоор ерөөсөө та бүхэн соён гэгээрүүлэх ажлаа орхигдуулсан байна аа. Хэвлэ олон нийтийн хэрэгслээр тамхины хор хөнөөлтэй холбоотой контент гарахгүй байна, соён гэгээрлийн ажил алдагдсан байна.

Хоёрдугаарт нийгмийн эрүүл мэндээ хамгаалах зорилгоор татварын бодлогоо ерөөсөө хэрэгжүүлж чадахгүй байна. Маш бага татвартай байна. Үүнийгээ хийгээч л гэдэг. 2 зөвлөмжийг энэ газраас ч, Дэлхийн банкнаас ч, Улсын Их Хурал ч гэсэн 2023 онд тогтоол гаргаж энийг бол уг нь чиглэл болгосон байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ хуультай дагаж орж ирж байгаа дагаж мөрдөх журмын тухай хуульдаа тодорхой байгууллагуудад, эрүүл мэндийн байгууллагуудад, боловсролын байгууллага, цагдаагийн байгууллагуудад энэ компани ажил соён гэгээрүүлэх ажил дээр онцгой анхаар. Мөн төрийн байгууллагуудын чиг үүргийг маш нарийвчилж оруулсан байгаа. Ялангуяа боловсролын байгууллага бол ерөнхий боловсролын сургууль дээр эрүүл мэндийн боловсролын хичээлийг оруулъя. Эндээ энэ хорт зуршлын талаар ойлгуулж хүүхдүүдээ эхнээс нь соён гэгээрүүлэх ажлаар энэ хорт зуршлаас сэргийлэх ажлыг хийе гэдэг асуудлыг бол оруулсан байгаа.

Хяналтын тухай мэдээж бид нарын хамгийн анхаарах асуудал байгаа. Хяналтыг өмнө нь 2012 онд МХЕГ гэж байсан. Мөн 2013 онд ЗГ-аас тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа аж үйлчилгээнд хяналт тавих журам гэж байгаа. Энийг хэрэгжүүлж явдаг. Тэгээд бид нар энэ дээр хяналт дээр хамгийн анхаарах ёстой юмны нэг бол ерөөсөө түрүүний хэлсэн тэр далд худалдааг байхгүйн төлөө хуулиа хэрэгжүүлэх асуудал дээр хүн хүч гаргаж харах ёстой. Дээр нь ер нь зохион байгуулалтын асуудлыг бид нар ялангуяа энэ эм, хүнс тамхи гэх мэт хүний эрүүл мэндэд шууд нөлөөтэй бүтээгдэхүүнүүд дээр яаж харах ёстой юм бэ гэдгийг бол дахиж нэг харах ёстой гэж харж байгаа юм. Энэ дээр бас Лүндэг гишүүн санаачлаад хууль Улсын Их Хуралд бас өргөн барьсан байгаа.

Ажлын хэсгийн гишүүдийг зөв байгуулах тал дээр би тантай 100 хувь санал нэг байна. Үнэхээр энэ асуудлыг үр хүүхдүүдийнхээ төлөө энэ асуудлыг цэгцлэх

ёстой гэдэг дээр л манай 78 гишүүн нэгдсэн гэж бодож байгаа. Энэ Номинчимэгийн асуудал биш энэ нийгмийн шаардлага дээр 78 гишүүн нэгдсэн. Ингээд энэ асуудлыг оруулаад хэлэлцүүлээд боловсруулаад явахад олон талын нөлөөлөл орох гэж их оролддог юм байна лээ би бас үнэнээ л хэлье. Тэгээд энэ сая улс төрийн нөхцөл байдлаас болоод хууль маань нэлээн бас хойшлогдлоо. Гэхдээ бид нар нямбай, чамбай бас энийг хэлэлцээд саналаа.

Н.Учрал: Номинчимэг гишүүн нэмэлт нэг минут.

О.Номинчимэг: Тусгаад авах ёстой гэдэг дээр санал нэг байна аа. Тэгээд таны сая дурдсан Батбаяр гишүүн маань манай ажлын хэсэгт бас анхнаасаа байсан. Гэхдээ үзэл санааны хувьд энэ 2 асуудлыг бас оруулахгүй бол нэгдэхгүй гэдэг байр сууриа илэрхийлээд бас ирсэн гишүүн байгаа. Тэрний нэг нь энэ автомат машины асуудал. Тэгээд автомат машины асуудлыг би Батбаяр гишүүнээс асуусан л даа. Яг үнэхээр хүүхэд залуучуудын тамхидалт буурахад нөлөөлдөг юм уу тооцоо судалгаанууд байна уу гэхээр чи ажлын хэсгийн ахлагчийн хувьд энийгээ өөрөө судал аа гэсэн. Би судалсан манай ажлын дэд хэсэгт байгаа мэргэжлийн хүмүүс ч гэсэн судалсан олон улсын судалгаа байна аа. Японд ч байна, Өмнөд Африкт ч байна. Нэг бол үр дүнгүй нэг бол ингэж өөр хүний цахим хаягаар ч гэдэг юм уу тэ. Энийг далд байдлаар дамжуулагч дундын тийм бизнесийн цэцэглэх ийм хор нөлөө гардаг аа. Үр дүнгүй байдаг шүү гэдэг олон судалгаа байна.

Тэгээд энэ асуудлыг ер нь зөвхөн Батбаяр гишүүн ч яриагүй. Энэ хууль дээр ажиллаж байхад 2, 3 улс төрч, улс төрд нөлөө бүхий этгээдүүд.

Н.Учрал: Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Энэ бол одоогоор манай хуульд хориотой байгаа асуудал юм. Бүр автомат машинаар худалдахыг хориглоно гээд одоогийн Тамхины хяналтын тухай хууль дээр Эрдэнэчимэг гишүүний ажилласан хууль дээр байдаг заалт. Тэгээд энийг хөндөөд оруулаад өгөөч гэдэг янз бүрийн асуудал тавьсан. Энийг оруулахгүй гэсэн. Энэ бол өөрөө хүртээмжийг сайжруулна. 24 цагийн турш намайг аваач гээд шилэн хоргонд байж байна. Хүүхдийн энэ авчихгүй гэдэг дээр хяналт нь үнэхээр үр дүнтэй байдаггүй гэдэг олон улсын судалгаа байгаа. Тэгээд би бол энийг үгүй гэсэн. Энийг үгүй гэснийхээ төлөө ерөнхийдөө бол бас энэ янз бүрийн төрлийн лоббичин гэдэг юм уу харлуулалт гүтгэлгүүд явж байгаа гэж бодож байгаа. Тэгээд энийг зарчмын байр суурийн хувьд бол оруулж болохгүй заалт юм аа л гэсэн байр суурьтай байгаа.

Гаалийн байгууллагатай холбоотой тэр кодын асуудал дээр манай гаалийн байгууллагаас бас нарийвчилсан мэдээллийг өгье. Мэргэжлийн байгууллага энэ дээр оролцоод гаалийн кодчиллын асуудал дээр бол дагаж орж ирж байгаа хуулиуд дээр оруулсан байгаа.

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулах уу? 3 дугаар микрофон.

Ч.Чимгэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Монгол Улс дэлхийн гаалийн байгууллагад 1993 онд элсэж орсон үүнтэй зэрэгцээд барааг тодорхойлох кодлох уялдуулсан ийм олон улсын конвенцод

нэгдэж орсон. Энэ конвенцын хүрээнд дэлхий дээр худалдаалагдаж байгаа бүх бараа энэ ангиллын кодын дагуу кодлогдож гаалийн байгууллагад мэдээлэл бүртгэлээр орж гадаад худалдааны статистик мэдээ гаргаж байгаа. Тамхин бүтээгдэхүүний хувьд бол энэ 24 дүгээр бүлэгт ангилагддаг. Энэ конвенцод бол 4-5 жил тутамд нэмэлт, өөрчлөлт ордог. Тэгэхээр одоогийн бид нарын мөрдөж байгаа конвенцын 7 дахь нэмэлт, өөрчлөлт дээр тамхин бүтээгдэхүүн дээр нэлээн том өөрчлөлт задаргаа оруулж өгсөн. Үүний нэг нь асаахгүйгээр сорж татах зориулалттай тамхины ангиллыг нэмж оруулж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл уламжлалт тамхинаас галаар асаадаг.

Н.Учрал: Ажлын хэсэг 3 дугаар микрофон. Ажлын хэсгээс нэмж хариульа 3 дугаар микрофон.

Ч.Чимгэрэл: Асаахгүйгээр сорж татах зориулалттай. Бид нарын өнөөдөр хэрэглээд байгаа нэлээн брэндэд тодорхойлсон акос гэдэг тамхины ангиллын кодыг бол дэлхийн гаалийн байгууллагаас оруулж өгсөн. Энэ дээр нь Монголын гаалийн байгууллага үндэсний задаргаа хийж өгөөд цахилгаанаар яг халаах хэрэгслээр татах зориулалттай ангиллын кодыг бол яг тэр 24041110 гэдэг код дээр нь бид нар бас тавьж өгсөн байгаа. Мөн энэ тамхин дотор бол энэ цахилгаан хэрэгсэл дээр өөрөө янжуур тамхитай адилтгах яг тамхины ургамлаар хийсэн нягтруулсан ийм жижиг жижиг хэмжээтэй тамхи орж явдаг. Тэгэхээр энэ өөрөө тамхин бүтээгдэхүүн янжууртай адилтгах тамхин бүтээгдэхүүн гэж ангиллын кодоороо явж байгаа. Тийм болохоор бид ямар нэгэн Дэлхийн гаалийн байгууллагын конвенцоос зөрчсөн ийм код бол байхгүй.

Н.Учрал: Ажлын хэсэг нэмэлт минут өгье 3 дугаар микрофон.

Ч.Чимгэрэл: Тамхины хяналтын тухай хуульд бол Монгол Улсын тамхины хяналтын хууль зохицуулагдаагүй шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний ангиллыг бид нар оруулж өгсөн. Үүнд бол мэдээж электрон тамхи байгаа. Та бүхэнд ард түмэн сэтгэгдэл төөрөгдлүүд байна. Энийг электрон бараа байна гэж үзээд асуудал тавиад бас нэлээдгүй сошиалаар явж байгаа. Энийг бас энэ ташрамд бас танилцуульа гэж бодож байна. Энэ электрон тамхи өөрөө цахилгаанаас цэнэг авч ажилладаг тамхин бүтээгдэхүүн. Энэ дотроо никотинтой болон никотингүй гэж бас 2 янз байгаа.

Тэгэхээр түрүүн хэлсэн дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан Беткусийн конвенц олон улсын конвенц дээр энэ цахилгаанаар ажиллаж хэрэглэдгийг нь цахилгаан бараа гэж үзээд нэг удаагийн хэрэглээтэй буюу 800 удаагийн соролттой 20 мянган удаагийн соролттой цэнэг авч ашигладаггүй нэг удаагийнхыг нь болохоор тамхин бүтээгдэхүүн гэж ангилсан. Ингээд тамхины хяналтын тухай.

Н.Учрал: Энэ тамхины хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь юу юм бэ хэн энэ тамхины хяналтыг хэрэгжүүлэх юм бэ гээд байгаа юм. Тамхины хяналтын энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр эрүүл мэндийн асуудал эрхэлж байгаа төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлж байгаа төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн асуудал эрхэлж байгаа төрийн захиргааны төв байгууллагын чиг үүргийг хуульчилсан. Гэхдээ тамхины хяналтыг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чиг үүрэг гээд 4 заалт байгаа. Тэрийг яг ямар байгууллагыг хэлээд байгаа вэ гэдгийг бас бид нар ойлгуулах хэрэгтэй юм шиг байгаа юм. Энэ

Засгийн газар ч гэсэн бас энэ талаараа сайн мэдээлэлтэй байж явахгүй бол цаашаа нөгөө хяналт хэрэгжүүлэхэд хэн хэрэгжүүлэх нь бас тодорхойгүй болно оо.

Тэгэхээр Одонтуяа гишүүн бол энэ хяналт хэрэгжүүлэх байгууллагыг хяналтаа яаж авч явах вэ гэж асуугаад байна шүү дээ. Болдын Уянга гишүүн хууль санаачлагч, хариулах уу асуух уу?

Б.Уянга: Энэ хуулийг дэмжиж гарын үсэг хуулийн төслийг дэмжиж гарын үсэг зурсан. Тэгээд шалтгаанаа хэлээд бас тодруулаад нэг мэдээллийг гишүүдэд нийгэмд бас хүргээсэй гэсэн үүднээс асуулт асууя. Тэгээд түрүүн бас Лодойсамбуу гишүүн хэллээ л дээ. Нөгөө эрүүл гэр бүлээс эрүүл хүүхэд нийгэмд бэлтгэгдэж гарна аа гээд. Тэгээд яг өөрөө өсвөр насны хүүхэдтэй яг тэр өсвөр насныхны тэр хийж байгаа дадал зуршилд нь нэлээн тийм соргог ханддаг хүний хувьд гэр бүлээсээ нэг хүмүүжил аваад бас найз нөхдөөсөө аваад байна. Тэгээд зүгээр ингээд дам дам сонсоод ингээд харж байхад болохоор энэ электрон тамхийг сурагчид ингээд гуялж гэж ярьдаг мөнгөө нийлүүлээд тав зургаагаараа авдаг юм байна. Тэгээд тэрийгээ ингээд хувааж татаад байдаг. Тэгээд одоо яг энэ тамхины энэ хууль дээр ч гэсэндээ бичсэн байгаагаар бол электрон тамхи хэрэглэдэг өсвөр насны хүүхдийн дунд судалгаа хийнгүүт сэтгэл гутрал байна, анхаарал нь төвлөрөхгүй байна, ой тогтоолт нь муудаад байна өөрийгөө хянаж чадахгүй байна аа гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр өсвөр насныханд энэ мэдээллийг л тэр түрүүний Номинчимэг гишүүний хэлснээр соён гэгээрүүлэх ажлыг л илүү хийж өгөх ёстой юм шиг байгаа юм. Тэгээд өнөөдөр очоод хэллээ маргааш тэр муу дадал зуршил нь солигдчихно гэсэн үг биш байх. Нэг тийм үе шаттай ажил хийгдэх ёстой. Тэгээд одоо яах вэ зүгээр ингээд гишүүдийнхээ асууж байгаа асуулт хариулж байгаа хариултуудыг сонсох нь яах вэ ингээд татвар нь нэмэгдчихээр мэдээж электрон тамхины үнэ өсчихнө. Тэгэнгүүт 5, 6 сурагчид нийлээд нэг электрон тамхийг авдаг байсан бол 10 сурагч нийлээд л авчих байх. Тэгэхээр энэ дадал зуршил гээд бие биеийн үе тэнгийнхэн хоорондоо нөлөөлж байгаа энэ байдалд нь яаж интервенц хийх ёстой юм бол? Энэ дээр нь үе шаттай арга хэмжээг Улсын Их Хурал дээрээс бол хуулийн хэрэгжилтийг нь хянана. Засгийн газар болохоор яг газар дээр нь бүх асуудлуудыг нь зохион байгуулах байх. Тэгэхээр дагаад эсвэл тийм үүрэгжүүлсэн Улсын Их Хурлын тогтоол орох ёстой юу? Өөр бас нэг ийм мэдээлэл байгаа байхгүй юу. Тамхинаас шалтгаалсан нас баралт жилд 4300 байна аа гээд. Зүгээр жижиг, дунд нэг сумыг Монгол Улсад байгаа сумын жишээгээр авах юм бол 2 сумын 2 мянган хүнтэй сум дундаж гэж үзэх юм бол 2 сумын хүн ам тэр чигтээ л нэг жилд тамхинаас үүдэлтэйгээр нас барж байна аа гэсэн үг. Тэгэхээр хэн ч хүүхэдтэй бид нар бүгдээрээ л үр хүүхэдтэй. Үр хүүхдийнхээ ирээдүйд ийм зүйлийг хүсэхгүй байгаа учраас энэ хуулийг дэмжиж зурсан байгаа гэдгийгээ хэлмээр байна. Тэгээд түрүүн бас гаалийнхан, тэгээд цагдаагийнханы төлөөлөл, ажлын хэсэгт орсон хүмүүс хариулж байх байдлыг ингээд харахаар ажлаа хийгээд байна болоод байна. Тэр гаалийн кодуудыг нь хийгээд байна л гээд байгаа юм. Тэгсэн мөртөө энэ зөвшөөрөлгүй тамхины далд худал даа Тамхины хяналтын тухай хуулийн зөрчлийн 83.3 хувийг эзэлж байна аа гээд. Энэ бүх гишүүдийн ширээн дээр ирсэн тамхигүй маргаашийн төлөө ТББ-ын энэ дүгнэлт дээр бичээд ирчихсэн байгаа байхгүй юу. Тэгээд эд нарын энэ ТББ-ын хэлж байгаа нь далд худалдаа нь илүү гаарч байна шүү дээ. Татвар нь их болчихсон юм чинь гээд тэгээд байгаа юм.

Тэгэхээр одоо яг энэ судалгаагаар 83.3 хувь нь Тамхины хяналтын тухай хуулийн зөрчил нь зөвшөөрөлгүй далд худалдаа гэдэг бол ерөөсөө хууль хэрэгжиж

чадаагүй. Тэгэхээр энд бас хариуцлага тооцвол яасан юм. Тэгээд энэ гаалийнханд хариуцлага тооцох хэрэгтэй шүү дээ. Яаж чадаж байна аа, яаж энэ үр хүүхдүүдийн ирээдүйг ингэж баллаж чадаж байгаа юм, цагдаагийнхан ч адилхан. Тэгэхээр энэ дээр хариуцлагыг тогтоочоод дараа нь чангалаад явбал зүгээр юм шиг. Тэгээд Номинчимэг гишүүнийг төгсгөлд нь нэг зүйлийг тодорхой хэлээд өгөөч гэж байгаа юм. Улсын төсөв бид нар саяхан ярьсан. Орлого бол бид нар нэмэгдүүлж чадахгүй алдагдалтай л төсөв батлаад яваад байна. Тэгвэл энэ татварыг тамхины энэ хортой зүйлийн татварыг нэмснээрээ бид нар яг хэчнээн тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт нэмж төвлөрүүлэх юм. Энэ бас хэрэгтэй мэдээлэл байх байх. Энийг бас тод хэлээд өгнө үү гэж хүсье ээ.

Н.Учрал: Яг ингэж нийгмийг соён гэгээрүүлж нийгэмд ойлголт өгөх чиглэлээр хууль санаачлагч нар нэмэлт мэдээллийг ийм хэлбэрээр асууж болох нь байна шүү. Уянга гишүүний асуултад Номинчимэг гишүүн хариулна. Тэр тодорхой мэдээллийг өгье өө.

О.Номинчимэг: Уянга гишүүндээ баярлалаа. Асуултад хариулья.

Тэгээд энэ хуулийн зорилт түрүүн Одонтуяа гишүүн ч гэсэн дурдсан. Ерөөсөө татвар авахдаа зорилго нь биш. Энэ хуулийн гол зорилго хүүхэд өсвөр үеийнхнийхээ тамхидалтыг бууруулах, тамхидалтаас хамгаалах зорилготой. Тэгээд тэрний хүрээнд л хийж байгаа зохицуулалтын болон эдийн засгийн 2 арга хэрэгслийн нэг нь л энэ татвар байгаа юм. Тэгэхээр энэ бол бид нарын Уянга гишүүн ч гэсэн ээж хүний хувьд бас санаа зовж энэ асуудлуудад хандаж байна. Бид бүхэн ч гэсэн мэргэжлийн байгууллагуудтай ажиллахад хуулиас гадна соён гэгээрүүлэх ажил маш чухал гэдгийг хаа хаанаа бүгд ойлгож байгаа. Энэ дээр ч гэсэн төрийн байгууллагууд өөр өөрийн чиглэлээрээ бас хамтарч бол нэлээн хүч нэгтэйгээр ажиллах шаардлага бол үүсэж байгаа гэдгийг бас хэлмээр байна. Өнөөгийн нөхцөл байдал яагаад үүсчихсэн байна аа гэхээр бид нар энэ электрон тамхи гэдэг юм уу шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн тэр зажилдаг энээ тэрээ гээд олон бүтээгдэхүүн Монгол Улсад орж ирсэн боловч ямар ч хуулийн зохицуулалт байхгүй байгаад байгаа. Бусад бараатай яг л адилхан гаднаас орж ирдэг чихэр жимстэй яг л адилхан тооцогдож байгаа гэсэн үг. Хуулийн зохицуулалт байхгүй байхаар хаа дуртай газраа зарж байна, сургууль орчим зарж байна, үсчин зарж байна, байрны подвалд зарж байна, зөвшөөрөлгүй. Ямар ч хуулийн зохицуулалт байхгүй байгаа болохоороо 71 иргэн ААН өөрсдөө дураараа олж ирж байна. Ямар ч зохицуулалт байхгүй байгаа болохоор маркетинг буюу цахим орчинд энийг сурталчлах бүх зүйл явж байна. Нөгөө тамхины хяналтын хуулиар 2012 онд баталсан чинь энэ тамхийг чинь онлайнаар зарж болохгүй зар сурталчилгаа нь хязгаартай гээд энэ бүх юмуудууд электрон тамхи гэдэг энэ хүүхэд рүү татаад байгаа юм бол бүх зохицуулалттай. Ямар ч зохицуулалтгүй байсан учраас бүгд задгай явсаар ийм үр дүнд хүрсэн.

Тэгэхээр эхний ээлжид бид нар энийгээ бас нэг зохицуулалтын аргаар аваад бусад тамхин бүтээгдэхүүнтэй адилхан байлгаад өгье өө.

Хоёр дахь асуудал бол энэ татвар байгаа. Татвар бол ердөө бид нар илүү янжуур тамхин дээр бас анхаарах ёстой. Үнэхээр талхнаас хямдхан янжуур тамхитай улсын хувьд тамхидалт өөрөө өсөхөөс өөр аргагүй. Үнэхээр хүртээмж ихэссэн байна. Үүн дээрээ анхаарч байгаа. Тэгээд энэ татварын асуудал бол ерөөсөө төсөв бүрдүүлэх зорилго ерөөсөө байхгүй. Онцгой албан татвар буюу нүглийн татварыг ерөөсөө хэрэглээ бууруулахтай л холбоотой тавьдаг. Тэгээд энийг

бол бид нар төсөв бүрдүүлэх гэж байгаа гэхээсээ аваад тамхитай тэмцэнэ. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нь заръя аа. Хүүхдүүдийнхээ ЕБС-ийн хүүхдүүдийн шим тэжээлтэй хоол ундаар хангахад нь зарцуулъя аа. Одоо бага ангийн хүүхдүүдээ өгч байгаа. Дунд, ахлах ангийнхныгаа хаячихсан байгаа.

Гуравдугаарт нь донтолттой, хорт зуршилтай тэмцэх үүнийг үүсгэхгүй байх хамгийн үр дүнтэй арга бол чөлөөт цагаа зөв өнгөрөөх спорт. Бид нар хүүхдүүдийнхээ спортын сургуулийн спортынх нь газрыг авчихсан, хүүхдийн тоглоомын талбайг нь авчхаад хүүхдүүдээ зөв хүмүүжүүлж зөв өсгөнө гэж яаж хэлж чадах юм бэ. Энэ мөнгөө тэгэхээр спортын дугуйлан хүртээмж барилга байгууламжийнх нь хүртээмжид зарцуулъя аа л гэсэн ийм зорилттой орж ирж байгаа юм. Үнийн дүнгийн хувьд мэдээж энэ дээр Татварын газрынхан болон Сангийн яамныхан тооцоолол хийсэн байгаа байх. Гэхдээ энэ бол төсөв бүрдүүлэх ямар ч зорилгогүй шүү гэдгийг бас.

Н.Учрал: Баярлалаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Тэгээд энэ хуулийг дэмжиж байгаа. Манай санаачлагч Номинчимэг гишүүн бас зориг гаргаж энэ асуудлыг бас сөхөж хуулийн төсөл боловсруулж өнөөдөр ингээд хэлэлцүүлэг эхэлж байна. Тэгээд энэ болох замд ер нь олон ч юм туулсан байх. Нэлээдгүй л гүтгэлийн чанартай янз янзын мэдээ мэдээллүүд ингээд л яваад л. Тэгээд энэ цаагуураа юу гэж байна гэхээр энэ тамхины энэ бизнесийг ямар нэгэн байдлаар хөндөх гэдэг бол олон хүний эрх ашиг хөндөгддөг юм байна. Тэнд бас их ч мөнгө явдаг юм шиг байгаа юм. Гэхдээ энэ удаагийн парламент бол энэ тамхины хууль дээр өөрчлөлт хийх нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа юм. Тэгээд яагаад гэвэл энэ тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлснээр энэ үдийн хоол, энэ спорт танхим, тэгээд ялангуяа тэр нийгмийн эрүүл мин хүндийн тал руугаа анхаарна аа гэдэг дээр би маш сайн анхаарч байгаа дэмжиж байгаа юм.

Нөгөө талдаа энэ хуулийн танилцуулгыг ингээд сонсоод үзэхээр Монгол шиг энэ тамхин диваажин шиг ийм улс энэ дэлхийд байхгүй л юм байна л даа. Тэгээд нөгөө моод Монголоор дуусдаг гэдэг шиг ер нь энэ дэлхийн улс орнуудаас Африкийн нэг хэдэн улс, Латин Америкийн хэдэн улсын арай л нэг ард нь орчихгүйхэн шиг яг ингээд хуулиа хэлэлцэж эхлэх гэж байна гэж ингэж харж байгаа юм. Тэгээд утаат тамхи болон энэ ялангуяа шинэ төрлийн энэ тамхины хэрэглээ ямархуу түвшинд байгаа вэ гэдгийг ялангуяа манай энэ орон нутгийн засаг захиргааны нэгжийг удирдаж байгаа шат шатын Засаг дарга нар бол маш сайн ойлгож байгаа.

Тийм ч учраас янз янзын захирамж тушаал гаргаад л шүүх дээр дуудагдаад л ингээд л амжилттай болж өгөхгүй байсан. Тэгээд харин энэ хуулиар бол би нэлээн давгүй өөрчлөлт орчих юм байна аа гэж ингэж бас харж байгаа. Нөгөө талдаа энэ хууль бол сая ч ярьж байна. Татвар биш нийгмийн сайн сайхны төлөө хийж байгаа хууль аа л гэж ингэж би ойлгож байгаа. Тэгэхээр энийг яах вэ мушгихын тулд тамхи үнэ нь тэд болох нь гэдэг нэг ийм юм яригдаад байгаа юм. Гэхдээ үүний цаана энэ бидний нүдэн дээр л болж байгаа үйл явц шүү дээ. Хэдүүлээ ямар хаа сайгүй л байна. Тамхины энэ випийн хэрэглээ ямархуу түвшинд оччихоод байгаа вэ гэдэг нь хэний ч нүдэн дээр ил.

Тэгэхээр энэ хуулийг ингээд батлах нь зүйтэй гэдэг дээр би санал 1-тэй байгаа юм. Нөгөө талдаа яг яг энэ вип үйлдвэрлэдэг улсууд чинь нь яг дотооддоо энийгээ хэрэглэдэггүй юм байна лээ шүү дээ. Дотооддоо хэрэглэхгүй гадагшаагаа зардаг. Энэ бол бас нэг юмны л дохио болов уу гэж би бас дотроо боддог юм. Яг амьдрал дээр ингээд харьцуулаад харахаар.

Ингэхээр яах вэ миний нэг асуух гээд байгаа зүйл бол аливаа хууль амьдралд нийцэх ёстой. Тамхины хуулийн хэрэгжилт зарим нэг тал дээрээ сайн, зарим нэг тал дээрээ тааруу явж байгаа гээд ингээд сая Пүрэвдорж гишүүн олон гишүүд хэлж байна. Тэгэхээр энэ хууль маань ч гэсэн нөгөө нэг Монголын хууль 3 хоног гэдэг шиг батлагдаад нэг хэдэн сар хэртэй нэг ингээд нэг байж байгаад эргээд нэг бахь байдагтаа оччихгүйн тулд энэ хяналт хэрэгтэй байх. Нөгөө талдаа эдийн засгийн нэг том хөшүүрэг хэрэглэх гээд байх шиг байна. Ер нь Монголчууд чинь энэ тамхины үнэ дээр их эмзэг ханддаг шүү дээ. Ямар сайндаа жаахан ядруухан яваагаа тамхины ч мөнгөгүй л явж байна даа гэж ярьдаг ард түмэн л дээ.

Гэтэл яг энэ тамхинаас гаргах энэ тал дээр энэ тамхины үнийн бодлого дээр манайх үргэлж тийм диваажин шиг маш хямдхан явж ирсэн ийм л юм билээ.

Тэгэхээр энийг ингээд нэг өөрчлөөд энэ нэг тамхины хамааралтай зүрх судас энэ олон юмнуудаас би нэг сэргийлж чадах болов уу багасах болов уу гэж бодож байгаа юм. Ямар ч архаг тамхичин тамхинаас гарах юм сан гэж боддог нэг ийм сэтгэл зүй байдаг. Тэрэн дээр нь их том дохио өгөх болов уу гэж ингэж бас би бодоод байгаа юм.

Тэгэхээр би энэ цагдаагийн байгууллагаас Монголын хууль 3 хоног болгохгүйн тулд одоо энэ мөр өргөн барьсан хуулийн төсөл дээр байгаа, одоо мөрдөгдөж байгаа хууль дээр байгаа энэ хяналт шалгалтын энэ процесс ер нь илүү сайжирч чадах уу? Гол нь л энэ шүү дээ ер нь.

Тэгэхээр энэ дээр би асуух гэж байгаа юм 1 дүгээрт цагдаагийн байгууллага хариултаа өг.

Хоёрдугаарт үдийн хоол зарим гишүүд бол бага ангид биш бүүр ингээд бүх 12 дугаар ангидаа ч гэсэн үдийн хоол өгдөг болъё гэдэг энэ дээр ямар ахиц дэвшил гарна гэж ингэж тооцож байгаа юм? Тэр спорт танхим юмнууд дээр ер нь ямархуу дэвшил гарна гэж тооцож байгаа юм. Хамгийн гол.

Н.Учрал: Цагдаагийн байгууллагаас хариулах уу Будзаан хурандаа. 4 дүгээр микрофон.

Д.Будзаан: Таны асуултад хариулья аа.

Цагдаагийн байгууллагаас бол яг Тамхины хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хяналт шалгалтыг төв, орон нутаг, сум дүүргийн хэмжээнд нэлээдгүй зохион байгуулдаг. Үүний үр дүнгээр жилд 300-аас 550 орчим зөрчил илрүүлнэ. 15-40 сая төгрөгийн торгуулийг иргэн ААНБ-д хүргэж ажилладаг.

Хоёрдугаарт энэ электрон тамхины эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас яг энэ дээр нөгөө нэг хяналт тавих, торгууль оногдуулах, хариуцлага тооцох, хурааж авах энэ зүйл нь бас байхгүй байгаа. Ийм зүйл байгаа. Хяналт шалгалттай

холбоотой дараагийн зүйл бол 500 метрийн л асуудал. Энд одоо жишээ нь нөгөө нэг Энх тайвны өргөн чөлөө хот суурин газар шинэ суурьшлын бүс төлөвлөлт сургууль дотуур байртай холбоотойгоор яг жишээ нь нөгөө нэг үйл ажиллагаа эхэлчихсэн байж байдаг. Үүний дараа нөгөө нэг хэрэглэгч нь ирчихсэн байж байдаг. Үүний дараа сургууль, цэцэрлэг баригддаг. Тэгэнгүүт холбогдох байгууллагаас үйлчилгээг нь хүчингүй болгодог, дахин сунгадаггүй, эрх олгодоггүй. Тэгээд нөгөө хуулийн иргэн хуулийн этгээд хууль бусаар худалдаалах ийм асуудал үүсдэг ээ.

Тэгээд энэ дээр бас нөгөө нэг цагдаагийн байгууллагаас яг нөгөө нэг хяналт шалгалтын ажлуудыг зохион байгуулаад явдаг байж байгаа. Танилцуулж дууслаа.

Н.Учрал: Тэгээд энэ Будзаан дарга та бид нар чинь 2018, 2019 онд биз дээ энэ 500 метрийг 250 метр болгоё гээд нэг хууль санаачлаад. Би нэг явж байсан. Тэгээд яг дүүрэг орон нутагт бол тэр 500 метр гэдэг заалт чинь хэрэгжихгүй ээ, хичээл сургууль, дотуур байр, сургуулийн 500 метр орчимд тамхи зарахгүй гэдэг энэ заалтыг хэрэгжүүлэх гэж манай цагдаа нар үйлээ үзэж байгаа тийм биз. Тэгээд ингээд далд эдийн засаг бий болдог. Тэгээд 1 мөр энэ асуудлуудаа шийдээд авмаар байгаа юм. Ер нь бол. Тэгэхээр цаашдаа энэ хуулийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл байх вэ? 4 дүгээр микрофон.

Д.Будзаан: Хөдөө суурин газар дээр болохоор сургууль, сумын захиргаа ойролцоо 100, 200, 300 метрийн зайтай байдаг. Тухайн радиуст болохоор 1-ээс 2 л дэлгүүр байдаг. Тэгэхээр тухайн сум дээр бас жишээ нь яг энэ 500 метрийн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх. Хууль бусаар бичиг баримтгүй зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа аж ААН иргэн иргэн болохоор өсвөр насны хүүхдүүдэд ямар нэгэн хяналтгүйгээр худалддаг байж болзошгүй ийм зүйлүүд байдаг аа. Энэ ч бас зөрчлөөр илрээд шалгагдаад явдаг байж байгаа.

Н.Учрал: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн. Тэр 500 метрийг шууд хөндөж болох байсан уу? Тийм. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Идэрбат гишүүний бас хөндсөн асуудалд нэмэлт мэдээлэл өгье гэж бодож байна. Тэгээд энэ гишүүнтэй санал нэг байгаа. Энэ асуудлаа бид нар өсвөр үеийнхнийгээ хамгаалахын тулд одоо л хөдлөхгүй бол хожимдох гээд байна аа. Ингэж байж бид нар хойч үеэ хамгаална гэж бодож байгаа. Тэгээд Монгол Улсад орж ирж байгаа энэ электрон тамхины зах зээлийг харах юм бол ердөө л 95-аас 98 хувь нь БНХАУ, Хонконг улсаас орж ирдэг. Дан ялангуяа зөвхөн экспортод зориулсан Шинжианы тусгай бүсэд байдаг 10 үйлдвэрээс энэ зах зээлийн 84 хувь нь орж ирдэг юм байна лээ. Тэгээд БНХАУ болохоор эдгээр бүтээгдэхүүнийг дотроо хорьчихсон, зөвхөн тамхины амттай л веб байж болно оо гээд. Хонконг бол бүрэн хорьчихсон.

Тэгэхээр бусад улсад зориулж үйлдвэрлэдэг ийм чанар муутай янз бүрийн тос агуулсан ийм бүтээгдэхүүнүүд ороод ирж байгаа. Тэгээд ийм Хятадын 10 компанийн эрх ашгийн төлөө бид нар, Монголын хойч үе, хүүхдүүд ямар өртэй гэж бид нар ингэж харж суух юм. Энийг даруй бид нар зохицуулах ёстой гэсэн энэ л байдлаар бол.

Н.Учрал: Идэрбат гишүүн тодруулж асууна.

Ц.Идэрбат: Тийм яг амьдрал дээр наад 500 чинь их зовлонтой л доо. Би өөрөө сумын даргаар ажиллаж байсан хүн. Тэгээд л яг тэр радиуст нь орчхоод л өгөх ч хэцүү, байх ч хэцүү. Бүр жижиг суманд бүр сүүлдээ тамхи зарахгүй ч юм шиг эд нар юм руугаа ороод байдаг нэг ийм зовлон байгаа юм. Тэгэхээр аливаа хууль хорьж цагдах нь сайн юм шиг харагдав чиг амьдралд хэрэгжих нь чухал. Тэгээд энэнээс болоод бүх тамхи лангуун доогуур орчихсон шүү дээ. Би цагдаагийн алба хаагчдаас хэрвээ энэ электрон тамхины юм орж ирээд лангуун доогуур дахиад нөгөө веп чинь ороод явчихвал яах вэ л гэж асуугаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хяналт шалгалт дээр сайжруулахад одоо байгаа хуулийг мөрдөхөд ямар хүндрэлүүд гараад байгаа юм, тэрийг яаж засах вэ гэдэг том бололцоог хуулийн байгууллага яаж ашигласан бэ л гэдэг юм би асууж байгаа юм. Нөгөө талдаа ЭМД-ын сан руу оруулна гээд тэр сан маань их сайн нэргүй байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ тамхинаас орсон онцгой албан татварын мөнгийг яг тэр тамхины эсрэг болон тамхинаас гарах сонирхолтой тэр хүмүүс рүүгээ чиглүүлэх хууль эрх зүйн бололцоо байгаа юу гэж асуух гэж байгаа юм.

Н.Учрал: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Д.Будзаан: Таны асуултад хариулъя. 500 метрийн асуудал бол яг жишээ нь энэ хуулийг хэрэгжүүлэхэд хууль бус зөвшөөрөлгүй худалдаа явуулах бас нэг л бусад гол заалтын нэг болж байгаа ийм зүйл байгаа. Одоо жишээ нь электрон тамхийг энэ хуульд тамхинд тооцоод худалдаалахад магадгүй 500 метрийг хөндөхгүй үлдээлээ гэхэд маргааш бас л лангуун доогуур орох хууль бус худалдаа болох, өсвөр насны хүүхдүүдэд худалдах. Бид нар цагдаагийн байгууллагаас яг энэ хяналт шалгалт бас л үр нөлөөгүй болгох эргээд л жилд нэг 300-аас 500 зөрчилд торгуулийн арга хэмжээ авч байна аа гээд эргээд ийм тайлантай сууж байх л эрсдэл байгаа юм аа. Тэгэхээр хууль тогтоомжийг тэр 500 метр байлаа гээд тэр хүн тамхинаас гарчих асуудал биш. Үүн дээр нь бас яг нөгөө нэг тухайн нөхцөл байдал, хот суурин газрын бас нөгөө нэг хүн амын төвлөрөлтэй уялдуулан бас энэхүү бас нэмэлт, өөрчлөлтийг харж.

Н.Учрал: Маш чухал хариулт хэллээ шүү. Номинчимэг гишүүн та нэмэлт тодруулга Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: 500 метртэй холбоотой судалгааг бид нар бас нийслэл дээр хийж ингээд бүх график зургийг нь гаргаж авсан юм аа. Радиусыг нь тавиад ингээд үзэхээр яах вэ хотын төвийн энэ барилгажилт ихтэй газруудад үнэхээр 500 метр байхгүй. Хотын захаар болбол хангалттай бол ийм зайнууд бол байгаа. Энэ дээр мэдээж хууль хэрэгжилт дээр алдаатай байгаа юмнууд байгаа. Тэгээд бид нар цааш нь энэ хуулийг бас хэлэлцээд явахад хууль нь сул байна хэрэгжихгүй байна гээд хуулиа сулруулах гэхээсээ илүү яаж хэрэгжилтийг нь сайжруулах вэ гэдэг талаас ч гэсэн бас хармаар юм шиг байгаа юм. Тэгэхгүй бол хууль хэрэгжихгүй байна аа гээд юу гэдэг юм хар тамхи Монгол Улсад хориглочихсон. Гэхдээ орж ирээд байна наад хууль чинь хэрэгжихгүй байна. Тийм юм чинь хуулиа сулруулаад оруулдаг больё оо гэдэг логик байж болохгүй.

Тэгэхээр энийг бас илүү сайн олон талаас нь хэлэлцэж шийдвэрлэх ёстой л гэсэн асууд байр суурьтай байна.

Н.Учрал: Номинчимэг гишүүн ээ энэ хөдөө орон нутагт их өөр юм байна лээ. Тэгээд энэ их өөр шүү. Тэгээд зарим суманд бол сургууль соёл дотуур байр юун 500 метр. Тэгээд энэ гэр хороололд манай энэ дүүрэгт чинь адилхан шүү дээ. Тэгэхээр наад 500 метр чинь хөндөөгүйгээр нөгөө бүх төрлийн энэ утаат тамхи энэ электрон тамхийг чинь тамхинд тооцоод эхлэхээр нөгөө биеэрээ дүүрэн мини гэж ярьдаг тиймээ манай Сонгино, энэ Сүхбаатар эд нар дээр тийм юм ярьдаг юм байна лээ шүү дээ. Биеэрээ дүүрэн нөгөө минжүүлчхээд зардаг. Тэгээд амьдрахын төлөө тэгээд л ажиллаж байна шүү дээ хүмүүс. Буруутгахын арга ч алга. Бид тэднийг дэмжиж чадахгүй учраас тэд өөр өөрсдийнхөө аргаар амьдарна аа тэгээд бизнес эрхлээд амьдарч байна шүү дээ.

Тэгэхээр бид нар ийм заалт хийчихдэг. Тэгээд түүний чинь цаана хэдэн хууль хэрэгжүүлэх нэрээр карманаас карманд янз бүрийн авлига өгдөг авдаг юм үүснэ шүү. Энийг цогцоор нь харахгүй бол болохгүй. Тэгэхээр манай Цагаанхүүгийн Идэрбат гишүүн бол Хэнтий аймгийн Засаг даргаар жишээ нь аймгийн төвийн Засаг даргын орлогч, Засаг дарга гээд энэ орон нутагт олон жил аймаг орон нутаг удирдсан хүн. Тэгээд та бол амьдрал мэднэ ээ. Тийм учраас энэ хуулийг ахлах бололцоог хангаж байгаа бас цөөн хүний нэг шүү та. Энэ чинь нөгөө 78 гишүүн санаачилчихсан чинь үлдсэн хэдэн гишүүд дотроос хэн нэгэн хүн ахлах болчихоод байгаа. Тэр болзлыг та бол аймаг орон нутагт ажиллаж байсан ажил амьдрал мэддэг хүн гэдгээрээ хангаж байна.

Дээрээс нь та бас хууль санаачлагч биш байна. Гуравт та бас тамхи татдаггүй тиймээ? Тийм ингээд бүх болзол хангаж байгаа учраас Идэрбат гишүүнээр энэ хуулийг ахлуулаад энэ сонирхлын бүлгүүдийн санал бодлуудыг сайн сонсмоор байна. Ер нь хуулийг бол сонирхлын бүлгүүдийн саналыг сонсохгүйгээр баталбал дараа нь дандаа эрх зүйн үр дагавар үүснэ. Тийм учраас энэ шүүмжилж байна гэж бодох хэрэггүй. Шүүмжилж байгаа талын байр суурийг сонсох ёстой тэгж байж явахгүй зөвхөн нэг талыг харж баталж болохгүй гэдгийг бас хэлмээр байна.

Ингээд Батжаргалын Заяабал гишүүн байна уу? Заяабал гишүүн байхгүй байна. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууна.

А.Ганбаатар: Энэ хууль дээр намын бүлэг дээр болоод Байнгын хороон дээр байр сууриа илэрхийлээд явж байгаа. Хуулийн төслийг энэ тамхин бүтээгдэхүүн шинээр нэр төрлөөр орж ирж байгаа тэр технологийн шинжтэй вепийн халаадаг тамхи эд нарыг хуульд хамруулах нь зүйтэй гэж дэмжиж байгаа. Гэхдээ Номинчимэг гишүүнд би хэлээд байгаа юм. Энэ танай нэг ажлын хэсэг чинь нэлээн академик байна аа. Амьдрал судлаагүй байна аа. Тэр Учрал даргын хэлээд байгаа сонирхлын бүлгүүдийн саналыг дутуу тусгасан байна аа. Нөгөө жор мэддэг эмчээс зовлон үзсэн чавганц гэдэг шиг яг энэ амьдрал дээр ТҮЦ-д зогсоод зарж байгаа янжуур дээр тогтож тэр ТҮЦ-ийнх нь санхүүгийнх нь эргэлт явж байгаа энэ хүмүүстэйгээ ерөөсөө ярилцаагүй байна аа.

Тэгээд 4 асуудал дээр байр сууриа илэрхийлье гэсэн юм аа.

Нэгдүгээрт энэ татварын асуудал байж байгаа. Татвар голлохгүй гээд байгаа юм. Татвар голохгүй юм бол энэ онцгой албан татварыг 2 дахин, 3 дахин, 4 дахин нэмэх шаардлага байгаа юм уу тэгвэл. Нүглийн такс гэж яриад байна. Нүглийн татвар гээд ойлгож байна. Тэгвэл буяны татвар байх ёстой шүү дээ. Нөгөө талд нь тамхинаас гаргахын тулд, янжуураас нь холдуулахын тулд тэр нэг амттай үнэртэй

тамхи сонирхоод татаад байх шиг байна. Амттай, үнэртэйгээсээ халаадаг руу нь ороод татах юм байна. Дараа нь эрүүл амьдралаа хүмүүс сонгох юм байна. Алкогол дээр жишээ татахад архинаас холдуулахын тулд пиво санал болгодог шар айраг. Технологийн хувьсгал гэж ярина. Тэрнээсээ дарс руу ордог. Энэ гурваасаа гарах юм бол эрүүл амьдрал. Тэгэхээр манайд нөгөө эрүүл амьдралыг нь бүрдүүлсэн орчин байгаа юм уу? Спорт заал, талбай, зугаалга, цэцэрлэг талбай эрүүл агаартай ийм газрууд цөөхөн шүү дээ. Тэгэхээр том компаниудын нөгөө орлогын нэг хувьд хүрэх татварыг энэ хуулийн төсөл чинь давхар дэмжээд орж ирсэн ийм төсөл байгаа юм уу. Спортын заалуудаа дэмжсэн эрүүл агаартай ийм орчнуудаа дэмжсэн ийм хуулийн төслүүд дагалдаж орж ирэхгүй байгаа юм аа. Киргиз, Казахстан гэж зэрэг орнууд бол 4, 5 жилдээ интервалтай 6-аас 10 хувьд л нэмж байгаа шүү дээ. Манайх огцом нэмэх юм бол тэр шагийн асуудал, тэр нөгөө лангуун доор татдаг асуудал. Тамхи нь өөрөө үнэтэй болчхож байгаа учраас тамхи орлуулдаг. Энэ хүүхдүүдийг хордуулж байгаагаас бүүр илүү хортой бараа бүтээгдэхүүн ороод ирнэ ээ. Энэ гаальд итгэх итгэл байхгүй шүү дээ. Гаальтайгаа нийлээд хийж байгаа. Ийм байна.

Энэ 500 метрийн асуудал бол энэ манай парламентын судалгааны хүрээлэн өөрөө хийчихсэн шүү дээ судалгааг нь. 83 хувьтай хэрэгжихгүй байна аа гээд. Засаг дарга нар жишээ болгоод ярьж байна шүү дээ. Тэгэхээр энэ тойргоор хэмжих гээд байгаа юм уу, эсвэл хэнд зарах дээр нь хяналт тавих гээд байгаа юм уу? Зорилго нь юу юм бэ? Насанд хүрээгүй хүүхдэд зарахгүй гэж байгаа болохоос насанд хүрээгүй хүүхдийг 500 метрээс хол байлгана гэж хэлээгүй шүү дээ.

Тэгэхээр энэ 500 метр ерөөсөө доошоо 100 байдаг юм уу 150 байдаг юм уу тоо тавиад орж ирэх ёстой. Энийг олж хараагүй байгаа юм аа. Цагдаа нар ороод тэр ТҮЦ-ээс чинь татвар аваад байдаг гэж байна шүү дээ. Өдрийн такс гээд. Энэ 2200 цэг дээр ажилладаг бүх ширхгийн тамхи татдаг хүмүүсийн дунд хийсэн судалгаан дээр гараад ирчихсэн байна шүү дээ. Энэ нууц биш. Далд эдийн засаг чинь ингээд үүсэж байгаа байхгүй юу. Лоббид хамрагдсан, хамрагдаагүй гээд эсвэл зарим нэг нь шүүмжилж хэлсэн гэдэг юм уу тэр 78 дотор гарын үсэг зураагүй хүмүүс нь нөгөө талдаа лоббид орчихсон юм шиг сурталчилгаа бас хийгээд байх юм. Эргэн тойрныхоо хүмүүсийг хардахын оронд өөрсдийнхөө тэр хамарч байгаа хүрээгээ бас судлах хэрэгтэй шүү дээ. Гаа нь үлдчихээд байхад бусад амт үнэрийг нь авчихаар чинь гаатай тамхины компанийн лоббид орсон гээд захын хүн бодно шүү дээ.

Тэгвэл л гааг нь бас авч хаях хэрэгтэй. Амт үнэрийг нь авч байгаа бол. Эсвэл хоёуланг нь үлдээгээд татвараа тавих хэрэгтэй. Дарга аа нэг минут авчихъя.

Н.Учрал: Ганбаатар гишүүнд нэг минут нэмж өгье. Энэ дотор чинь ахиад ньюанс байгаа юм байна лээ шүү дээ. Янжуур тамхины чинь амт үнэр гэдэг нь өөрөө тэр өвс ургамал нь байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр орцыг нь аваад хаячхаж байгаа болох гээд байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ веп халаадаг янжуур 3 чинь дотроо өөрөө техникийн зохицуулалтын хувьд ялгаатай байгаад байгаа байхгүй юу. Энийг ингээд нэгд нь хамруулаад ингээд байна. Үнэхээр тэр багаж төхөөрөмжид нь татвар тавьж байгаа бол дүнсэн тамхины гаансанд тавих хэрэгтэй болчихоор байна шүү дээ. Зожголканд тавих нь байна шүү дээ. Пивоор шилэнд нь тавих нь байна шүү дээ. Сав бокст нь тавих гээд байгаа байхгүй юу. Ийм алдаатай юмнууд байна аа. Тэгээд энийгээ эргэж хармаар байна. Би 78-д ороогүй тамхи татдаггүй ажлын хэсэгт дэд даргаар орж ажиллаж болно шүү дарга аа. Энэ асуудлуудаа эргээд харчих юм бол энэ хууль явах ёстой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Н.Учрал: Энэ ажлын хэсэгт болзол хангах хүмүүсийн шалгуур их өндөр шүү 1-т тамхи татдаггүй, 2-т ашиг сонирхлын ямар нэгэн зөрчилгүй тэгээд аймаг орон нутаг удирдаж байсан хүмүүсийг урилгаар оруулах хэрэгтэй. Энэ Идэрбат гишүүн байна, манай энэ Болормаа гишүүн байна манай дүүргийн дарга. Алдаржавхлан дарга гээд ингээд тамхи татдаггүй дүүрэг орон нутаг удирдаж байсан ажил амьдрал мэддэг нөгөө цагдаа нартайгаа яг нүүр тулж байсан хүмүүсийг оруулаад амьдралтай хууль батлах ёстой л гэж би бодож байна. Тамхи татаж байгаад гэрээнээс гарчихсан хүнийг бас оруулна.

Номинчимэг гишүүн нэмэлт хариулт өгье.

О.Номинчимэг: Ганбаатар гишүүнд баярлалаа. Байнгын хороон дээр бас дэмжиж байгаа. Таны үндсэн асуудалд бас тодорхой хариултуудыг өгье өө гэж бодож байна. Спорт ер нь санал нэг байгаа. Энэ нөгөө донтолтоос сэргийлэх хамгийн гол зүйл спорт. Тийм учраас спортын барилга байгууламж хөтөлбөр, 21 аймаг 9 дүүрэгтээ хүртээмжийг сайжруулахад энэ олж байгаа татвараас нь л зарцуулъя гэж байгаа юм. Тэгээд таны хөндөөд байгаа тэр нэг хувийн татварыг хөндөж орж ирэхгүй яасан юм бэ гэхээр тэр угаасаа байгаа юм. ААН-ийн албан татварын тухай хуульд энэ компаниуд орлогоосоо нэг хувиар спортын барилга байгууламж барих юм бол хөнгөлөгдөнө өө гэдэг заалт нь угаасаа байгаа юм. Тэгэхээр ямар ч энд хөндөж орж ирэх шаардлага байхгүй. Энэ хуулийн хэрэгжилтийг бид нар Сангийн яамнаас аваад үзэхээр хамгийн сайн ашиглаж байгаа нь Шунхлай компани юм билээ. Спортын барилга байгууламж яг энэ нэг хувиараа барьж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ хэрэгжээд явж байгаа заалт шүү гэдгийг бас хэлмээр байна аа.

Гааны асуудал байна аа. Энэ дээр бас олон хүмүүс энэ сошиал дээр ч гэсэн олон янзын мэдээлэл явж байх шиг байна. Энийг би нээлттэй тайлбар нийгмийн бодлогын Байнгын хороон дээр ч гэсэн өгсөн олон гишүүдийнхээ санал бодлыг тусгаад дэмжлэгтэйгээр орж ирж энэ хуулийг явуулах нь зүйтэй гэж үзсэн учраас ингэсэн. Энэ хууль анхнаасаа энэ 2, 3 жилийн өмнө ч гэсэн явах гээд Улсын Их Хурал байтугай Засгийн газрынхаа босгыг ч давж чаддаггүй лоббинд нь уначихдаг байсан хууль. Би энэ хуулийг энэ 126 гишүүнтэй болоод олон энэ шинэ гишүүнтэй болоод бас гарч байгаа. 78-уулаа үзэл санаан дээр нь энэ асуудлыг шийдэх ёстой шүү гэдэг байдал дээр нь нэгдэж орж ирж байгаад маш их олзуурхаж байгаа. Ингээд 78 гишүүндээ маш их баярлаж байгаа. Зарим гишүүдэд нь би танилцуулж амжаагүй. Зарим нь Засгийн газрын сайдууд байгаа. Ингээд энэ асуудал орж ирсэн хувь гишүүний хувьд манай ажлын хэсгийн хувьд манай ажлын хэсэгт орж байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийн судлаачдын хувьд ч гэсэн гааг бас адилхан хасах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Би ч гэсэн ийм байр суурьтай байгаа. Тэгэхээр энийг Улсын Их Хурал дээр мэдээж дахиад саналууд гарна. 1 дүгээр, 2 дугаар хэлэлцүүлэг гарна. Энэ дээр гишүүдийнхээ санал бодлыг гаргаад зарчмын зөрүүтэй санал гаргаад энийг шийдвэрлэх боломжтой гэж харж байгаа.

Гуравдугаар асуудал энэ татварын хэм хэмжээ байна аа. Бид нар татварыг байгаа үнийн дүнгийнх нь хэдэн хувь байна уу, байгаа татварынх нь хувь байна уу гэдэг дээр бас ялгаа заагтай харах ёстой. Түрүүн хэлсэн 2017 онд гаалийн албан татвар си ай эф үнийнх нь 5 хувь байсныг 30 хувь буюу 25 хувиар нэмж байгаа. Манай хуулийн төсөл дээр орж ирж байгаа энэ түрүүн хэлсэн манай Анхбаяр Сангийн яамнаас энэ ерөөсөө үнийн дүнтэй нь харьцуулах юм бол тэгж энэ хүмүүст

буруу мэдээлэл өгчхөөд байгаа шиг өндөр биш 3600 төгрөгийн тамхи чинь ирэх жил 4700 орчим болох нь л гэсэн ийм л тооцоолол байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна аа.

Өөр нарийвчилсан асуултуудыг манай ажлын дэд хэсгээс нарийвчилсан мэдээлэл өгөх хүмүүс байвал бас өгч болно шүү гэж хэлмээр байна.

Н.Учрал: Баярлалаа. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууна. Мөнхбат гишүүн байхгүй байна. Мөнхбат гишүүн байхгүй байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн асуулт асууна.

Т.Мөнхсайхан: Тамхины хяналтын тухай хуулийг дэмжиж байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд бас энэ хуулийг оруулж Улсын Их Хуралд өргөн барих гэж нэлээдгүй олон гишүүд сайд нар үзсэн. Тэгээд харин харамсалтай нь өнөөдрийг хүртэл өргөн баригдаагүй байж байгаад харин Номинчимэг гишүүн маань энийг өргөн бариад өнөөдөр хэлэлцүүлж байна. Тэгэхээр энэ цаанаа энэ тамхи импортлогч үйлдвэрлэгч нарын маш том ийм лобби байдаг. Акц хийдэг янжуур тамхи, электрон тамхи гэж албаар ингэж хуваагдуулсан лоббид өртсөн мэт мэдээлэл өгдөг. Яг бодит байдал дээрээ янжуур тамхи, электрон тамхи үйлдвэрлэгч, импортлогч нар бүгдээрээ нэг янжуур тамхи үйлдвэрлэгч, импортлогч нар аль хэдийн электрон тамхийг оруулж ирдэг импортолдог болсон.

Тийм учраас ямар нэгэн тийм лоббинд өртөх асуудал төдийлөн их байхгүй болов уу гэж харж байгаа юм. Манай улсад 2023 оны байдлаар 2019-2023 оны хугацаанд эмэгтэйчүүдийн тамхи таталт зургаа дахин нэмэгдсэн. Хүүхдийн тамхи татах нас 3-аар залуужсан. 18 байснаа 15 болсон. Энэ бүх тооцоо судалгаануудыг хийсэн. Эмэгтэйчүүд, эхчүүд, хүүхдүүд маань эрүүл мэндэд асар их сөрөг нөлөөтэй. Энэ тамхийг ихээр хэрэглэдэг болж байна гэдэг маань манай улсын үндэсний аюулгүй байдалд маш том заналхийлэл хийж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ хуулийг бид нар яаралтай баталж ирээдүй болсон хүүхэд залуучуудаа эхчүүдээ энэ хортой бүтээгдэхүүнээс хамгаалах зайлшгүй шаардлагатай. Одоо манай улсад хүн болгон л ярьдаг хорт хавдар гэж. Хорт хавдрыг үүсгэж байгаа шалтгааны чинь 35 хувийг нь энэ тамхидалт эзэлж байгаа. Электрон тамхи хор уршиггүй мэт ярьдаг энэ зүйл ор үндэсгүй ээ. Маш их консервон бодис агуулдаг гэдэг нь угаасаа тогтоогдчихсон зүйл. Тэгэхээр цаашдаа бид нар энэ тамхидалтыг бууруулах бүх шатын арга хэмжээ авах ёстой. Одоо энэ хуулийн өөрчлөлтүүдийг бид нар хийхгүй бол ирэх 5 жилд дахиад эмэгтэйчүүдийн тамхидалт магадгүй 10 дахин нэмэгдэх, тамхинд орж байгаа хүүхдийн нас магадгүй 10 нас болж бид нарын ирээдүйд асар их сөрөг нөлөөлөл үзүүлэх ийм том эрсдэл өнөөдрийн хувьд бий болчихсон байгаа учраас гишүүд маань энэ Тамхины хяналтын тухай хуулийг хэлэлцэж батлах тал дээр та бүхэн маань идэвх санаачилгатай оролцоосой гэж та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байгаа. Тэгээд энэ тамхидалтай тэмцэх, тамхины хэрэглээг бууруулахад энэ олон улсын байгууллагуудын оролцоо маш их чухал дэмжлэг их чухал байдаг. Тэгээд саяхан бас олон улсын тамхины хяналтын конвенцын хурал болсон. Энэ хуралд эрүүл мэндийн сайдын зөвлөх гэж нөхөр энэ хуралд оролцоод энэ тамхины асуудлыг ер нь дэмжих ийм байр суурийг тэр хурал дээр илэрхийлсэн.

Тэгээд энэ ямар учиртай байр суурь вэ гэдгийг 2 хоногийн өмнө Байнгын хорооны хурал дээр энэ ЭМЯ-ны төлөөллүүдээс асууж тодруулсан. Энэ бол эрүүл

мэндийн сайдын байр суурь биш, ЗГ-ын байр суурь биш гэдэг ийм зүйлийг хэлсэн. Тэгэхээр энэ хэний байр суурь болчхов оо. Энэ Женев хотод болсон энэ олон улсын хуралд оролцохоор бодвол сайд нь өөрийнхөө төлөөллийг энэ тушаал шийдвэр гаргаад, зардал мөнгө гаргаад ингээд явуулж байгаа байх л даа. Тэгээд очоод хэний байр суурийг илэрхийлчхэв гэдгийг энийг надаа нэг тодруулах хэрэгтэй.

Тэгээд мөн 2 дугаарт үүнээс үүдэлтэйгээр олон улсаас орж ирэх дэмжлэг туслалцаа энэ зүйлүүд маань буурах маш том эрсдэл.

Н.Учрал: Нэмэлт нэг минут авах уу? Мөнхсайхан гишүүн.

Т.Мөнхсайхан: Тэгээд энэ олон улсаас орж ирэх байсан энэ дэмжлэг туслалцаанууд зогсвол энэний хариуцлагыг хэн хүлээх вэ? Энэн дээр хэр нухацтай хандсан юм бол оо? Яагаад тэр нэг уурхайчин нөхөр эрүүл мэндийн салбарыг төлөөлөөд сайдыг төлөөлөөд ингээд тэр хуралд очоод ийм болчимгүй үзэл бодол илэрхийлчхэв ээ. Энэ дээр хэн хариуцлага хүлээх вэ гэдэг асуудал. Тамхин дээр орж ирж байгаа онцгой албан татварын нэмэгдлийг ЭМД-ын санд тодорхой хувийг нь төвлөрүүлэх нь их чухал шүү дээ. Яагаад гэвэл энэ тамхины эмчилгээний зардлыг ЭМД-ын сангаас гаргана аа гээд тусгачихсан байгаа байхгүй юу. Ингээд ЭМД-ын сан руугаа хамаг юмыг санхүүжүүлнэ гэж цутгаж цутгачхаад тэгээд эргээд эх үүсвэрийг нь нэмэгдүүлээгүйгээс л болж өнөөдөр ЭМД-ын сангийн өнөөдрийн нөхцөл байдал үүсэж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр хэр оновчтой нэмэгдлүүдийг хийж байгаа вэ гэдгийг бас асууя?

Н.Учрал: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Мөнхсайхан гишүүнд баярлалаа. Эрүүл мэндийн салбарын сайд байхдаа бас бодлогын дэмжлэг үзүүлж манай ажлын дэд хэсэгт бүхий л талаар дэмжлэг үзүүлж бас ажиллаж байсанд хувь хүний хувь гишүүний зүгээс бас талархал илэрхийлье ээ. Эрүүл мэндийн дэмжих сантай холбоотой бид нар яах вэ өмнө нь бол тамхины онцгой албан татварын зөвхөн 2 хувь нь Эрүүл мэндийг дэмжих санд ороод зарцуулалтын хувьд бас их учир дутагдалтай байсан. Тэгэхээр гишүүдийнхээ энэ саналыг аваад бид 2 хувь биш 50 хувийг нь түрүүн хэлсэн хүүхэд залуучууд руугаа спортод шим тэжээлтэй хоол тэжээл мөн энэ тамхинаас үүдэлтэй эмчилгээ, тамхинаас гарах эмчилгээндээ зарцуулъя аа гэсэн байгаа.

Тэгээд энэ дээр бол ЭМД-ын Сангийн хууль бас дагалдаж орж ирж байгаа. Та бүхнийхээ саналыг өшөө сайн тусгаад чамбайруулаад хэлэлцүүлгийн явцад явах боломжтой гэж харж байгаа. Мөнхсайхан гишүүн маань бас дурдлаа. Сошиал орчинд бас 2 тал болоод байлдаж байгаа юм шиг зураг гаргадаг аа гэдэг яг үнэн. Дэлхий дахинаа янжуур тамхины хэрэглээ багасаж байгаа, янжуур тамхины томоохон компаниуд болох Филипп Моррис нь байдаг юм уу. Бритиш, Американ табако, Жапан табако гээд бүх энэ том брэндүүд нь өөрөө янжуур тамхиныхаа зах зээлийг алдаж байгаа болохоор халаадаг тамхи, энэ электрон тамхи гээд шинэ төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлээ алдахгүйн үүднээс гаргаж ирж байгаа.

Тэгэхээр ерөөсөө энэ янжуур тамхи, электрон тамхи гэдэг чинь 2 талд гараад байлдаад байдаг биш хүн шиг нэг толгойтой, 2 гартай, нэг гараараа янжуур тамхи нэг гараараа электрон тамхи үйлдвэрлээд зах зээлээ энэ хортой бүтээгдэхүүн

үйлдвэрлэдэг энүүгээрээ хамгаалах л ийм зорилготой байгаа. Монголд ч гэсэн адилхан. Электрон тамхи импортлогчид, янжуур тамхи импортлогчид, янжуур тамхины үйлдвэрлэгч нь бүгдээрээ электрон тамхи үйлдвэрлэгч. Бүгдээрээ адилхан янжуур тамхи импортолж байгаа нь электрон тамхи импортолдог. Тэгээд сошиалд болохоор олон нийтэд болохоор 2 талд байлдаад байгаа ч юм шиг. Нэг нь нэгнийхээ эсрэг байгаа ч юм шиг боловч цаагуураа бүгдээрээ нийлчихсэн. Энэ хуулийг яаж гацаах вэ болиулах вэ л гэдэг ийм лоббиг хийдэг. Тэгээд би бас энэ дээр Тамхины тухай хуульд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нэг зүйл заалтыг бас дурдмаар байгаа юм. Одоо Тамхины хяналтын тухай хууль дээр 5.1.4-д Тамхины хяналтын тухай хууль тогтоомж боловсруулах явцад ашиг сонирхлын зөрчилтэй тамхи үйлдвэрлэгч импортлогчоос тавьсан саналыг хүлээж авахаас татгалзах үүрэгтэй.

Энэ бол төрийн бүх байгууллагын үүрэг. Тамхины компаниуд хэтэрхий их лоббитой болохоор конвенцоороо ч тэр бид нарын нэгдэж орсон, Монгол Улсын хуулиар ч тэр ийм саналыг битгий хүлээж аваарай бодлого боловсруулахдаа гэдгийг цагаан дээр хараар манай хуульд бас тусгаж өгсөн байгаа гэдгийг хэлмээр байна аа. ЭМЯ-аас түрүүн Мөнхсайхан гишүүний асуусан асуултад тодруулаад хариулчихъя аа.

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулах уу? 4 дүгээр микрофон.

Б.Цэцэгсайхан: Мөнхсайхан гишүүний асуултад хариулъя. ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга. Тэгэхээр өнгөрсөн 7 хоногт ДЭМБ-ын ТХСК-ын 11 дэх удаагийн хурал Женев хотод зохион байгуулагдсан. Энэ хуралд Чинбүрэн гишүүний орон тооны бус зөвлөх Энхбаяр гэж хүн оролцсон. Яг ямар асуудал ярьсныг бид нар одоогоор албан ёсны мэдээлэл ирээгүй байгаа. Тэгэхээр энэ хүний байр суурь ЭМЯ болон Засгийн газрын байр суурь биш гэдгийг би бас дахин хэлмээр байна. ЭМЯ бол Тамхины хяналтын хууль, ТХСК-ыг бүрэн дэмжиж байгаа.

Н.Учрал: Тэгээд орон тооны бус зөвлөхөөр тэгээд хурал удирдуулчихаад Их Хурлын танхимд орж ирчхээд ийм юм яриад байж болохгүй шүү нөхөд өө. Тэгээд ер нь орон тооны бус зөвлөх, яамны газрын дарга нарыг цуглуулж хурал удирдана гэж ер нь юу байна? Юу яриад байгаа юм? Тэр чинь орон тооны зөвлөх биш юм уу? Та нар юу яриад байна? Орон тооны бус зөвлөх олон улсын хуралд яам төлөөлдөг болчихсон юм уу? 4 дүгээр микрофон.

Б.Цэцэгсайхан: 2 өөр хүний асуудал яригдаж байгаа. Женевт болсон хуралд явсан нь Их Хурлын гишүүний орон тооны бус зөвлөх Энхбаяр гэж хүн байгаа. Яг сайдын эрүүл мэндийн сайдын зөвлөх Дэмбэрэл гэж хүн ажиллаж байгаа, орон тооны зөвлөх нь, сайдын орон тооны зөвлөх.

Н.Учрал: Ойлголоо. Тэгээд ер нь нэг зарчимтай л байна шүү нөхөд өө. Нэг Их Хуралд орж ирчхээд тэгээд ер нь зөвлөхүүд даргадаа л үйлчлэх үүрэгтэй шүү. Тэрнээс биш яам удирдах, салбар төлөөлөх эрхгүй. Зөвлөх бол зөвхөн өөрийнхөө даргад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх л үүрэгтэй хүмүүс, мэдээ мэдээллээр хангах. Тэрийг ойлгох ёстой шүү. Хэрвээ тэр яам төлөөлөх гээд байгаа бол яамныхаа тэр тодорхой албан тушаалд сонгон шалгаруулалтад ороод тэгээд тэнцээд ажиллах ёстой л гэдэг. Би ийм л байр суурьтай байна. Тэгээд наад мэдээллүүдээ зөв хангахгүй бол ингээд гишүүдийн асуултад янз бүрийн буруу хариулт өгч болохгүй ээ.

Далайн Батбаяр гишүүн асуулт асууна.

Д.Батбаяр: Эрхэм Улсын Их Хурлын гишүүд болон ажлын хэсгийнхэн энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Өнөөдөр хэлэлцэж байгаа энэ хууль маш чухал хууль. Хэрвээ та бүхэн санаж байгаа бол Төрийн ордонд болсон нэгэн хурлын үеэр олонд нэртэй урлагийн нэг хүн Төрийн ордонд камерын үүдэнд камерын нүүрэн дээр нь тамхи татаад нөгөө электрон тамхиа татаад сууж байгаа ийм бичлэг явж байсан. Энэ нийгмийг бол маш их цочроож байсан. Үүнээсээ гадна энэ электрон тамхины хэрэглээ бол хязгааргүй болчихсон. Машинд ч тэр, байшинд ч тэр, өрөөнд ч тэр хаа сайгүй татдаг болчихсон. Ийм байгаад байгаа юм.

Тэгээд энэ итгэл үнэмшлээрээ би ажлын хэсэгт орсон. Тамхины хяналтын тухай хуульд үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсэгт орсон байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн энэ ажлын хэсгийн ямар үнэлэлт дүгнэлт гарсан бэ гэхээр 2012 онд баталсан энэ хууль маань үүнээс хойш бий болсон энэ электрон танхимыг хянах боломжгүй болчихсон юм байна аа. Ийм учраас заавал тамхины хяналтын хуулийг шинээр хийх шинээр батлуулах ийм шаардлага үүсэж байгаа юм байна аа гэсэн ийм дүгнэлтэд хүрсэн юм. Ямар асуудал дээр би санал нийлээгүй ажлын хэсгээсээ гарсан бэ гэхээр яг одоо бид нарын шийдэх ёстой байгаад байгаа асуудал нь юу вэ гэхээр энэ электрон тамхийг хэн татах вэ, хэзээ татах вэ, хаана татах вэ гэдэг асуудлыг шийдэх ёстой байсан юм. Түрүүн Одонтуяа гишүүний ярьж байгаатай би бас санал нэг байгаад байгаа юм. Энэ тамхины хяналтын хууль биш Татварын хууль болчхов уу даа гэсэн ийм бодолтой байгаад байгаа юм. Тэгэхээр ажлын хэсгээс асуух асуулт байна.

Нэгдүгээрт нь энэ хуулиар энэ хуулийн төслөөр насанд хүрээгүй иргэн хүүхэд худалдан авах боломжийг хаасан ямар зохицуулалтууд орж ирж байгаа вэ зөвхөн насанд хүрсэн хүн тамхийг хэрэглэх ямар боломжийг энэ хуулиар олгож байгаа вэ гэсэн 1 дүгээр асуулт байна.

Хоёрдугаарт нь янжуур тамхины гол үйлдвэрүүд бол яг манай хөршүүдэд Казакстан, ОХУ-уудад байгаа. Хэрвээ одоо энэ хуулийнхаа төслөөр орж ирж байгаа энэ үнийн дүнгээрээ татвар ноогдох юм бол Евроазийн эдийн засгийн холбоотой хийсэн хэлэлцээрийн үр дүнд тодорхой хөнгөлөлтүүд эдлэх болно оо. Эдгээр Казахстан болон ОХУ-д байгаа үйлдвэрүүд Монголд хэрвээ бүтээгдэхүүнээ нийлүүлбэл. Тэгвэл янжуур тамхины үнэд яаж нөлөөлөх вэ гэсэн 2 дахь асуулт байна.

Гурав дахь асуулт нь гэвэл хэрвээ электрон тамхи болон янжуур тамхины үнэд эрс ялгаа гараад янжуур тамхины үнэ нь бага болчих юм бол буцаад янжуур тамхины хэрэглээ өсөх ийм магадлал байгаа юу гэсэн ийм 3 асуулт байна аа.

Н.Учрал: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Батбаяр гишүүний асуултад хариулъя аа.

Та бидний хамт бас ажиллаж байсан хуулийн хэрэгжилттэй танилцаад электрон тамхины зохицуулалтыг хийх ажлын хэсэг байсан. Тэгээд энэ хүрээнд бас ажлын хэсгээ өргөтгөж бас энэ хуулийг өргөн барьсан байгаа. Гэхдээ бид нар яах вэ энэ хуулийн хэрэгжилттэй танилцах үед зөвхөн электрон тамхины асуудал ч биш

бас янжуур тамхины ч асуудал байгаа юм байна гэдэг асуудалтай байсан учраас энэ зохицуулалтуудыг бүгдээр нь ижил тэгш байлгаж аа гэдэг үзэл санаагаар хуулиа өргөн барьсан байгаа. Таны асуусан энэ 21 нас хүрээгүй хүүхдэд тэгвэл яах зохицуулалт орж ирсэн бэ гэдэг байна. Ер нь манай Монгол Улс бусад улсад 18, 21 гээд янз бүрийн настай энэ хүмүүст бол архи, тамхи зарахгүй гэдэг ийм заалт байдаг аа.

Улс орон бүрийн л хэрэгжилт бас янз бүр байдаг юм байна. Та бид бүгдийн үеийнхэн бүгд л мэддэг. Ахлах ангид ороод л томоогүй эсвэл ингээд гоё охиныг хараад күүл харагддаг ч юм уу, бусдаасаа үлгэр дуурайл авдаг ч юм уу бүгд л ерөнхийдөө 1 ахлах ангиасаа татаж үзээд л янз бүрийн байдлаар аваад л явдаг. Энэ аль ч улсад байдаг л юм байна лээ. Энэ бол ерөөсөө нөгөө байх ёстой моралийн заалт буюу хэрэгжилтийг хамгийн сайн хангахын төлөө чармайх ёстой заалт байдаг юм байна лээ. Тэгээд бид яг таны хэлж байгаа үнэн. Энэ электрон тамхины үнэхээр зохицуулалтгүй байсны хор уршгаар тархалт нь үнэхээр ихэссэн. Тэгэхээр яг таны хэлж байгаа яг утаат тамхитай адилхан дотор орчинд татахаа больё. Төрийн ордонд арга хэмжээнд ороод хэвнэг татаж байгаа байдлыг болиулъя. Цэг дээр нь татдаг больё, зар сурталчилгааг ийм эрээ цээргүйгээр интернэтээр болон онлайнаар хийхээ больё, тусгай зөвшөөрөлтэй оруулж ирдэг больё. Тусгай зөвшөөрөлтэй энгийн зөвшөөрөлтэй зардаг больё гэдэг энэ бүх зохицуулалт маань энэ хуулийн төсөлд орж ирсэн байгаа. Бидний бас энэ 21 насанд хүрээгүй хүүхдэд зарах юм бол ямар байдлаар нэг хөшүүрэг хийж болох вэ гэдэг дээр манай цагдаагийн газраас ч гэсэн саналуудаа хэлээд 21 нас хүрээгүй. Ер нь энэ тусгай зөвшөөрөлтэй газрууд чинь бүгд камертай байх ёстой. Тэгээд үнэхээр 21 нас хүрээгүй хүүхдэд зарсан байх юм бол энэ борлуулах энгийн зөвшөөрлийг нь цуцлах хүртэл санкцтай болгоё гэдгийг Зөрчлийн тухай хууль дээр бас тусгаж энэ дагалдах хууль дээр орж ирж байгаа.

Хоёр дахь асуудал тэр Евроазийн хэлэлцээртэй холбоотой асуудал байна аа. Энийг түрүү жил энэ хавар орж ирэхэд нь бол би бүх л Байнгын хороон дээр энийг анхааруулж болохгүй зүйл шүү гэдгийг анхааруулж байсан. Аргаа ядаад хэвлэлийн хурал хүртэл хийсэн. Тэгээд удахгүй бас энэ хэлэлцээр ямар байдлаар Засгийн газраас Улсын Их Хуралд орж ирэх байх. Соёрхон батлах бол Улсын Их Хурал дээр хийгдэх ёстой процесс. Энэ асуудлыг хаа хаанаа бүгдээрээ ойлгож байгаа байх гэж бодож байна. Энэ 30 хувийн гаалийн албан татварыг байхгүй байх асуудлыг юугаар нөхөж яаж зөв болгож орж ирэх юм бэ гэдэг дээр манай Засгийн газар бол ажиллаж байгаа байх гэж би итгэж байна. Тэгээд тэрнийхээ дагуу ч гэсэн орж ирэхэд нь бол харна. Манай ажлын хэсгийн ер нь бид бүхний зарчмын байр суурь бол тамхи ийм хямдхан байж болохгүй ээ. Гаалийн албан татварыг тэглэх бол байж болшгүй зүйл. Тэгэхээр энийг дүйцүүлэхүйц л зохицуулалтуудыг бид хийх ёстой. Одоогоор Соёрхон батлагдаагүй бид нарт байгаа хууль эрх зүйн орчинд бол бид бүхий л төрлийн тамхи маань татвартай байх ёстой л гэсэн энэ зорилгоор.

Н.Учрал: Энэ Евроазийн чөлөөт худалдааны хэлэлцээр бол энэ Гантөмөр сайдын үеэс бас хэлэлцэгдэж эхлээд миний үед гарын үсэг зурагдсан.

Тэгэхээр Евроазийн чөлөөт худалдааны хэлэлцээр бол бараа бүтээгдэхүүнийхээ жагсаалтыг гаргаад нөгөө гаалийн худалдааны тарифыг заримыг нь буулгаж байгаа, заримыг нь тэглэж байгаа. Тэгэхдээ харилцан. Нэг ёсондоо уул уурхайн бус экспортоо бид нэмэгдүүлэх зорилтыг барьж ажиллаж байгаа.

Ингээд хамгийн сүүлд гэрээнд гарын үсэг зурахаас өмнө ялангуяа энэ гишүүдийн тавиад байсан тамхитай холбоотой асуудал дээр хэрвээ энэ тэглэгдсэн тохиолдолд нөгөө тариф нь буурсан тохиолдолд бол бид онцгойгоо нэмэгдүүлэх нь манай дотоодын асуудал юм аа гэдэг зөвшөөрлийг авсан.

Тэгэхээр бид онцгой татвараа нэмнэ. Ингээд харилцан ашигтай байдлаар хийгээд явна. Тэгэхээр үүн дээр бол нэг тийм санаа зовниод байх юм байхгүй. Евроазид чөлөөт худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурах гэж үе үеийн Засгийн газар хичээж ажилласан юм байна лээ. Энэ уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр.

Ингээд олон Засгийн газрын үед дамнаж байгаад зурагдсан. Манай парламент баталсны дараа Евроазийн 5 парламент баталж байж эцэслэх ёстой ийм хэлэлцээр. Тэгэхээр бид нар бас их гүрэн, 2 их гүрний дунд оршиж байна. Дээрээс нь бид нар рэ экспорт хийх бололцоо байна гэдэг агуулгаар нь харсан. Манайхаар дамжуулаад рэ экспорт хийх буюу Евроазийн зах зээл рүү барууны бусад орнууд Монголд бараа бүтээгдэхүүнээ үйлдвэрлээд гаргах энэ нөхцөлүүдийг бий болгоё гэдэг ийм томоохон алсын хараатай юм аа.

Тийм учраас энэ тамхитай холбоотой асуудал дээр санаа зовних зүйл байхгүй онцгой хүнд нэмээд явж болно. Энийг бид эрхээ авсан. Энийг Засгийн газар энэ эрхээ авсан учраас Их Хуралд танилцуулаад ингээд онцгойг нь нэмээд явахад болно. Өнөөдрийн энэ орж ирж байгаа хууль шиг эрүүл мэндийн санд тэр онцгой тэр нэмсэн төлбөр хураамжийг нь хуримтлал болгоод түүнийгээ юунд захиран зарцуулах вэ гэдэг байдлаар бас хандаад явах бололцоотой гэж ингэж үзэж байгаа.

Ажлын хэсгээс Золжаргал гишүүн хуулийн төсөл санаачлагчийн хувиар хариулна мөн үү? Би хэлээд байгаа шүү дээ 68-уулаа хариулж болно оо.

Ж.Золжаргал: Батбаяр гишүүний нөгөө энэ цахилгаан шинэ төрлийн тамхийг хэн, яаж, хаана татах вэ гэдэг асуулт дээр нэмж мэдээлэл хуваалцъя. Түүрүүн бас нэлээн хэдэн асуулт дээр гараад л байна. Нөгөө судалгаа нь ямар байгаа юм бэ гээд. Тэгэхээр 4 хүүхдийн нэг нь веп татаж байна гэдэг нь аягүй тодорхой судалгаа. Өнөө өглөө би бараг зуугаад хүүхэдтэй уулзсан 10 жилийн ахлах ангийн хүүхдүүдтэй. Тэгээд зүгээр аман яриагаар бол хамгийн бага хэлж байгаа нь 3 хүүхдийн нэг. Их хэлж байгаа нь тал нь. Тэгээд бодит байдал дээр бол маш их тархаж байгаа. Тэгэхээр энд нэг ийм зүйл байгаа юм. Хувь хүн лаагаа иднэ үү, луувангаа иднэ үү өөрийнх нь хэрэг. Нөгөө талдаа масст нөлөөлж байгаа зориудаар хэрэглээ рүү оруулж байгаа ялангуяа бие дааж шийдвэр гаргах чадваргүй насанд хүрээгүй хүүхдүүдийн хувьд. Энэ чинь ганцхан минут билүү.

Н.Учрал: Нэмэлт нэг минут Золжаргал гишүүнд өгье.

Ж.Золжаргал: Тэгэхээр хүний эрхийн асуудал нэг тусдаа, масс нийгэмд нөлөөлж байгаа статистик тоон дээр дүн шинжилгээ хийх нөгөө тусдаа асуудал. Тэгэхээр зэрэг ялангуяа энэ өсвөр үеийнхнийг энэ тамхинаас холдуулах нь бүүр тулчихсан асуудал болчихсон гэдэг нь үнэн юм. Одоо биднийг жоохон байхад би анхны тамхиа 7 настайдаа татаж байсан. Хөдөөгийн хүүхдүүд нөгөө аавын цээж гэдэг юм шүү дээ. Мал амьтны бааснаас өгсүүлээд л 9 жорын юм татдаг. Одоо ийм гоё амттай, үнэртэй, чихэртэй юм чинь ингээд гоё күүл харагдах гээд лаг харагдах

гээд татаад байгаа нь үнэн байхгүй юу. Тэгэхээр энэ хүний нэг их тамхи татах эрхийг нь хаагаад байгаа юм байхгүй. Зүгээр зориудаар маркетингийн хэрэгсэл байдлаар өсвөр үеийнхэн рүү оруулж байгааг хязгаарлах нь зайлшгүй. Харин татварын хувьд тамхи маш өндөр үнэтэй болоод ингэх юм бол далд зах зээл энэ тэр гэдэг нь бас болгоомжилбол зүйтэй асуудал. Энийг ажлын хэсэг дээр ярьж тохирох хэрэгтэй байх гэж бодож байна.

Н.Учрал: Далайн Батбаяр гишүүн тодруулна.

Д.Батбаяр: Тийм яг түрүүн цагдаагийн газрын дарга ч гэсэн бас ярьж байсан. Энэ нөгөө 500 метртэй холбоотой хуулийн заалт маань хэрэгжихгүй байгаад байгаа юм. Тийм учраас энэ хуулиараа шийдэх ёстой асуудал маань хаана татаж болох вэ, хэн татаж болох вэ, хэн худалдаж авч болох вэ гэдэг асуудлыг шийдэх ёстой байсан гэж хараад байгаа байхгүй юу. Тэр утгаараа энэ хүний оролцоог нь багасгачихъя, лангуун доор нь зардгаа болиулчихъя. Тэр дэлгүүр дотор нь вендинг машин байг, өөрийнхөө картаараа бид нар чинь энэ утсаа хүртэл нээж болдоггүй шүү дээ. Яг тэрэн шиг энэ технологийнх нь туршилт, технологийнх нь энэ хөгжлийг ашиглаад зөвхөн насанд хүрсэн хүн худалдан авалт хийж болдог энэ технологийг энэ хуулийнх нь төсөлд нь суулгаад өгөөч гэдэг байдлаар л яриад байгаа юм. Санал оруулаад байгаа юм. Тэгээд энэ утгаараа ахиад энэ саналаа бол ахиад оруулах гэж үзнэ.

Н.Учрал: Батбаяр гишүүнд нэмэлт нэг минут.

Д.Батбаяр: Тэгэхээр одоо болж байгаа гол хамгийн гол ач холбогдолтой зүйл нь хэн худалдан авах вэ хаана хэрэглэх вэ гэдэг нь чухал байгаа учраас энэ асуудлыг энэ хуулийн төслөөр шийдэж чадаагүй гэсэн үзэл бодолтой байгаад байгаа учраас ажлын хэсэгт ороод өөрийнхөө энэ саналыг тусгуулах талаар ажиллах хүсэлтэй байна.

Тэгэхээр ажлын хэсэг хэрвээ энэ хуулийг хэлэлцэх нь зүйтэй гээд олонхын санал дэмжээд ажлын хэсэг байгуулах юм бол намайг энэ ажлын хэсэгт оруулж өгнө үү гэсэн энэ хүсэлтээ албан ёсоор хэлье.

Н.Учрал: Баярлалаа. Өнөөдрийн энэ чуулган их ажил хэрэгч чуулган болж байна шүү. Олон ургалч үзлээ уралдуулж. Номинчимэг гишүүн нэмэлт хариулт өгнө. Нэмэлт нэг минут өгчихье өө Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Нэмэлт тайлбар өгчихье. Хаана, хэнд зарах, зарахгүй асуудал хуулиар маань зохицуулчихсан байгаа. Би бас тэрийг түрүүн тодорхой хэлсэн байх. Зүгээр юу юм байна лээ л дээ хүүхдүүд угаасаа томоогүй хаая бид нар фокус группийн судалгаа эд нар хийж үзсэн. Ер нь бараг ингээд нэг ийм бие хүн болсон. Тэрийгээ эсэргүүцэх гэж албаар багшийнхаа хажууд ардаа ангийнхаа ард суугаад татдаг ч гэдэг юм уу. Эсвэл бараг дэлгүүрт очоод хуурамч и монголиагийн ай ди үзүүлж байгаад тамхи авчхаад хүү намайг харж байна уу намайг 21-тэй этгээд тамхи өчлөө шүү дээ гэдэг тийм юмнууд бол гарч байгаа. Тусгай зөвшөөрөлтэй газраас. Энэ бол угаасаа хаа ч байдаг газар. Гэхдээ бид нар энийг мэдээж байхгүй болгохын төлөө л явна. Вендинг машин буюу автомат машинаар зарах асуудал одоогийн хуулиар хориотой байгаа. Энэ би танд хэлсэн судалгааны хувьд бол үнэхээр үр дүнгүй хүүхдүүдэд далд зах зээл дундын мийдел майн үүсгэх гээд манай

судлаачид бас хэлчих байх аа. Ийм үр дагавар гардаг юм байна лээ шүү гэдгийг би байр сууриа илэрхийлж байна.

Н.Учрал: Парламент бол олон ургалч үзлээ уралдуулдаг ийм танхим байна аа. Тийм учраас гишүүд бие биеийнхээ саналыг хүндэтгэлтэй хүлээж авна. Энэ бас энэ ажлын хэсэгт орсон хүмүүс ч гэсэн анхаарах хэрэгтэй. Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тамхины хяналтын тухай хууль тамхидалтын хувь хэмжээг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн бодлогын маш чухал салшгүй хэсэг гэж үзэж байгаа. Тэгээд сүүлийн жилүүдэд бол энэ хүүхдүүд өсвөр насныхны дунд тамхидалт нэмэгдэж байгаа. Ялангуяа энэ шинэ төрлийн электрон тамхины хэрэглээ маш ихээр нэмэгдэж байгаа гэсэн зүйл яригддаг. Хууль санаачлагчдын танилцуулга дээр энэ насанд хүрээгүй хүүхдүүдийн 4-ний 1 нь ямар нэгэн төрлийн тамхи тамхин бүтээгдэхүүн хэрэглэж байна гэсэн тоо баримтууд дурдагдсан байна. Тэгээд энэ маш их санаа зовоож байгаа ийм асуудал байгаа юм аа. Тэгэхээр энэ дээр бас нэг асуулт байна. Тэр нь юу вэ гэхээр манай мэргэжлийн байгууллагууд өөрсдөө бас ийм тодорхой өндөр сэмпл дээр хийсэн энэ тамхидалттай холбоотой ямар сегментийн бүлэг хүмүүс тамхинд илүү ихээр орж байна.

Цаашид ер нь орох эрсдэлтэй байна. Хүүхдүүдийн дунд энэ ямар арга замаар тархаж байна? Ер нь энэ хэрэглэгчийн зан төлөвтэй холбоотой ийм далайцтай судалгаа хийж байгаа туршлага байна уу? Ер нь энэ судалгаа хийх энэ хэрэг энэ зан төлөвийг судлах асуудлыг хэн хариуцах вэ? Ер нь цаашдаа бид нар өөрсдөө ийм маш их хэмжээний дата мэдээлэлтэй болохгүй бол ер нь энэ нийгмийн эрүүл мэндийн бодлого тодорхойлох түвшинд манайд яг ийм дотоодын судалгаанууд маш их хомс байгаад байна аа.

Тэгээд бид нар дандаа эсвэл нэг ийм олон улсын судалгаанууд тэр нь Монгол дахь сэмпл нь харьцангуй бага аль эсвэл яг нөгөө нэг өөрт тохиолдсон хөгтэй явдал гэдэг шиг тийм эргэн тойрныхныхоо нөхцөл байдлын хувьд яриад байх шиг байна аа. Тэгэхээр ийм датад суурилсан судалгаа шинжилгээнд суурилсан бодлого гаргая гэх юм бол бид нар бас ийм судалгаанд бас санхүүжилт гаргах ёстой. Тодорхой байгууллагуудыг үүнд бас чиглүүлэх ёстой гэж харж байна. Мэдээж хэрэг нийгмийн эрүүл мэндийн бодлогын хүрээнд энэ тамхидалтыг бууруулахтай холбоотой бодлогын бас олон арга хэрэгслүүд байна. Энэ хүртээмжийн асуудлыг хүмүүс ярьж байна. Аль болох яаж энэ хүртээмжийг бууруулах вэ? Ялангуяа хүүхэд, өсвөр насныхнаас хол байлгах вэ гэдэг асуудал яригдаж байна. Татварын асуудал зайлшгүй бас эдийн засгийн хөшүүрэгтэй холбоотой чухал асуудал.

Тэгэхээр нэгэнт татварын асуудал яригдсан учраас бас тодорхой хэдэн тоо баримт асууя гэж бодож байна. Ер нь энэ тамхины зах зээлийн багтаамж нь яг хэдэн төгрөгтэй тэнцдэг юм бэ? Одоо яг ямар зах зээлийн талаар бид ярьж байгаа вэ? Одоо яг энэ тамхины татварт хэдэн төгрөг төвлөрдөг вэ? Улсын төсөвт. 2026 онд энэ татвар нэмэгдүүлснээр нэмэлтээр хэдэн төгрөг төвлөрөх юм бэ гэсэн ямар тооцоонууд байгаа вэ? Яг энэ дээр тодорхой тоонууд хэлж өгнө үү? Энэ тамхины импорт ийм тусгай зөвшөөрлөөр олгогддог гэж ойлгож байгаа. Тамхи импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо хэд байдаг вэ? Эдгээрээс яг ийм их хэмжээгээр зах зээл дээр давамгайл байдлаар тамхи импортлогдож байгаа ААН-үүдийн мэдээллийг бас хэлж өгнө үү? Тамхины импортлогчид тодорхой бас үүрэг хариуцлага хүлээх ёстой гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ тамхины импортлогчдын

мэдээлэл тэдгээрийн зах зээлд эзлэх хувь хэмжээний мэдээлэл бас нээлттэй байх ёстой гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ талаар хууль туссан бөгөөд хууль санаачлагчийн судалгаанд ямар мэдээллүүд туссан бэ? Эрүүл мэндийг дэмжих сан гээд нэг ийм сан ороод ирж байгаа. Энэ сангийн зарцуулалт бол одоо бас анхаарал татаж байна аа. Сангийн зарцуулалт дээр одоо жишээлэх юм бол спорт цогцолбор барина ч гэнэ үү ингээд ер нь бас улсын төсвөөр хийгдэх ёстой зүйлүүд тусгагдсан харагдаж байгаа. Энэнийхээ бас үндэслэлийг тайлбарлаж өгнө үү? Мөн ЭМД-ын сангаас тамхины хамаарлаас гаргах асуудалд.

Н.Учрал: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн хариулна.

О.Номинчимэг: Жаргалан гишүүнд баярлалаа. Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах асуудал нам харгалзахгүй, нийгмийн суурь асуудал гэдэг байр сууринаас хандаж байгаад талархаж байна. Энэ ч бас байр сууринаас бүх намын төлөөлөл оролцсон 78 гишүүн энэ хуульд бас санал нэгдсэн байх аа гэж бодож байна аа. Жаргалан гишүүний асуусан нарийвчилсан судалгаануудын талаар манай эрүүл мэндийн байгууллагынхан хариулах байх. Миний хувьд байгаа мэдээлэл дээр энэ импортын зах зээлийн хувьд ямар зах зээл байна аа гээд тэгж байна. Бид нар нийтдээ нэг 17 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаа юм байна. Хүнс, хөдөө, аж ахуйн яамнаас тусгай зөвшөөрлийг нь өгдөг. Энэ дээр ч бас жоохон гажуудалтай л юм байна лээ.

Ер нь худалдааны асуудал эрхэлсэн байгууллага уг нь тусгай зөвшөөрлийг нь өгөх ёстой. Гэтэл одоогийн Засгийн газрын бүтцээр худалдааны асуудал эрхэлсэн сайд маань яамгүй. Тэгээд ЗГ-ын тогтоолоороо Хүнс, хөдөө, аж ахуйн яамнаас энэ тусгай зөвшөөрлийг өгдөг. Тэгээд энэ нөгөө хүнс биш ХАА ч биш ийм бүтээгдэхүүнийг ер нь бас цаашид бид нар яаж хяналтаа тавих үүднээс байх вэ? Төрийн байгууллагууд маань импортолж байгаа бол тэрнийхээ хяналтыг тавьдаг энэ бүтцийг яах вэ гэдэг дээр сайн харах л ёстой гэсэн бас байр суурьтай байгаа. 2024 түрүүн оны ГЕГ-ын мэдээллээр бол ерөнхийдөө 1 нийтдээ ерээд сая долларын мэдүүлсэн үнэ нь шүү дээ тэ? Ерээд сая долларын ийм бүтээгдэхүүн Монгол Улсад орж ирсэн байна лээ 3.5 тэрбум ширхэг янжуур тамхи, 8.2 сая ширхэг электрон тамхи. Тэгээд энэ дээр гааль дээр мэдүүлж байгаа үнийн дүн зах зээл дээр зарагдаж байгаа бүтээгдэхүүнийг харахаар ер нь бол нэлээн 100 хувийн ашгийн маржин тавьж явдаг бүтээгдэхүүн байна лээ. Тэгэхээр нийтдээ 700-аад тэрбум төгрөгийн зах зээл байна гэж харж байгаа. Нэлээн их зах зээл тэгээд энэ маань өөрөө энэ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нь олон юм шиг боловчиг яг үнэндээ зах зээл нь бол оликобо зах зээл үүссэн. Янжуур тамхин дээр бол зах зээлийн 90 хувийг 2 ААН л эзэлж байна. Энэ нь Вольтам гэдэг компани байна импортлогчийн хувьд. Жапан табако гэдэг брэндүүдийг оруулж ирдэг. Нөгөөх нь Алтан гадас гэдэг Солонгосын Кэй Ти Эн Жи гэдэг компанийн тамхинуудыг оруулж ирдэг. Энэ 2 компани маань янжуурынхаа зах зээлийн 90 хувийг эзэлж байгаа. Электрон тамхин дээр бол энэ зах зээлийн 75 хувийг Электроник гажет гэдэг компани дангаараа эзэмшдэг. Энэ нь өөрөө түрий хэлсэн Хятадын шинжээн дэх энэ 10 компаниас электрон тамхийг оруулж ирдэг компани байгаа. Тэгэхээр ер нь бол маш их ийм төвлөрсөн зах зээл. Төгс бус өрсөлдөөнтэй олигопол зах зээл үүсчихсэн байгаа. Ийм ч учраас зах зээлийн өөрсдийнхөө хуваагдал нэгдлийг үгсэн хуульд ч хамгаалж байдаг учраас тамхины хууль дээр нэлээн нөлөө үзүүлэх гэж оролддог ийм бүлэг хүмүүс байгаа гэж харж байгаа.

Эрүүл мэндийн дэмжих сантай холбоотой асуудал бас яг хэрэгжилтийг нь харахаар учир дутагдалтай юм нэлээн байгаа. Тэгэхээр энэ дээр хэлэлцүүлгийн явцад гишүүдийнхээ саналыг аваад яаж сайжруулах вэ гэдэг дээр тусгаад явна. Таныг ч бас ажлын хэсэгт орж ажиллаасай гэсэн ийм хүсэлт байна.

Н.Учрал: Гуравдугаар микрофон дээр ажлын хэсгээс нэмж хариулъя. НЭМҮТ-ийн захирал Баттөр байна.

Л.Баттөр: Дотоодын судлаачдын судалгаа хангалттай байгаа. Тухайлбал степс буюу халдварт бус өвчин, осол, гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийн судалгааг бид бүхэн 5, 5 жилийн зайтай хийдэг. ДЭМБ бусад Нэгдсэн үндэсний байгууллагуудтай хамтарч олон судалгаанууд хийдгийн бас нэг жишээ нь сургуульд суурилсан ийм эрүүл мэндийн судалгаанууд хийгдсэн. Сүүлийн үед бол Ерөнхийлөгчийн Тамгын Газрын зүгээс Эрүүл Монгол хөдөлгөөний хүрээнд бас судлаач нар энэ судалгаануудыг хийсэн. Ялангуяа эдгээр судалгаанууд хүүхдүүд рүү чиглэсэн тэр яриад байгаа 4 хүүхдийн нэг тутам нь цахилгаан тамхи хэрэглэсэн гэдэг. Энэ үр дүнгүүд эдгээр судалгаануудаас гарсан ийм үр дүн юм аа. Ихэнх гишүүд маань бас энэ янжуур тамхины хэрэглээ эргээд.

Н.Учрал: Нэмэлт нэг минут. 3 дугаар микрофон.

Хэрэглээ өсөх юм биш үү гэдэг ийм асуудлуудыг тавьж байна. Тэгэхээр бид нар өнөөдөр цахилгаан тамхинд янжуур тамхинаас гараад цахилгаан тамхи руу шилжиж байгаа энийгээ бид нар тамхинаас гарч байна гэж андуурч яриад байгаа. Энэний нотолгоо нь маш олон нотолгоонууд байгаа. Хамгийн энгийн жишээ бол импортын бараан дээр янжуур тамхины хэрэглээ нэмэгдэж импортоор орж ирж байгаа бүтээгдэхүүн нэмэгдэж байгаа. Випийнх бүүр огцом нэмэгдэж байгаа. 430 мянган вип саяхан 4, 5 жилийн өмнө оруулж ирдэг байсан бол одоо 8 сая гаран випийг оруулж ирдэг.

Тэгэхээр энэ бол ерөөсөө тамхинаас гаргаж байгаа ийм хэрэглээ биш юм аа. Дэмжих сантай холбоотой асуудал дээр бол 2025 онд энэ дэмжих сангийн төсөв бол татагдсан. 2024 он дээр нийт яг эрүүл мэндийн, нийгмийн эрүүл мэндийн чиглэл 500 сая төгрөгийг зарцуулж эдгээр төсөл хөтөлбөрүүдэд бас тодорхой хэмжээгээр зарцуулсан.

Н.Учрал: Жаргалан гишүүн тодруулах уу? Батбаярын Жаргалан гишүүн тодруулна.

Б.Жаргалан: Ажлын хэсэгт баярлалаа. Тэгэхээр сая дурдагдсан судалгаануудыг бас надад ирүүлбэл сайн байна. Энэ татварын хувь хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотой асуултад ингээд хэлэлцүүлгийн явцад бас мэдээлэл аваад яах вэ энэ татварын бодлого, бодлогын загвар дизайн бас их нарийвчлалтай ээдрээтэй асуудал байдаг. Тэгэхээр хэдэн хувиар татварыг нэмэгдүүлэх юм бол хэрэглээ хэдэн хувиар буурах вэ ч гэдэг юм уу гэх мэтчилэн асуудлуудыг бас ярилцах ёстой гэж бодож байна. Энэ Эрүүл мэндийг дэмжих сангийн асуудлыг ч гэсэндээ бид нар бас илүү нарийвчилсан байдлаар яривал зохистой гэж харж байна. Тэр ЭМД-ын сангаас тамхины хамаарлаас гаргах үйлчилгээг санхүүжүүлнэ гэдэг бол бас өрөөсгөл санагдаж байна аа.

Яагаад вэ гэхээр ЭМД-ын сан тэртээ тэрэнгүй маш их ачаалалтай ажиллаж байгаа. Тэгэхээр одоо ингээд энэ муу хорт зуршилтай холбоотой асуудлыг сангаас гаргуулна гэдэг бол бас өөр. Магадгүй энэ Эрүүл мэндийг дэмжих сангаас ч гэдэг юм уу энэ дээр бас нэг загвар дизайны хувьд ч гэсэн дээ арай өөр байвал зүгээр гэж харж байна аа.

Н.Учрал: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдээс Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай, намын бүлгийг төлөөлж бүлэгт харьяалаагүй гишүүдээс мөн урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Нэрс ирүүлсэн байна. Үг хэлнэ. Өлзийхүүгийн Шижир гишүүн үг хэлнэ.

Шижир гишүүн индэрт урих юм байна шүү. Шижир гишүүн 2 дугаар микрофон дээрээс үг хэлнэ. Микрофоныг индэрт ирэхээр нь асаая аа.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Энэ хуулийг дэмжиж байгаа. Сая бас нэлээн хэдэн гишүүдийн хувьд татварын хууль маягтай юмнууд яригдаж байна. Энэ татварын тухай хууль биш. Энэ хууль тамхины хяналтын тухай, тамхины хэрэглээний тухай, тамхины дам хэрэглээний тухай түүнээс нийгэмд үүсэх хор уршгийг зохицуулах тухай ийм хууль юм байгаа юм. Өмнөх манай Эрдэнэчимэг гишүүн маш сайн хууль санаачилсан. Энэ хуулийг тодорхой цаг хугацааны хүрээнд нийгэмд үүсээд байгаа нөхцөл байдлын хүрээнд өөрчлөх зайлшгүй шаардлага үүсэж байгаа. Өмнөх хууль дээр ерөөсөө тамхи гэдэг ганцхан заалттай байхгүй юу. Тамхин бүтээгдэхүүн гэдэг нь гээд. Ингээд үнэрлэх, зажлах зорилгоор ингээд тамхины төрлийн навчаар хийсэн гээд. Одоо энэ дээр чинь шинээр үүсээд байгаа цахилгаан тамхийг, халаагуур тамхийг шингэнээр ууршуулан татаж байгаа тамхийг. Түүнтэй адилтгаж байгаа электрон тамхи гэх мэтийг хуулийн зохицуулалт болгож оруулж байгаа юм аа.

Энийг хуулийнх нь тэр яг томъёолж байгаа хэдэн юмыг та нар сайн хараач гэж бас хэлмээр байна.

Хоёрдугаарт тамхинаас хамаарч жил бүр 4500 хүн нас барж байна гэвэл маш том тоо. Энэ аймшигтай том тоо. Энэ аймшигтай том тоо. 3 дугаарт сая Мөнхсайхан сайд гишүүн бас хэлж байна. Тамхи татах нас 3 насаар залуужиж байна аа гээд. Энэ дахиад цаашаа залуужна аа. Хэрвээ энэ байдал өөрчлөгдөхгүй бол. Яагаад вэ гэхээр одоо өнгөрсөн онд зөвхөн би та нарт гаалийн хэдэн мэдээлэл харснаа авснаа хэлж өгье. 2024 онд 3.1 тэрбум янжуур тамхи 59 сая доллароор Монгол Улсад орж ирсэн импортлогдсон. Энэ жил 3.5 тэрбум ширхэг тамхи 66 сая доллар болж нэмэгдсэн. Энэ тоо дахиад нэмэгдэнэ. Энэ зохицуулалт хийгдэхгүй. 8.2 сая электрон тамхи, 21.2 сая доллароор бусад төрлийн тамхи нь 18.9 сая доллар ингээд нийтдээ 100 сая долларын зах зээл дээрээс хэн ч ашиг сонирхлын зөрчлийг харж үлдэнэ.

Тийм учраас Улсын Их Хурал энэ тамхины хуулийг хэлэлцэх эсэхээ шийдээд цаашаа явах хэрэгтэй. Зарчмын зөрүүтэй асуудлууд байвал ажлын хэсэг дээр гараад өөрчлөх хэрэгтэй. Энэ саналууд чинь бүгд нээлттэй шүү дээ. Та нар бод доо. 100 сая долларын зах зээл дээрээс хэн зүгээр энэ зах зээл дээрээс тодорхой юмны эрх ашгийг хөндүүлэхийг хүсэх юм бэ? Эрх ашиг нь хөндөгдөөд байгаа учраас тал бүрийн лоббинууд яваад байгаа байхгүй юу. Зарим төрлийн тамхи 6.8 буюу 689

хувиар импорт нэмэгдсэн байна. Сая манай Золжаргал гишүүн хэлж байна шүү дээ хүүхдүүдийн хэрэглээг ярьж байна аа гээд. Та нар өөрсдөө хүүхдүүдээ ирээдүйд тамхи татдаг болохыг хүсэх үү? Энэ хамгийн эхний асуулт. Та нар ирээдүйд хүүхдүүдээ тамхи татдаг болохыг хүсэх үү? Тэр үүднээс хандаж та хэд маань энэ хуульд хандаарай гэж хэлье. Бас дээр нь дахиад уран бүтээлчдэд хандаж нэг уриалга гаргамаар байна. Өөрсдийн хийж байгаа уран сайхны кино, клип, аливаа арга хэмжээн дээр тамхидалттай холбоотой, тамхидалттай холбоотой дүрслэлийг, тамхидалттай холбоотой зураг авалтыг бууруулаач ээ. Бүүр чаддаггүй юм аа гэхэд бүүр буурвал сайн.

Тэгээд ер нь тамхи 5 насыг хорооно, архи 10 насыг хорооно гэж үг байдаг. Энэ бол Монголчуудын уламжлалт зүйр үг. Тийм учраас бид нар энэ бүх зүйлүүдийг бодоод энэ хуулийг хэлэлцэх эсэхийг шийдээд яваасай гэж Их Хурлын гишүүдээсээ хүсье. Бид нар магадгүй өнөөдөр энэ танхимд хэчнээн хүүхдүүд орж ирсэн бүгдээрээ харсан. Энэ хүүхдүүдийн ирээдүйн асуудлыг тодорхой хэмжээгээр зохицуулах ийм хуулийн зохицуулалттай л хууль. Тэрийг л зохицуулах гээд байгаа юм. 3 насаар хүүхэд тамхи татдаг хүний нас богиносно оо гэдэг чинь дараагийн судалгаагаар 4 болбол яах юм. 5 болбол яах юм? Хэрэглээ чинь жил бүр ингээд өсөөд байна шүү дээ. Жилд 10, 10 сая доллароор тэрбум тэрбум сая сая ширхгээр.

Тэгэхээр үүнийг одоогоос ингээд зохицуулалт хийхгүй бол бид нар нэргэсэн хонь хашхирав гэгчээр нийгмийн эрүүл мэндийн сан чинь эмнэлгүүд чинь тамхинаас шалтгаалсан өвчлөлөө дийлэхгүй болох ийм нөхцөл байдалд хүрсний дараа бид нар асуудлыг ярьж болохгүй шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Н.Учрал: Баатаржавын Мөнхсоёл гишүүн. 2 дугаар индер дээр.

Б.Мөнхсоёл: Би өөрөө ажлын хэсэгт анхнаас нь орж ажилласан гишүүний хувьд бас үг хэлэх нь зүйтэй юм болов уу гээд гараад ирлээ. Номин гишүүн бид анх ажлын хэсэг үүсэхэд 6, 7 гишүүд уг нь байсан. Сүүлдээ хоёулаа болоод дуусах шиг боллоо. Тэгээд ямар ч байсан өнөөдрийн байдлаар 78 гишүүд өргөн барьж байна аа. Тэгэхээр энэ электрон тамхитай тэмцэх энэ хууль эрх зүйн асуудал яагаад үүссэн бэ гэдэгтэй холбоод үгээ эхэлье гэж бодож байна. Хамгийн гол нь бид нар ирээдүй хойч үе үр хүүхдүүдээ хамгаалах гээд байгаа юм ердөө л энэ. Өөрөөр хэлэх юм манай охин жишээлбэл 17 настай. Аль 3, 4 жилийн өмнө сургуулийнхаа 0-д ороход ангийнх нь юм уу нөгөө ангийн хүүхдүүд бас вэгийг хэрэглээд зогсож байхыг хараад санаа нь зовоод гэртээ ирээд ээждээ хэлж байсан. Тэр үед бодогдсон асуудал юу вэ гэхээр зарим эцэг эхчүүд үр хүүхдүүддээ хяналт тавьж чаддаг.

Зарим нь өдөр тутмынхаа ажил амьдралд ачаалагдаад үр хүүхдүүд нь юу хийж байгааг бас мэдэхгүй өнгөрөх нь элбэг байдаг. Электрон тамхи өөрөө янжуур тамхи шиг бас утаа гаргадаггүй энэ тэр гээд олон шалтгаанаас хамаараад эцэг эхчүүд хүүхдээ тамхинд ороод байгааг мэддэггүй. Ийм бас нэг шалтгаан байна. Тэр утгаараа ерөөсөө ийм энгийн шалтгаанаас үүдээд энэ ажлын хэсэгт идэвхтэй ажилласан ээж хүн байгаа юм аа.

Хоёрдугаарт нь түрүүн манай гишүүд бас хэлж байна лээ шүү дээ. Энэ тамхийг үйлдвэрлэж байгаа газрууд нь жишээлбэл Камбож улс өөрсдөө өөрийнхөө улсад зардаггүй гэж байгаа байхгүй юу. Тэгээд яагаад энэ чинь нэг юм илэрхийлээд байгаа юм биш үү? Өөрсдөө татахгүй мөртөө үйлдвэрлээд байдаг, гаргаад байдаг. Энэ чинь өөрөө бизнесийн ач холбогдолтой гэдгийг илэрхийлчхээд байна аа.

Гуравдугаарт нь энэ ерөөсөө санаанаасаа зохиогоод нэг Номинчимэг гишүүн тэргүүтэй хэдэн гишүүд энэ асуудлыг аваад яваад байгаа биш. Дэлхий даяар 82 улс энэ электрон тамхины хэрэглээг хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлээд зохицуулж байна. Үнэр амтыг нь тас хориглосон 20 улс байна. Мөн 40 гаран улс бол энэ электрон тамхийг бүүр улс эх орондоо татахыг хориглочихсон байгаад байна. Гээд ингээд тоо статистик дүнгүүдээс харахаар бид нар энийг бас зохицуулахгүй бол цаашаа энэ хорт зуршил даамжрах нь гэсэн ийм асуудал байгаад байгаа юм. Тэгээд сайн үр дүн юу вэ гэхээр тухайн улсуудад энэ эрх зүйн орчныг бий болгосноороо энэ хэрэглээ тамхины вепингийн хэрэглээ нь хамгийн багадаа 6 хувь, хамгийн ихдээ 34 хувь буурчихсан байна аа. Ингээд сайн жишээнүүд бас байна. Тэгээд хэн эрүүл мэндээ хохироохыг бодох вэ? Бүгдээрээ бодъё. Хэн эрүүл мэндээ хохироохыг бодох вэ? Янжуур тамхинаас гарахын тулд веп хийж байгаа. Вепинг хийдэг гэж ярьж байгаа нь буруу. Анхнаасаа бид нар зохицуулаагүй учраас энэ вепингийн хэрэглээг зуршил болгочихлоо. Бид нарын алдаа он жилүүдийг алдсан байна. Одоо нэгэнт мэдчихсэн юм чинь төгс биш юм аа гэхэд тодорхой хэмжээнд шийдье гээд зохицуулах гэж байна. Энэ олон гишүүдээс нөгөө талд нь аргумент хэлж байгаа гишүүдийн зарим нь энэ үнийг ярьж байна татварыг ярьж байна. Ямар ч улстай харьцуулахад хамгийн бага түвшинд байгаа шүү. Ямар ч улстай харьцуулахад.

Хоёрдугаар нэг шалтгаан огцом нэмэхгүй байгаа. Жигд нэмээд нэмээд эцэстээ аль ч улсаас өндөр гарахааргүй байгаа. Тэгээд бүгдээрээ томчуулаа больё. Сонголтоороо өөрсдийгөө хордуулж байгаа бол үр хүүхдүүдээ хорт зуршлаас хамгаалъя л гэж уриалж байна. Юуг нь нэг их бодоод байгаа юм. Зохицуулахдаа харин зөв л зохицуулцгаая тал талаас нь нухацтай хандъя. Зохицуулах нь зөв гэдэг дээр хатуу байр суурьтай байна аа.

Н.Учрал: Даваагийн Цогтбаатар гишүүн үг хэлнэ. Индэр дээр.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд энэ тамхины хяналтыг сайжруулахтай холбогдуулж оруулж ирсэн энэ асуудлыг бол хуулийнх нь хүрээнд дэмжиж байгаа. Тэгээд энэ ажлын хэсэгт бас баярлалаа гэдгийгээ илэрхийлж байна аа. Тэгээд бид нар өөрсдөө маш цөөхүүлээ ард түмэн. 3 сая 500 мянгахан хүнтэй. Тэгээд тэрийгээ бид нар 500 метр ч бай, 50 метр ч бай заавал тамхи зарж байж амьжиргаагаа залгуулах шаардлага байхгүй л гэж үзэж байгаа юм.

Тамхи зарахгүйгээр бид нар амьжиргаа зар явахгүй байна гэдэг бол энэ өрөөсгөл ойлголт оо. Бид нар энэ электрон тамхи гээд энэ технологид суурилсан шинэ хорыг 2 гуравхан жилийн өмнө 4700-г оруулж ирдэг байсан бол одоо бүүр саяар яригддаг болсон. Яг ямар нэгэн ийм навчит ургамал буюу энэ янжуур тамхийг 3.1 тэрбум ширхгийг хэрэглэдэг байсан. Одоо тэр нь өсөж явсаар байгаад 3.5 тэрбум ширхэг болж байгаа юм. Бид нар хойч ирээдүйгээ хамгаалахын тулд өнөөдөр энэ хуулийг бүүр тас хорих чиглэлд нь батлах ёстой. Яг тойрогтоо очиж ажиллаад Баянхонгор аймаг, Өвөрхангай аймаг, Архангай аймагт очоод ажиллахад ээжүүд, эмэгтэйчүүд тэр дундаа яг хэлж байгаа юм. Хүүхдүүдтэй өдөр тутамдаа тулж ажиллаж байгаа хүмүүс бол энэ тамхины асуудлыг тэр чигт нь хорьж өгөөч л гэдэг ийм хүсэлтийг илэрхийлж байгаа.

Өнөөдөр бид нар дахиад хорт хавдар гэдэг энэ асуудалд нийгмээрээ нэрвэгдэж байгаа. Энэ нэрвэгдэж байгаа асуудал дээр яг хорт хавдар нь тусаад үхэл амьдралын зааг дээр ирэхэд энэ тамхи гэдэг хорноос маш эрт салах ёстой

байсан гэдгээ ухаараад л маргааш нь байна уу? Ингээд л хорвоогийн мөнх бусыг үзүүлэх юманд заавал бид нар энэчээ хэлэлцүүлэг хийгээд бид нар 500 метрээр хорьё, 50 метрээр хорьё, гудамж талбайд татъя гэдэг юмны тас эсрэг энэ хуулийг баталж байж бид нар ирээдүй хойч үе яах вэ өнөөдөр татаад явж байгаа өнөөдөр хэрэглэж байгаа улсуудыг буруутгах аргагүй. Ирээдүй хойч үеийн энэ хорт зуршил, энэ тамхи гэдэг хорноос салгахын тулд өнөөдөр 126 гишүүн сайн муу юу гэж дуудуулна хамаа байхгүй. Ганцхан хорих чиглэлд болиулах чиглэлд ажиллах ёстой. Эдийн засгийн аргаар дэмжээд буюу энэ татвар ноогдуулаад тамхидалтыг багасгах энэ тамхидалтыг өдөрт 3 татдаг бол нэг татдаг, нэг татдаг бол бүүр байхгүй болгох чиглэлд эдийн засгийн аргаар өнөөдөр дэмжих ёстой гэдэг ийм байр суурь илэрхийлж байгаа.

Тэгээд энэ хуулийг дэмжиж үг хэлж байгаа. Баярлалаа.

Гишүүд урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлж дууслаа.

Үдээс өмнөх чуулганы хуралдаан завсарлаж байна. 14 цагт чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Н.Учрал: Үдээс хойших нэгдсэн хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Гишүүд танхимдаа орж ирнэ үү. Санал хураалтаар үргэлжилнэ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэхээр санал хураалт явуулна аа. Гишүүдийг танхимд урьж байна.

Тамхины хяналтын тухай хуулийг санаачилсан 78 гишүүнийг танхимд урьж байна. Тамхины хяналтын тухай хуулийг санаачлагч 78 гишүүн хаачив. Хуулиа санаачилчихна, тэгээд хуулиа өөрсдөө шүүмжилнэ, тэгээд санал хураана гэхээр орж ирэхгүй. Энэ чинь өөрөө өөрөөсөө асуулт асууна. Энэ чинь 78 хүн хариулах боломжтой хууль шүү дээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг дэмжих санал хураалт явагдана аа. Номинчимэг гишүүн нарын санаачилсан хууль. Ер нь үе үеийн парламентад манай ийм цог жавхаатай эмэгтэйчүүд л ийм хуулийг барьж авдаг юм шүү. Манай Номинчимэг гишүүн шиг зоригтой бас асуудлын гүн рүү орж асуудлыг шийдье гэдэг эрмэлзэлтэй тэр жил манай 2016 онд надтай өрсөлдсөн манай Эрдэнэчимэг гишүүн. Энэ хуулийг санаачилсны ач буянаар дотор хаана ч тамхи татахгүй нөхцөл бүрдсэн шүү. Тамхины хяналтын хууль дээрээ хэлэлцэх эсэхийг дэмжиж аваад ажлын хэсгээ байгуулъя. Ажлын хэсгийг би түрүүн хэлсэн. Энэ ажил амьдрал ойлгодог хүмүүсээр ахлуулж ажлын хэсэгт ажиллуулна аа, олон болзолтой. Тэгээд Идэрбат гишүүнийг ахлаач гэж би хэлсэн. Дотор нь манай энэ аймгийн дарга байсан дүүргийн дарга нь байсан тамхи татдаггүй ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийг оруулна.

Манай Сандаг-Очир гишүүн маань байна. Тамхи татахгүй дээрээс нь ашиг сонирхлын ямар ч зөрчил байхгүй хариуцлагатай. Тэгээд БНД-ийн Засаг даргаар ажиллаж байсан. Тэр 500 метр худлаа гэдгийг маш сайн мэдэж байгаа хүн. Манай Хан-Уул дүүргийн Засаг даргаар ажиллаж байсан манай Алдаржавхлан дарга

байна. Манай СХД-ийн Засаг даргаар ажиллаж байсан Алтаншагай гишүүн маань байна. Бас тамхи татахгүй, ашиг сонирхлын зөрчил байхгүй. СХД-т 500 метр худлаа гэдгийг маш сайн мэдэж байгаа. Манай Сонгинохайрханд олон сургууль, цэцэрлэг баригдсан. Тэгээд юун 500 метр. Энэ чинь ойр ойрхон сургууль цэцэрлэгтэй. Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг хамгийн их нэмэгдүүлсэн дүүрэг. Тэгээд манай Сонгинохайрханы Засаг даргаар ажиллаж байсан Алтаншагай дарга орно. Манай дүүргийн Засаг дарга Хөххүүгийн Болормаа гишүүн орно. Бас тамхи татахгүй, ашиг сонирхлын зөрчил байхгүй. Олон жил дүүргийн Засаг даргаар ажиллаж олон удаа ялалт байгуулсан Болормаа гишүүнийг оруулна. Өөр чинь хэн байна. Бейсен ахыг бас оруулж болно шүү. Бейсен гишүүнийгээ оруулж болно. Түрүүн манай Ганбаатар гишүүн бол энэ тамхины талаар маш сайн судалгаа хийсэн хүн байна гэдгийг хэлсэн үгнээс нь та нар сонссон. Яг химич хүн шиг шинжлэх ухаанч үндэслэлүүдийг ярьж байгаа. Тэгэхээр Ганбаатар гишүүн болж байна. Манай Өмнөговийн засаг дарга байсан манай Сэддорж дарга бас орох болзлыг хангасан.

Ингээд ер нь аймаг дүүргийн дарга нараас бүрдсэн ажлын хэсгийг оруулж болно оо тийм. Тэр ЧД-ийн Засаг даргаар ажиллаж байсан манай Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн ажлын хэсэгт орно оо бас, тамхи татахгүй. ЧД-т Засаг даргаар ажиллаж байхдаа бас 500 метрийн асуудлыг харж амьдрал дээр ойлгосон ийм бас орон нутгийн амьдрал мэддэг хүн шүү. Ингээд ажлын хэсэг ерөнхийдөө бүрдлээ. Манай Дундговийн Засаг дарга Мөнхбат дарга, ингээд аймаг, дүүргийн дарга нараас бүрдсэн ажлын хэсгийг байгуулаад энэ олон төрийн бус байгууллагуудтай ажиллана аа. Өөр гишүүдийг оруулна.

Тэгээд би бол Их Хурлын даргын хувиар тамхи татдаггүй хүний хувьд анхаарч ажиллана аа. Номинчимэг гишүүн ингээд таны санаачилсан хууль бол ер нь олон талын оролцоог хангаж батлагдах нөхцөл бүрддэг юм шүү. Тэгэхдээ иргэдийн санал бодлыг сайн сонсох хэрэгтэй. Энэ бизнес эрхлэгч нарын, хувийн хэвшлүүдийн сонирхлын бүлгүүдийн саналуудыг сайн тусгах хэрэгтэй. Өргөн олноороо хэлэлцүүлэг хийх хэрэгтэй. Ингэж байж энэ хуулийг батална. Манай Баянхонгорын Засаг даргаар ажиллаж байсан Жаргалсайхан гишүүн бас бүх болзлыг хангаж байна. Энэ ер нь нэлээн чадварлаг баг бүрдлээ шүү.

Үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэллээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдээр гишүүд асуулт асууж тэгээд урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үгээ хэлсэн. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг нарын 78 гишүүн 9 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хууль.

Хуулийн төслөөр санал хураалт явуулахад бэлтгэе.

Санал хураалтад дахиад бэлтгэе. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах хуулиар хэлэлцэх эсэхийг дэмжигдсэний дараа саяын ажлын хэсэг байгуулагдаад тэгээд хэлэлцүүлгүүдээ зохион байгуулна. Мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оруулсан ажлын хэсэг мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ, олон нийтэд зөв мэдээлэл өгнө. Ингээд 7 хэмжиж нэг огтолж байж энэ хуулийг батална. Тэрнээс биш одоо ингээд нэг шуургангаар батлахгүй ээ. Энэ олон талын эрх ашгийг хангаж байж бас хуулийг нэг мөр хэрэглэх бололцоотой хууль батлах ёстой. Тийм учраас шууд батлагдахгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Ажиллах

хэрэгтэй, ажлын хэсэг сайн ажиллах хэрэгтэй. Гэхдээ хэлэлцэх эсэхийг бол Их Хурал дэмжих хэрэгтэй гэдэгтэй бол манай хууль санаачлагч 78 гишүүн бол нэг бодол санаатай байгаа байх аа гэж итгэж байна.

Ингээд бүртгэлийн санал хураалт эхлээд явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

Одоо Байнгын хорооны саналаар Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар Санал хураалт явуулна. Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалт.

55 гишүүн зөвшөөрч 34 гишүүн татгалзсан байна. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

61.8 хувийн саналаар дэмжсэн байна аа.

Үргэлжлээд хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр санал хураана.

ЭМД-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

52 гишүүн дэмжиж, 37 гишүүн татгалзсан байна 58.4 хувийн саналаар ЭМД-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

53 гишүүн зөвшөөрч, 36 гишүүн татгалзсан байна 59.6 хувийн саналаар Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

54 гишүүн зөвшөөрч, 35 гишүүн татгалзсан байна 60.7 хувийн саналаар Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

52 гишүүн зөвшөөрч, 37 гишүүн татгалзсан байна.

58.4 хувийн саналаар Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

59.6 хувийн саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

48 гишүүн зөвшөөрч, 41 гишүүн татгалзсан байна.

53.9 хувийн саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Батбаярын Жаргалан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлье.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

53 гишүүн зөвшөөрч, 36 гишүүн татгалзсан байна. 59.6 хувийн саналаар Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Их хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

53 гишүүн зөвшөөрч, 36 гишүүн татгалзсан байна. 59.6 хувийн саналаар Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай их хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

55 гишүүн зөвшөөрч, 34 гишүүн татгалзсан байна. 61.8 хувийн саналаар Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг

анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Даргын зөвлөл дээр санал дэмжигдсэнтэй холбогдуулаад мөн Засгийн газрын гишүүд томилогдсонтой холбогдуулж Засгийн газрын гишүүн нэг Байнгын хороонд ажиллах Дэгийн хуультай.

Ингээд зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн даргаас ирүүлсэн.

Үүнтэй холбогдуулаад дараагийн асуудалд оръё.

14.24 цаг

[Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.](#)

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам эвслийн бүлэгтэй зөвшилцөж Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгээс ирүүлсэн санал.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Жигжидийн Батжаргал, Гонгорын Дамдинням, Загджавын Мэндсайхан нарыг Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны, Хассуурийн Ганхуягийг Улсын Их Хурлын Өргөдлийн болон Төсвийн байнгын хорооны, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Отгоны Саранчулуун нарыг Улсын Их Хурлын ТББХ-ны, Ням-Осорын Учрал, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын ХЗБХ-ны, Жадамбын Бат-Эрдэнэ, Буяагийн Тулга нарыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайханыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Дашзэвэгийн Амарбаясгалан, Жадамбын Бат-Эрдэнэ, Хассуурийн Ганхуяг нарыг УИХ-ын. БОХХАА-н байнгын хорооны, Отгоны Саранчулууныг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны, Жигжидийн Батжаргал, Ням-Осорын Учрал нарыг Улсын Их Хурлын ТББХ-ны, Нанзадын Наранбаатарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Сайнбуянгийн Амарсайхан, Гонгорын Дамдинням, Лхагвын Мөнхбаатар,

Буяагийн Тулга нарыг Улсын Их Хурлын ХЗБХ-ны, Лувсанцэргийн Энх-Амгаланг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн Улсын Их Хурлын МАН-ын бүлгийн даргын ирүүлсэн саналыг үндэслээд та бүхэнд танилцуулж байна аа.

Одоо зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Их хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулъя аа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд танхимд цуглая.

Өмнө нь Их хурлын дарга, Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан хүмүүс гишүүд чөлөөлөгдсөн тул зарим нь 2 Байнгын хороонд орох ёстой. Засгийн газрын гишүүнээр томилогдсонтой холбогдуулаад зарим гишүүд нэг Байнгын хороонд орно. Ингээд Их Хурлын дарга, бүлгийн дарга нар бол ТББХ-нд орох ёстой гээд ингээд үүнд үндэслэсэн саналыг МАН-ын бүлэг илгээсэн.

Ирц ямар байна. Улсын Их Хурлын гишүүдийг танхимд урья. Үүний дараа нэн яаралтай горимоор Их Хуралд өргөн мэдүүлсэн цаг хугацаатай уралдаж байгаа асуудал Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийг хэлэлцэнэ.

Энэ цаг мөчид бол 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэлийг Тэмүүлэн гишүүнтэй ажлын хэсэг саналуудаа нэгтгэж байна. Тэгээд бид нар хуулиараа маргааш энэ 5 жилийн үндсэн чиглэлийг батлах хуультай.

Тэгэхээр шаардлагатай бол энэ нэн яаралтай горимоор хэлэлцэж байгаа хуулийн дараа 5 жилийн үндсэн чиглэлийг үргэлжлүүлж хэлэлцэх шаардлагатай байгаа. Ажлын хэсэг хэрвээ хуралдаж дуусвал. Улсын Их Хурал дээр бол олон өргөдөл гомдлууд ирдэг. Иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудаас ч гэсэн олон шаардлагуудыг хүргүүлж байна. Ди парламент дээр 100 мянган хүн саналаа өгчихсөн асуудлууд бас хүлээгдэж байна. Тэгэхээр энэ асуудлуудыг бид нар Их Хурал дээр орж хэлэлцэх хэрэгтэй. Нэгд бол тэр Батхүү өмгөөлөгчийн санаачлаад яваад байгаа тэр үл хөдлөх хөрөнгийн татварын нөгөө 2 хувийн асуудлаар 100 мянган хүн гарын үсэг цуглуулсан байна. Тэгээд энэ асуудал орхигдчихоод байна.

Тэгэхээр энийг энэ асуудлыг нэгтгээд Их Хурал хэлэлцэх хэрэгтэй. Тэгэхээр Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд энэ асуудлыг Их Хурал дээр оруулж ир гэж төсөв дээр ажлын хэсэг байгуулагдсан удаан байна, удаан байна. Ажлын хэсэг байгуулагдаад анхааралтай ажигласаар байтал энэ чинь амьдрал үргэлжлээд байна. Тэгээд тэр ард сууж байгаа хүмүүс ажлын хэсэг байгуулагдсан анхааралтай ажиглаж байгаа гээд анхааралтай ажиглаж байхад дэлхийн дэг журам өөрчлөгдөж байна шүү дээ нөхөд өө. Тэгэхээр тэр татварын 2 хувийн асуудлыг энд хэлэлцмээр байна.

Хоёрт энэ ахмадууд тэтгэвэр барьцаалсан зээлийн 24 сарыг 36 сар болго гээд энэ гар утсаар дүүрэн мессеж. Би энэ дээр тэр санхүүгийн тооцоолол хийлгэж байгаа юм. Энэ асуудлыг Их Хурлын Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцэж оруулж ирнэ ээ. Тэрнээс биш арилжааны банкнуудыг бодоод сууж байдаг юм гэж байхгүй шүү.

Арилжааны банкнуудыг нэг тэтгэх тэжээх ёстой юм шиг нэг ийм үүрэг хүлээчихсэн. Тэгээд энэ нэг 24 сарын 36 сар болох асуудлыг шийдэх ёстой тэгээд би санхүүгийн тооцоолол хийлгэж байгаа юм. Тэгээд үйлдвэрчний эвлэлтэй ч ярина. Одоо манай Эрдэнэбат гишүүн ч гэсэн энэ асуудал дээр хамтарч ажиллана. Тэгээд бүгдээрээ энэ асуудлыг нээлттэй яриад нэг 36 сар болговол ядаж энэ сар болгон оногдоод байгаа зээлийн ачаалал нь буураад эхлэхээр тэр мөнгө төгрөг чинь эцэстээ энэ ард түмний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнд л зарцуулагдана шүү дээ.

Тэгээд тооцоолол хийлгэсэн инфляц тийм их өдөөгөөд байх юм байхгүй юм байна лээ. Хэдэн арилжааны банкнуудтай нэг үг ярьж чаддаггүй нэг хэдэн хүн цуглачихсан. Тийм учраас энэ банкны эрх ашигтай холбоотой хэнийг ч энэ Монгол банкны ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч дээр Их Хуралд томилохгүй шүү.

Одоо тэгэхээр банк хөрөнгийн зах зээл гэсэн 2 тулгууртай эдийн засаг руу шилжинэ ээ. Тийм учраас энэ ТӨК-ийн хуулийг одоо энэ Их Хурал энэ чуулганаар батлах хэрэгтэй. Тэгээд Засгийн газар тэр ТӨК-а нэгтгэх нийлүүлэх нээлттэй болгох тогтоолоо оруулж ир. Тэгээд энэ чуулганы завсарлагаанаар тэр нээлттэй болгох, нэгтгэх, нийлүүлэх ажлаа оруулж ирээд ирэх хаврын чуулганаар Их Хурал тайлагна. Тэгээд ингээд хариуцлагатай ажиллахгүй бол цаг хугацаа хүлээгдэж байна аа. Их Хурлын гишүүд танхимдаа орж ирье.

Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

Гишүүд анхааралтай энэ Их Хурлын ажил явж байгаа. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах Их Хурлын тогтоолын төслийг Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.4-д заасны дагуу 22.1.3-д заасан саналыг үндэслээд Байнгын хорооны бүрэлдэхүүнийг тогтоолоор батлах хуулиар хүлээсэн үүрэгтэй.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

47 гишүүн дэмжиж, 43 гишүүн татгалзсан байна.

52.2 хувийн саналаар Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Их Хурлын тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье.

Тогтоолын төслийн эцсийн найруулгыг сонсгох уу?

Эцсийн найруулга. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа эсэхийг тодруулъя. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Тогтоолын төсөл батлагдлаа.

14.34 цаг

Хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлье ээ. [Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл. Засгийн газар](#)

2025 оны 11 сарын 25-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн. Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэн яаралтайгаар хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул өнөөдөр хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя аа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт урья.

Г.Дамдинням: Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1-ийн есөд газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэх шаардлагатай Улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна аа гэж заасан. Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Засгийн газар болон нийлүүлэгч компаниудаас тус улсын дотоодын зах зээлийн нөхцөл байдал, эрэлт нийлүүлэлттэй холбоотойгоор гаргасан экспортын хязгаарлалт, үйлдвэрлэлийн процесс, ээлжит засвар, төлөвлөгөөт ажлаас шалтгаалсан нийлүүлэлтийн хэмжээний бууруулалт зэрэг арга хэмжээнүүд нь манай улсын шатахууны хангамжийн тогтвортой байдалд шууд нөлөөлж, тасалдал, хомсдол үүсэн, эрэлт нийлүүлэлтийг эрэлтийг нэмэгдүүлж үнийн хэлбэлзлийг бий болгосоор ирсэн. Улс орны нийгэм, эдийн засгийн засаг, уул уурхай, үйлдвэрлэлийн өсөлттэй холбоотойгоор манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2023 онд 2.4 сая тонн, 2024 онд 2.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн тус тус импортыг хэрэглэж өмнөх оны мөн үеэс даруй 21 хувиар өссөн бол 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийт импортын хэмжээ 2.3 сая тоннд хүрээд байна аа.

Ард иргэдийн өргөн хэрэглээний 92 авто бензиний хэрэглээ 2024 онд сард дунджаар 60 мянган тонн байсан бол 2025 онд сард дунджаар 80 мянган тоннд хүрч өсөөд байгаа боловч ОХУ-ын Роснефть компанитай хийсэн гэрээний хүрээнд хөнгөлөлттэй үнээр буюу 705 ам.долларын тогтмол үнээр нийлүүлж буй энгийн 92 авто. Бензиний сард нийлүүлэх хэмжээ тодорхой шалтгааны улмаас 60 мянган тонноор хязгаарлагдаж нэмэгдүүлэх боломжгүй боломжгүй нөхцөл байдалтай байна.

Мөн уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлтийг дагаад дизель түлшний хэрэглээ сард 140 мянган тоннд хүрч байгаа тул хэрэглээнд дутагдаж буй 20 мянган орчим тонн АИ 92 авто бензин 25 мянга орчим тонн дизель түлшний хэрэглээг бусад эх үүсвэрээс буюу БНХАУ-аас худалдан авч хангах нөхцөл байдал үүсээд байна. Шатахуун хангамжийн тогтвортой байдлыг хангах улсын хэмжээнд байгаа 30-аас доошгүй хоногийн тогтмол нөөцтэй байх, нөөцийг бүрдүүлэх, хадгалах савны хүчин чадал багтаамжийг нэмэгдүүлэх хүрээнд импортлогч борлуулагч ААН-үүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, шуурхай шийдвэр гаргах эрх зүйн зохицуулалттай болох шаардлага зүй ёсоор тулгарч байна аа.

Иймд олон улсын худалдааны нөхцөл байдал гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан дотоодын зах зээл дээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн болох шатахуун хангамж нийлүүлэлтэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тасалдал, хомсдолоос урьдчилан сэргийлэх, даван туулах арга хэмжээг тодорхойлох, нөөцийг бүрдүүлэх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргахтай

холбогдсон харилцааг зохицуулах зорилготой. Стратегийн ач холбогдол бүхий хэрэглэ бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж танилцуулж байна аа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Баярлалаа.

Н.Учрал: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн танилцуулна аа. Индэрт урья.

С.Цэнгүүн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар яаралтай хэлэлцүүлэхийг дэмжиж, Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа тус хуулийн төслийг хэлэлцээд үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно оо.

Монгол Улсын Засгийн газраас хуулийн төслийг олон улсад өрнөж байгаа худалдааны болон тарифын бодлого зохицуулалтын өөрчлөлт зарим улс орон авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээ зэрэг арга хэмжээний сөрөг нөлөөллөөс үндэсний эдийн засаг, санхүүгийн байдлаа хамгаалах, төлбөрийн тэнцлийг хангах, эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулах хямралаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэл хохирлыг бууруулах, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн шийдвэрийг тооцон гаргаж эрх зүйн зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзэн өргөн мэдүүлжээ.

Тухайлбал стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээг нийлүүлэгч талаас 50 болон түүнээс дээш хувиар бууруулсан тохиолдолд дотоодод шатахууны нийлүүлэлтэд хомсдол тасалдал үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэж, нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар Засгийн газар холбогдох арга хэмжээг авах бөгөөд улмаар шуурхай штаб байгуулж импортлогч ААН-үүдэд бөөний агуулахад хяналт тавих, импортын шатахууныг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах хэмжээг тогтоох ажлыг шуурхай зохион байгуулна аа.

Мөн Монгол банк стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих зорилгоор ААН-үүдэд эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд олгох, мөн хадгалах агуулах, шилжүүлэх, ачих байгууламж, дэд бүтцийг шинээр барих өргөтгөхөд шаардагдах санхүүжилтийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох эсвэл гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авах зэрэг зохицуулалтыг тус тус тусгасан байна. Хуулийн төслийг D.Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байна аа.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл хууль батлагдсанаар гарах үр дүнгийн талаар, дотоодод үүсээд байгаа шатахууны нийлүүлэлтийн хомсдол, тасалдлын нөхцөл, шалтгааны тал талаар, хариуцсан яам ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд Энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд Төв банк Монголбанкны үйл ажиллагаанд хориглосон тухайлсан хуулийн этгээдийн үнэт цаас худалдаж авах баталгаа гаргах зэрэг санхүүжилтийн арга хэмжээ хэрэгжүүлэх нь зохистой эсэх талаар санхүүжүүлэх эх үүсвэр мөнгөн дүн нь тодорхой биш байгааг анхаарах, Засгийн газар төв банканд өрийн дарамт үүсэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж хууль хэрэгжиж эхэлснээс үүсээд байгаа шатахууны хомсдол, тасалдлыг хэдий хугацаанд шийдвэрлэх талаар хууль батлагдсанаар гарах үр дүнгийн талаар, аймаг орон нутагт харилцан адилгүй, ялгаатай байдлаар хомсдол, тасалдал үүсэж байгаа шалтгаан, нөхцөлийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад 65 хувийн саналаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Цэнгүүн гишүүнд баярлалаа. Энэ чуулганы танхимыг үзэж сонирхохоор хүүхдүүд ирсэн байна шүү. Энд нөгөө нэр гараад Их Хурлын гишүүн тэрний урилгаар тэр ирсэн байна гээд би уншъя л даа. Болох юм уу? Дараагийн хурлаас энэ дээр ингээд нэрийг нь гаргаад би Их Хурлын гишүүн тэрний урилгаар тэр дүүргийн тэр ирсэн байна. Сурлагын өндөр амжилт хүсье энэ тэр гээд уншвал гишүүддээ ч тэр энэ оролцож байгаа хүмүүст ч тэр бас сэтгэгдэл өндөр үлдэнэ шүү дээ тийм биз дээ. Би дараагийн чуулганаас тэгж уншъя аа тийм боломж олгоорой.

Баярлалаа. Энэ хүүхдүүд ингээд хөөрхөн байгаа байхгүй юу. Баярлалаа.

Хэлэлцэх асуудалд оръё оо. Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс нэрс ирүүлсэн байна аа. Ажлын хэсгийн гишүүдийг эхлээд би танилцуулъя.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн ажлын хэсгийг танилцуулъя.

Засгийн газрын гишүүн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Чулууны Хишигдалай, Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны Гэрээ эрх зүй гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал Пүрэвдоржийн Мөнхбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох, АМГТГ-ын Газрын тос, бүтээгдэхүүний хэлтсийн дарга

Чулуунбаатарын Чулуунбат, АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Даваахүүгийн Даваабаяр. Ажлын хэсгийг танилцууллаа.

Пүрэвдорж гишүүнийг нэмье. Энэ нөгөө бүлгээс ирсэн юм байна шүү. Пүрэвдорж гишүүн би таныг арын хаалгадаад нэмлээ шүү. Энэ нөгөө хэлэлцэх эсэх. 120 минутаар тогтоосон байхгүй юу. Пүрэвдорж гишүүнийг асуулт асуулгая, бас нэг үг хэлүүлье.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна аа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэболд: Хуулийг дэмжиж байгаа. Тэгэхдээ хэдэн тодруулах зүйл байгаа юм Дамдинням сайд аа.

Нэгдүгээрт энэ 3 сар эсвэл 6 сараар шатахуун нөөцлүүрийн сав бүтээхэд бий болгоход ямар хугацаа бас ямар өртөг энд яг зах зээлийн үнэлгээгээр шаардагдаж байгаа вэ? Нэг.

Хоёрдугаарт энд сая Цэнгүүн гишүүний Байнгын хорооны мэдээлэл уншихад хувийн хэвшилд бас боломж олгоно оо. Дэд бүтцийн зээлийн нөхцөлүүдийг нь аль болохоор боломжоор олгоно оо гэж байгаа. Тэгэхээр яг энэ одоо нөөцлөвөр савны хэчнээн хувь нь яг төрийн мэдлийн ТӨК-д, хэчнээн хувь нь хувийн хэвшилд нээлттэй байх юм бэ? Энэ 2 дахь асуулт.

Гуравдугаарт тэр гадаадын эх сурвалж банкны зээлээс гадна гадаад эх сурвалж гэж байгаа. Эндээ ямар нэгэн нөхцөл ямар нөхцөл байх юм бэ? Хугацааны хувьд ч тэр тийм ээ.

Дараагийн асуулт үндэсний аюулгүй байдлын мөрдөгдөж байгаа үзэл баримтлалд 2020 он гэхэд бид нар шатахуунаа дотооддоо 100 хувь хангадаг болно оо гэдэг зорилго тавьчихсан байгаа хэрнээ энэ зорилго биелээгүй.

Ер нь яах вэ бид нар нөгөө гал унтраахаас илүүтэйгээр тодорхой нөөцтэй болдог энэ эдийн засаг дахь савлагаа энэ иргэдийн бухимдлыг эдийн засгийн аюулгүй байдлынхаа баталгааг хангах зорилгоор энэ хуулийг орж ирж байна гэж харж байгаа. Нөгөө талдаа нөгөө үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан зорилго яах вэ. Нөгөө Ерөнхий сайд та 2-ын сая Энэтхэгийн зээлээр баригдаж байгаа төсөл дээр очсон. Ойролцоогоор 50 хувьтай гэж байгаа. Энэ төсөл чинь хэзээ 100 хувьд хүрээд хэзээ шатахуунаа нэрж үйлдвэрлээд хэзээ нийгэмд үр өгөөжөө өгөх юм бэ. Тэгэхээр ерөнхийдөө бол бид нар аливаа бодлогын асуудлыг тэр тусмаа үндэсний аюулгүй байдал өрсөлдөх чадвартай асуудлыг ярихдаа ер нь том зургаараа бол үйл явц ингэж явж байгаа.

Харин одоогийн нөхцөл байдалд асуудлыг шийдвэрлэхийн тулд ийм байдалтай байгаа гэдгээ ингээд макро болон микро түвшинд нь иргэддээ болон хууль тогтоогч нарт маш сайн тодорхой ойлголт өгдөг баймаар байгаа юм.

Төгсгөлд нь одоо энэ саяын ойлгосноор Ерөнхий сайдын ОХУ-д айлчилсан айлчлал бас энэ дээр ойлголцолд хүрээд энэ хуулийн төсөл яаралтай горимоор орж

ирж байгаа юм байна аа гэсэн ойлголттой байгаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлаас шийдвэр гарлаа гэхэд хэдэн сарын хугацаанд энийг барьж байгуулах вэ эс үгүй бол хэдэн жилийн хугацаанд барьж байгуулах вэ гэсэн тодорхой 3 асуултад хариулж өгнө үү.

Н.Учрал: Дамдинням сайд.

Г.Дамдинням: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр бид 3-аас 6 сарын шатахууны хэрэглээгээ бүрэн хангаж хадгалдаг болно оо гэсэн ийм зорилго тавьсан байдаг. Энэ зорилгын хүрээнд бол бид нар юу яасан байгаа юм. Одоогийн байдлаар бол бидний савны хүчин чадал нөөцийн хэмжээ бол дийлэхгүй. 6 сарын хэрэглээгээ хангадаг хэмжээнд хүргэнэ гэвэл бид нар үндсэндээ нэг бараг 3 их наяд орчим төгрөгийн эх үүсвэр хэрэгтэй болно зөвхөн савандаа.

1 сарын хэрэглээний нөөцөө хадгалж чаддаг савтай болно гэдэг нь 200 мянга орчим тонны нөөц хадгалдаг болно оо гэсэн үг. 200 мянга орчим тоннын нөөц хадгалдаг савыг барихад 500 тэрбум орчим төгрөгийн эх үүсвэр хэрэгтэй. Энийг бол ААН-үүд 1.5-аас 2 жилийн хооронд барина. 1 дүгээр асуулт энэ.

Хоёрдугаарт нөөц сав ер нь манай улс 1990 онд ардчилсан тогтолцоонд шилжсэн цагаас хойш энэ салбар тэр чигтээ хувийн хэвшлийн нуруун дээр явж байгаа. Тэгэхээр манай улсад төрийн эзэмшлийн нөөцийн сав гэдэг ойлголт бол батлан хамгаалах салбараас бусдад онцгой байдлын салбараас бусдад байхгүй үндсэндээ бараг 100 хувь хувийн хэвшил дээр явж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Төрийн өмч байх үед бол энэ шатахууны ууршилт гээд бусад асуудлуудаас болоод энэ хулгай зэлгий асуудлууд маш их явдаг байсан юм байна лээ. Тэгээд хувийн хэвшил бол энийг менежментээр бүтэн ингээд аваад явж байгаа. Манай уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж байгаатай холбоотойгоор бид ерөөсөө жилдээ 20 хувийн өсөлттэй хэрэглээтэй болчихоод байгаа юм.

Тэгэхээр бид бол савныхаа хэрэгцээг нэмэгдүүлэх, ААН-үүдэд хувийн хэвшлийн ААН-үүдэд зээл гаргаж тэдний энэ улсынхаа хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр л авч байгаа арга хэмжээ гэж ойлгоход болно. Үндэсний аюулгүй байдлын зорилго дээр байдаг дотоодоосоо хангадаг болно оо гэсэн энэ зорилгын гол урт хугацааны ажил маань бол энэ Дорноговь аймгийн Алтанширээ сумд баригдаж байгаа нефть боловсруулах үйлдвэр. Нефть боловсруулах үйлдвэрийн маань ажил сая 50 хувьд хүрсэн явж байгаа. Бид 2027 оны эхний хагас жилд багтааж дуусгана. Энэ үйлдвэр дууссанаар бүтэн ашиглалтад орсноор бол бид нэг зарим бүтээгдэхүүнийхээ 50 хувийг, зарим бүтээгдэхүүнийхээ 70 хувийг дотооддоо боловсруулж хэрэглэж чаддаг болох юм.

Одоо бид түүхий эдээ бүрдүүлэх тухай асуудлыг ярьж байна. Засгийн газраас надад энэ ажлыг хариуцуулаад ажлын хэсэг гаргачихсан. Холбогдох компаниуд болон ААН-үүдтэй хэлэлцээр хийгээд явж байна. Нөөцийг бүрдүүлэх чиглэлд бол энэ маш өндөр өртөгтэй эрсдэлтэй ажил байдаг учраас бид бас энэ өмнөд хөршийн хөрөнгө оруулагчтай ярилцаад явж байгаа.

Н.Учрал: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: 2, 3 тодруулах юм байна. Хууль зүйн үндэслэлийг нь хуулийн үндэслэлийг нь аваад үзэхээр төсөв болон эдийн засгийн бодлогоороо зохицуулах бололцоотой зүйлүүд харагдаад байгаа. Тэгээд энэ дээр тодорхой асуултууд байна. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн гээд шинэ нэр томъёо гарч ирж байна. Яг энэ хуулийн агуулгыг нь харахаар ерөнхийдөө шатахуунтай холбоотой асуудал байгаа. Тэгтэл дахиад стратегийн орд гэдэгтэй адилхан стратегийн ач холбогдолтой бүх бүхий бүтээгдэхүүн гэдэг ерөнхий агуулгаар оруулж ирдэг нь өөр энэ дотор жишээлбэл стратегийн ач холбогдолтой гэж нэмэх бүтээгдэхүүн байгаа юу? Энийг яг тодорхой зорилгод нь нийцүүлээд ер нь нэрийг нь ерөнхий өгч болоогүй юу гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт нь ер нь энэ хууль дутагдал хомсдол бол Аи 92 бензин түлшний үнийг зохицуулалттай хямдралтай үнээр авдгаас болж ингэж ийм асуудлууд үүсэж байгаа юм. Хэрвээ зах зээлийн горимоороо явдаг байсан бол эрэлт нийлүүлэлтээр үндэслээд арилжааны банкнууд нь ч гэсэн санхүүжилтээ олгоод заавал төв банкны энэ репо санхүүжилтийг ингэж хийх шаардлагагүйгээр зохицуулах боломжууд байсан. Төсвөөрөө энэ шатахууны саваа ч гэсэн өөрсдөө шийдэх ийм бололцоо боломжууд байсан. Тэгэхээр миний өмнө Байнгын хороонууд дээр танилцуулж байсан ярианаас энэ ОХУ-ын Роснефть компанитай хийсэн энэ Аи 92 бензиний үнэ 2028 онд энэ гэрээ нь 5 жилийн гэрээ нь дуусна гэж ойлгосон. Тэгэхээр энийг нөхөх зах зээлийн үнээрээ явахад яамны зүгээс ямаршуу бодлого барьж байгаа вэ? Яг энэ гэрээ дуусахад бид нар энэ зах зээлийн үнэ рүүгээ шилжиж чадах уу үгүй юү гэдэг ийм асуулт байна.

Гуравдугаарт нь энэ Монголбанкны бас бие даасан байдал руу нэг хууль гаргачхаад одоо жишээлбэл өөр салбарын ялангуяа эдийн засгийг зохицуулдаг гол салбаруудын бас үйл ажиллагаанд шууд бас халдмааргүй санагдаад байгаа юм. Тэгээд түрүүн хэлсэн стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн гээд дахиад нэг өөр бүтээгдэхүүн гаргаж ирээд энэ одоо жишээлбэл Монголбанкны гол заалтуудыг бас хүчингүй байх ийм эрсдэлүүд бас харагдаад байна. Энэ талаар асуулт асууя.

Тэгэхээр энэ репо санхүүжилт хийх гэж байгаа бол Монголбанкны тухай хуулийн 23.1.4, 231.5, 23.1.7 дугаар заалтыг хамаарахгүй болгоно оо гээд үнэхээр л яг арилжааны банкнуудад тодорхой зорилгыг нь заагаад репо санхүүжилт хийж байгаа үнэт цаасыг нь худалдаад авч байгаа бол энэ заалтуудыг заавал оруулах шаардлагагүй харагдаад байгаа юм. Жишээлбэл 23.1.4-д нь болохоор хуулийн этгээдийн дүрмийн санд хувь хөрөнгө оруулах, үнэт цаас худалдаж авах энэ харилцаа жишээлбэл энэ үзэл баримтлалаас харагдахгүй байгаа учраас энийг заавал Монголбанкны энэ хуулийг үйлчлэхгүйгээр ингэж хязгаарлах хэрэг байна уу?

Нөгөөдөх нь бас Засгийн газар Монголбанкнаас бусад хуулийн этгээд, иргэн зээл, төлбөрийн болон банкны баталгаа гаргах гээд энэ ААН-үүдэд Монголбанк баталгаа гаргахгүй репо санхүүжилтийн асуудал яригдаж байгаа учраас энэ заалт бас хамаарагдахгүй байгаа харагдаад байна. 23.1.7 дээр бас хуульд зааснаас бусад тохиолдолд хуулийн этгээдэд эдийн засгийн буюу арилжааны давуу тал давуу байдал бий болгон эдийн засгийн тодорхой салбарт зориулсан тэнцлийн болон тэнцлийн гадуурх аливаа хэлцэлд гүйлгээ хийхгүй гэсэн ийм хориглосон заалтыг энэ бүтээгдэхүүн дээр хамаарагдахгүй байхаар заасан байна л даа. Тэгэхээр ингэх шаардлага байхгүй харагдаад байгаа. Арилжааны банкуудаар репо хэлцлээ хийгээд явахад бол энэ хувийн ААН-үүдийн хувь хувьцаа худалдаж авах баталгаа гаргах асуудал гарахгүй харагдаад байгаа. Тэгээд энийг оруулж ирсэн энэ түлшний

асуудал болон савны асуудлаас болоод өөр асуудал байна уу. Энэ талаар тодруулга өгөөч. Баярлалаа.

Н.Учрал: Гонгорын Дамдинням гишүүн хариулна.

Г.Дамдинням: Энэ хуулийн нэршилтэй холбоотой асуудал бол стратегийн нөөц бараа материалын нэр төрөл гэсэн нэр томьёо нь хуульд биш шүү дээ. Улсын Их Хурлын тогтоолд байдаг юм байна лээ. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1.1-д заасныг баримтлаад бид бол энэ өмнө нь хэрэглэгдэж байсан энэ томьёоллоор нь аваад явж байгаа. Энэ дотор бол шатахууны төрлийн бүхий л бүтээгдэхүүнүүдийг бид нар ойлгох ёстой. Энэ хууль зайлшгүй гарах гээд байгаа шалтгаан нь юу вэ гэхээр бидний хэрэглээ огцом өсчөөд байгаа байхгүй юу. Бид ирэх онд 100 сая тонн нүүрс экспортолно. Энэ нь одоо үндсэндээ манай шатахууны хэрэглээг бүх төрлийн шатахууны хэрэглээг шүү 20-оос 25 орчим хувиар өсөх ийм хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл энэ эдийн засгийн тэлэлтийн хурд нь манай шатахууны савны хэмжээнээсээ илүү гарчхаад байна аа.

Хоёрдугаар асуудал бол бид асуултын хувьд бол зах зээлийн үнээр нь явуулах чиглэлд зөвхөн K2 буюу Евро 2 стандартын Аи 92 авто бензин дээр л ОХУ-тай урт хугацааны гэрээтэй 2028 он болтол жил болгон сунгаад явдаг. 705 доллороор 1 тонныг нь авч байгаа. ОХУ-ын дотоод зах зээлээс ч хямдхан үнээр авч байгаа. Энүүгээр бол бид хямдруулж барьж байгаа. Евро стандартын бусад бүх төрлийн бүтээгдэхүүнүүд дээр бол зах зээлийнхээ жамаар ингээд явж байна. шатахууны компаниудын хувьд бол энэ өөрсдөө сав нөөцөө бүрдүүлээд явах чиглэлд бол энэ хурдаа гүйцэхгүй байгаа. Зээлийн харилцааны зохист түвшний харилцаагаа дийлдэггүй учраас энэ анх удаагаа орж ирж байгаа хууль биш. 2022 оны 2 дугаар сард дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн баррель нь 148 ам.долларт хүрч шатахууны үнэ 4500 төгрөг хүрэх нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор бид 2022 оны 4 дүгээр сард гол нэрийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөг бууруулах тухай хууль батлаад ААН-үүдэд Монголбанкнаас репо санхүүжилт өгч 3 сарынхаа хэрэглээг урьдчилж захиалж тогтвортой байдлыг хангаж байсан ийм туршлага байна.

Олон улсын геополитикийн нөхцөл байдал тайван бус байгаа байдал, манай дотоодын хэрэглээний эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор бид шатахууны нөөцийг бүрдүүлэх чиглэлд олон жил би бүүр дахин тодотгож хэлье. Огт авахгүй явж байсан арга хэмжээг нь нэг авчихъя даа л гэж зорьж байгаа юм. Нийлүүлж байгаа импорт хийж байгаа бид нарт экспорт хийж байгаа манай хөршүүдээс ч гэсэн хамгийн түрүүнд тавьж байгаа шаардлага тэр. Савныхаа хэмжээг нэмээч. Урьдчилж аваад хадгалаач. Та нар оруулаад л шууд дамжуулдаг энэ байдлаа болиоч ээ. Тэгэхгүй бол бид нар та нарын энэ тогтмол ха тогтмол хангалтыг хийж чадахгүй байна шүү дээ гэдэг асуулт тавьж байгаа. Энэ зүй ёсны асуудал. Бид нар одоо савны маань хэмжээ байхгүй байгаа учраас бид нар тусгайлсан ийм санхүүжилт гаргаж ААН-үүдээ дэмжихээс өөр арга алга алга. Монголбанктэй холбоотой асуудал дээр нь Монголбанкны төлөөлөл хариулсан нь зөв байх.

Н.Учрал: Энхтүвшин гишүүн тодруулах уу? Ажлын хэсэг Монголбанк нэр албан тушаалаа хэлээд хариулаарай. 4 дүгээр микрофон.

П.Мөнхбаяр: Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол банкнаас Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал Мөнхбаяр гэж хүн байна аа. Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Таны дурдсанчлан Төв банкны тухай хуулийн 23.7 дээр бол яг энэ тухайлсан салбар дээр бол давуу тал үүсгэсэн тийм хэлцлийн болон хэлцлийн бус гадуурх хэлцэл хийхийг хориглосон байж байгаа. Энэ бол яг тухайлсан салбар дээр очиж байгаа санхүүжилт учраас яг энэ энэ заалттай бол хамаарахгүй байдлаар энэ хуулийн зохицуулалтыг оруулах энэ зохицуулалтыг бол хийсэн байж байгаа. Өмнө нь бол энэ түрүүн дурдсан нөгөө ковидын үеэр өмнө нь яг энэ репо санхүүжилтийг бол олгож байсан. Энэ репо санхүүжилтийн нөхцөл хэмжээ бүх зүйлүүдийг бол Мөнгөний бодлогын хорооны хурлаар хэлэлцээд эдийн засагт үзүүлэх нөлөө бүх зүйлүүдийг нь тооцож үзсэний үндсэн дээр санхүүжилтийг ингэж олгож явж байсан ийм туршлага бол бий.

Н.Учрал: Энхтүвшин гишүүн тодруулна.

Д.Энхтүвшин: 2 асуудал тодруулъя. Монголбанкнаас 23.1.4 тэр үнэт цаас худалдаж авах хувийн хуулийн этгээдээс үнэт цаас худалдаж авахтай холбоотой хувийн компанид төлбөрийн баталгаа гаргахтай холбоотой заалтуудыг хэрэглэх шаардлагагүй юм шиг харагдаад байгаа юм. Тэрийг тодруулж өгөөч?

Дамдинням сайдаас бид нарын хөнгөлөлттэй ихийг авна, сав хадгална гэдгийн шаардлага нь бол хямдхан байгаа учраас жишээлбэл үнээр тохирчихсон тогтчихсон 705 доллар гэж байгаа учраас илүү авах хэрэгцээ байгаа юм уу гэж харагдаад байгаа юм. Үгүй гэвэл зах зээлийн зарчмаараа гэвэл тэртээ тэргүй зах зээлээсээ худалдаж авч байгаа учраас энэ асуудлууд бол зах зээлийнхээ өөрийн зарчмаар явах бололцоотой харагдаад байгаа юм.

Гэтэл Роснефтээс бид нар 60 мянган тонноос илүү авч чадахгүй байж байж дахиж нэмж санхүүжилт сав барихын тулд яаралтайгаар ингэж шаардах ийм зохицуулалт хууль батлах хэрэг байгаа юм уу гэдэг асуулт.

Н.Учрал: Ажлын хэсэг хариулна. 4 дүгээр микрофон.

П.Мөнхбаяр: Баталгаа батлан даалтын хувьд бол энэ 23.1.5 дээр бол Монголбанкнаас олгож байгаа баталгаа батлан даалтын асуудлуудыг хөндсөн байж байгаа. Энэ репо хэлцэл өөрөө ямар онцлогтой вэ гэхээр энэ өөрөө банкнуудын банкнууд дээр байгаа тодорхой барьцааны эсрэг Монголбанкнаас санхүүжилт олгоод тэр банкнууд нь цаашаагаа дамжуулаад ААН-үүд дээр санхүүжилтийг олгодог. Энэ ААН-үүд дээр санхүүжилт олгоход бол нөгөө барьцааны хүрэлцээгүй асуудал бол нэлээдгүй тулгардаг. Өмнөх жишээнүүдээс харахад. Тэгэхээр энэ дээр бол Засгийн газар тодорхой хэмжээгээр баталгаа батлан даалт гаргах замаар энэ барьцааны асуудлуудыг бас шийдэх боломжтой юм аа гэдэг агуулгаар энэ хууль дээр бол заалт оруулсан байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Монголбанкнаас баталгаа батлан даалт гэсэн агуулга бол биш нөгөө ААН дээр нь санхүүжилт олгоход баталгааных нь асуудлуудыг.

Н.Учрал: Дамдинням сайд.

Г.Дамдинням: Нөөцлөх шаардлагатай тухай асуудал зайлшгүй болчхоод байгаа юм аа. Бид нарт бидний энд гол нийлүүлэгч бол ОХУ. Нийт нийлүүлэлтийн 95-аас 97 хувийг энэ улсаас авдаг. Энэ улсын маань гадна, дотнын нөхцөл байдал бол бас төвөгшөөлтэй байгаа. Тэгэхээр энэ асуудлаасаа шалтгаалаад 2025 оны 8 дугаар сараас он дуустал АИ 92 авто бензин дотоодын хэрэглээн дээрээ зарим мужууд дээрээ хязгаарлалт тавьчихсан. Дизель түлшнийхээ экспорт дээр хязгаарлалт тавьчихсан. 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээртэй учраас бид бүхэн харьцангуй гайгүй авч байна. 60 мянган тонн АИ 92 авто бензин дээр тогтмол 705 долларын л боломжийг бид гаргаж ярьж байгаа болохоос түүнээс илүү гарсан хэрэглээн дээрээ бид бусад эх үүсвэрээс яг зах зээлийнх нь үнээр авах энэ хэлцлүүдийг хийгээд л ингээд л явж байгаа. Нөөцлөхөөс өөр гарцгүй болчхоод байна аа.

Н.Учрал: Энхтүвшин гишүүн тодруулах уу? Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж асуулт асууна. Дараа нь та бас үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Ингэхээр энэ 2 асуудал байгаа.

Нэгдүгээрт нөөцийн савын асуудал байна. Тэгэхээр 2000 оны эхээр ч байна уу даа. НИК гэж компани байж байхад тэдний бүх нөөцийн савнуудыг бүгдийг нь ашиглалтын шаардлага хангахгүй байна гээд бүгдийг нь акталсан юм. Тэгээд акталсны дараагаар хувьчлал явсан байх. Би тэгж бодож байна. Тэгээд тэрний дараагаар нөгөө акталсан савнууд нь бүгдээрээ зүв зүгээр ашиглагдаад явсан юм.

Хоёр дахь кэйс нь бол Онцгой байдлын ерөнхий газар дээхэн үед бас бензин нь ерөөсөө ууршаад байдаг. Нөгөө нэг нормативасаа хэтэрхий ууршаад алга болчхоод байна. Тэгээд нөгөөдхөө дүүргэдэг нэг тийм ажилтай. Төрд байх дээр нэг ийм л юм болдог юм л даа. Тэгэхээр энэ нөөцийн сав яг ямар статусаар явах юм бэ? Менежментийн гэрээгээр явах юм уу? Хувь хүн оролцоод энэ дээр явах юм бол илүү тэр янз янзын асуудал нь гайгүй болох байх. Төрийн юм гээд л нөгөө ууршуулаад байвал яах вэ гэдэг ийм л асуудал гарч ирэх юм. Тэгээд энэ дээрээ хэр зэрэг шаардлагаа хангаж ажиллах юм.

Хоёрдугаарт нь шатахуун хангамжийн асуудал байна. Энэ маш зөв. Ер нь бид нар энэ ард иргэдээ ингэж нервтүүлж шатахууны очерт оруулж байхын оронд бас тодорхой хэмжээгээр нөөцлөөд тэрүүгээрээ хомсдолтой үед хангах нь маш чухал байгаа.

Дээрээс нь үнийн хувьд ч гэсэн дээр байдаг юм. Жишээ нь өвлийн дизель түлш 705 доллароор орж ирдэг байсан бол сая шатахууны хомсдол үүсээд өдөрт 2 мянган тонныг ачдаг болоод эхлэнгүүт урьд нь мянган тонн байсан юм л даа. Тэгэнгүүт бас давуу талаа ашиглаж байгаа юм уу ингээд 950 доллар болчхож байгаа юм. Бид нар дахиад л үнэ дээрээ алдаж байгаа байхгүй юу даа. Тийм учраас хямдхан байгаа дээр нь бас энэ тодорхой хэмжээгээр нөөцийг бий болгоно гэдэг чинь бас их зөв зүйл гэдгийг хэлье.

Гурав дахь асуудал нь бол энэ Алексей Николаевич ОХУ-ын Элчин сайдтай би энэ баруун бүсэд ажилласан. Өөрөөр хэлбэл баруун бүсээр нефть шатахуун ерөөсөө орж ирэхгүй хаачихсан байгаа. Тэр үед нь очиж ажилласан. Элчин сайдтай хамтарч ажиллаад тэгээд тэрний үр дүнд 100, 100 тонноор өндөр үнэтэй орж ирсэн. Сүүлийн үед харин 1 мянган тонноор зөвшөөрөл өгдөг болоод эхэлж байх шиг

байна. Бид нар баруун бүсээр чинь 120 мянган тоннын шатахууны хэрэглээ байдаг. Тэгээд ийм нөхцөл байдлыг бас нэг шийдэх гэж бас ажилласан. Тэрний үр дүнд бас жоохон жоохон үр дүн гарч байна. Тэгээд энэ нөөцийн сав нь баруун бүсэд баригдах юм уу?

Дээрээс нь Роснефть чинь зөвхөн энэ юугаар оруулж ирдэг байхгүй юу. Энэ Наушкаар Сүхбаатараар оруулж ирдэг. Гэтэл яг тэр баруун бүсээр чинь бол газпром нефть юм уу аль эсвэл жижиг компаниуд шатахууныхаа нийлүүлэлтийг хийдэг. Энэ дээр шууд компаниуд шууд хамтарч ажиллах, өөрөөр хэлбэл дунд нь байдаг янз янзын зуучлагч нар 2, 3 зуучлагч дамждаг. Дээрээс нь төлбөрийн асуудал нь бүүр тэр юуны хаагуур ч билээ Дубайгаар дамжиж явдаг. Төлбөр нь замбараагүй өртөгтэй болчихсон. Өөрөөр хэлбэл одоо энэ чинь нөгөө ОХУ-ын санкцаас болоод төлбөрийн асуудал чинь үнэ өсөхөд маш их нөлөөлж байгаа.

Энэ энэ асуудлуудыг тэр баруун бүсийн хангалтын асуудлыг яаж шийдэж байгаа юм. Өөрөөр хэлбэл эндээс Улаанбаатараас орж ирээд Улаанбаатараасаа 1700 км зөөгөөд Баян-Өлгий аймагт шатахуун борлуулах тухай асуудал яригдаж байна. Гэтэл бид нар цаанаас Бескээс авлаа гэхэд илүү хямдхан цаанаас зургаан зуун тавьхан километр яваад л орж ирэх ийм боломжтой. Гэтэл энд нэг дураараа дургидаг баахан дундын зуучлагч байгаа учраас төлбөрийн асуудал энэ тэрээс болоод маш их өндөр үнэтэй шатахуун хэрэглэдэг. Ийм нөхцөл байдал бий болчихоод байна.

Н.Учрал: Гонгорын Дамдинням гишүүн хариулна.

Нөөцийн сав улсад байж үзсэн юм билээ. Пүрэвдорж гишүүнтэй яг санал нэг байна. Түүхийг нь ингээд төр өөрийн эзэмшлийн нөөцийн сав бариад тэрийгээ тэгээд улсын төсвөөр санхүүжүүлээд аж ахуйн бус аргаар ингээд явахаар хулгайлуулдаг юм билээ. Шатахуун чинь өөрөө их тийм онцлог бүтээгдэхүүн ууршдаг. Тэгээд ууршилт нь тэгээд норм дүрмийнхээ хамгийн дээд хэмжээгээр ууршиж алга болоод ингээд бөөн хулгай зэлгий болдог юм билээ. Тийм болохоор энэ хуулийн үр дүнд бол үндсэндээ ААН-үүддээ л хөнгөлөлттэй зээл олгож савны багтаамжийнх нь хугацаа тоо хэмжээг нэмэгдүүлнэ. Улсын нөөцийн тоо хэмжээг энэ хуулиар хатуу зааж өгнө. Зөрчих юм бол хариуцлага тооцно оо гэсэн зохицуулалтыг оруулж байгаа юм.

Дээрээс нь энэ хуульд орж байгаа бас нэг том зохицуулалтыг бид бас дурдах ёстой. Юу вэ гэхээр сая ингээд АИ 92-ын хомсдол болж байх үед аль ШТС-д хэдий хэмжээний нөөц байгааг бид нар мэдэхгүй. Улсын хэмжээнд байгаа 1800 ШТС-д бид нар ямар нэгэн хэмжих тийм багаж хэрэгсэл байхгүй. Хүн явуулж л хэмжинэ. Өөр ямар ч гарцгүй. Тэгэхээр энэ хууль гаргаж байгаад бид бол улсын хэмжээнд байгаа бүх ШТС-уудад мэдрэгчүүд тавиад хэмждэг тийм бүтэн систем тогтоох гээд байгаа юм.

Энэ ерөөсөө 35 жил огт хийгдэж байгаагүй юм байна лээ. Үнэхээр тэр ШТС-ууд нь юм байгаа байгаа мөртөөсөө зохион байгуулалттайгаар өгөхгүй байна уу хомсдолыг зохион байгуулалттайгаар хийгээд байна уу эсвэл үнэхээр байхгүй болоод байна уу гэдгийг бид бодитой харж чадахгүй байгаа. Тэгэхээр хувийн хэвшил энэ бүгдийг нь энэ мэдрэгчүүд тавьж ийм системтэй болно оо гэсэн ийм зохицуулалт бас энд орж ирж байгаа.

Хоёрдугаарт бол энэ баруун бүсийн шатахууны хангамжтай холбоотой асуудал таны хэлж байгаатай бас яг ижилхэн 8 дугаар сараас хойш үндсэндээ орж ирэхгүй таг гагцхисан. Манай баруун 5 аймаг бол Бискээс баруун талаасаа авдаг байсан, Газпром нийлүүлдэг, эсвэл дундын зуучлагч буюу трейдер компаниудаар оруулж ирдэг байсан. Сая ОХУ-д Монгол Улсын Ерөнхий сайд айлчлах үеэр би ОХУ-ын Эрчим хүчний сайд Цивилев сайдтай уулзаж мөн бас тэр улсын Ерөнхий сайдтай манай Ерөнхий сайд уулзаж Ерөнхийлөгчтэй нь ч бас бидний багийнхан уулзаж тохиролцсон зүйл юу вэ гэхээр баруун бүсээр Роснефть шууд нийлүүлдэг болъёо гэж байгаа юм. Шууд нийлүүлдэг болъёо Бийск рүү өөрсдөө төмөр замаар хүргэе. Ингээд Баруун бүсээр оруулж ирдэг болъёо гэж байгаа юм.

Тэгэхээр энэ бэрхшээл бол удахгүй гайгүй болох байх. Газпромынхон ч гэсэн бас баруун бүсээрээ нийлүүлье. Манай баруун 5 аймгийн хэрэглээ ОХУ-ын хувьд бол хэт бага байдаг учраас заавал дундын зуучлагчидтай байсан. Энийгээ больёо гэж энэ тохиролцоонд хүрсэн.

Н.Учрал: Пүрэвдорж гишүүн тодруулна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр тэр нөгөө бүх шатахууны станцууд дээр хэд нөөцтэй байгаа гэдэг нь ерөөсөө энэ танай байгууллагын тэр үйл ажиллагаатай шууд холбоотой. Жишээ нь баруун 3 аймгийн газрын тосны төлөөлөгч Тогтохбаатарын Ганболор гэдэг залуу ажиллаж байсан. Сум болгонд 2 удаа очиж баруун 5 аймгийн тэр олон сумууд байна шүү дээ жараад сум. Тэрэн дээр очиж бүгдийнх нь тоо хэмжээг авдаг. Тэгээд наашаа илгээдэг тэгээд хяналт шалгалтаа хийдэг. Гэтэл одоо яасан бэ гэх дээр баахан хүнтэй болсон мөртөө зүгээр л нөгөө нэг колонкуудаасаа мэдээ аваад л наашаа явуулдаг. Тэд нарынх нь юу бүх юмнууд нь бүгдээрээ буруу ийм байгаа.

Тийм учраас наадах дээрээ нэг яг энэ шатахууны хангамжийн асуудлыг бүрэн бүтэн байлгах, асуудалгүй байлгах, хомсдолд орсон үед сайн ажиллах.

Пүрэвдорж гишүүн нэмэлт нэг минут авах уу? Хариулах уу? Дамдинням сайд хариулья.

Г.Дамдинням: Пүрэвдорж гишүүний хэлж байгаа саналтай санал нэг байна аа. Энэ улсын хэмжээнд шатахууны төлөөлөгч гээд 19 аймагт л байгаа ганц ганц л хүн байгаа. Бүх ШТС-уудыг хэмжиж мэддэггүй, чадахгүй угаасаа нэг хүн хэдийг нь очиж хэмжих вэ дээ. Тэгэхээр энэ бүгдэд нь тэр мэдрэгч тавьж нэгдсэн зохион байгуулалтаар удирдаж тэгээд энэ АМГТГ-ын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дээрээ хянадаг удирддаг зохион байгуулдаг энэ ажлыг энэ хууль гарснаар бид нар хийх юм. Тэгээд энэ ажил руугаа л яваад байгаа юм.

Н.Учрал: Цэндийн Сандаг-Очир гишүүн асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Саалиа бэлдэхээр саваа бэлд гэж. Энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ харин ч их оройтож орж ирсэн байна. Тэртээ тэргүй сүүлийн 70, 80 жил бид нар чинь одоо ОХУ-аас бензин шатахуунаа зөөсөөр байгаа хэрнээ өнөөдрийг хүртэл 1 сарын л нөөцтэй байх хэмжээний агуулах савтай. Тэгээд өнгөрсөн хугацаанд ийм Монголбанк ийм бололцоо боломж байсан юм бол урьд нь ингээд өмнө нь ингээд ийм боломжийг гаргаад энэ хувийн хэвшлүүддээ дэд бүтцийг нь барьчих нөөцийг нь сав барьчих ийм бололцоо боломж

байгаагүй юм уу? Заавал ингээд бензин шатахуунаар тасалдсан хойно очерлуулж, дугаарлуулж, уурлуулж уцаарласны дараа нь ингэж ийм бололцоо боломжийг гаргаж ирдэг нь ямар учиртай юм бэ гэдгийг нэгд асууя.

Хоёрт энэ гол хуулийн чинь 8.1.1, 1.2 л юм байна л даа. 8.1.1 Энэ газрын тосны бүтээгдэхүүний импортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ААН-д эргэлтийн хөрөнгө шаардах. Энэ хуулийн чинь гол үзэл баримтлал нь энэ мөн юм уу? Эргэлтийн хөрөнгөд бас энэ санхүүжилт ч олгох юм байна шүү дээ. Би ойлгох нь гол нь сав, нөөцийн сав агуулах барихад нь, тэр дэд бүтэц барихад нь ингэж энэ зээлийг олгох юм байна гэсэн чинь ахиад ийм тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдэд эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд нь энэ санхүүжилтийг олгох Монголбанканд эрх өгөх гэж байна л даа. Энэ чинь өөрөө энэ ажлын хэсэгт өрсөлдөөний монополын газраас хүн байна уу? Энэ өрсөлдөөний хуулийг зөрчсөн асуудал гарах уу? Засгийн газар аль нэг бизнесийн тодорхой стратегийн нэрийн доор энэ бензин шатахууны энэ чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийг тусгайлсан ийм хууль гаргах гэж байна шүү дээ. Бизнесийг нь дэмжиж санхүүжилт олгох гэж байна. Энэ өөрөө Монополын тухай, Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн асуудал үүсэх үү үүсэх юм биш биз дээ? Энэ газраас мэргэжлийн байгууллагаас саналыг нь авсан зүйл байна уу гэдгийг.

Гурав дахь асуудал Пүрэвдорж гишүүнтэй санал нэг байна. Ер нь энэ нөөц бүрдүүлээд энэ зээл олгох гэж байгаа дээрээ энэ Монгол Улсынхаа гол гол цэгүүдэд бүсүүдэд энэ зээлийн үйл ажиллагаа явуулах тэр бололцоог нь олгож тэр нөөц агуулах барих тэрийг бас тодорхой хэмжээнд зааж өгөх шаардлагатай байна аа. Зүүн бүс, баруун бүс, хойд бүс, өмнөд бүс гээд ингээд. Тэгэхгүй бол ингээд Улаанбаатар хот дотроо л гол компаниуд чинь үйл ажиллагаагаа явуулаад эргэлдээд Улаанбаатар хот чинь өөрөө аюулын харанга болж энэ тэсэрч дэлбэрэх энэ чинь өөрөө аюултай бүтээгдэхүүн. Тийм учраас энэ ХАА, уул уурхайд гол хэрэглэгддэг дизель түлш АИ 92, 95 хэрэглэдэг энэ газруудад бүс нутгийн зориулалтаар ингэж зохицуулалт хийж яам энэ эрхийг нь бас тэр компаниудад зээлийн санхүүжилтийг олгохдоо бас энэ талыг харгалзаж энэ зээлийг олгох бололцоо боломж байгаа юу гэдэг ийм 3 асуулт асууж байна аа.

Н.Учрал: Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Сандаг-Очир гишүүнтэй бас санал нэг байгаа. Би ажил аваад үндсэндээ 4 сар л болж байна. Тэгээд чуулган маань эхлээд үндсэндээ тэгээд 2 сар орчим болж байна уу даа. Тэгээд хамгийн хурднаараа л ажиллаад оруулж ирж байгаа маань энэ. Би тантай яг ижилхэн бодол байр суурьтай байдаг. Ковидын үед нэг авч байсан энэ арга хэмжээнийхээ хуулийг үргэлжлүүлээд энэ ААН-үүддээ жоохон боломж олгоод явчихгүй яасан юм доо гэж боддог.

Тийм учраас бол энэ хуулийг 5 жилийн хугацаанд буюу манай гол импортлогч орны байдал тогтворжтол мөрдөж хэрэгжүүлж энэ хооронд савныхаа нөөцийг нэмэгдүүлэе гэж зорьж байгаа.

Хоёрдугаарт бол эргэлтийн хөрөнгө гэдэг асуудлыг бас тавьж байна. Эргэлтийн хөрөнгө гэдэгт бол үндсэндээ бид зарим үед үндсэндээ ингээд савныхаа хэмжээгээр буюу 2, 3 сарын хугацааны нөөцийг шууд нэг дор захиалга өгөх боломжийг ААН-үүддээ өгөх гэж байгаа юм. Манай ААН-үүдийг ингээд их том гэж бодоод байх шиг байгаа юм. Эд маань бол нэг ийм тодорхой 1 сарын хэрэглээ

орчмын мөнгийг 12 удаа эргэлдүүлж л явдаг хүмүүс юм байна лээ. Зээл нэмж өөрөө авах гэхээр хэмжээ нь хүрэлцдэггүй.

Тэгэхээр энэ дээр нь бол зүгээр мөнгө өгөх гэж байгаа зүйл биш, зээл өгье. Энд нь засаг бас тусалъя. Ингээд захиалгыг нь авхуулаад савыг нь 1 дүгээрт нөөцөө бүрдүүлэх өөрөөр хэлбэл яг эргэлтийн тэр шатахуун худалдаж авах мөнгөнд нь олон улсын захиалга хийхэд нь мөнгийг нь зээлье.

Хоёрдугаарт саваа барих төсөлд нь зээлье.

Гуравдугаарт саванд шаардлагатай тэр чинь бас төмөр замын орц гарц, галын байгууламж, цахилгаан дулаан гээд олон юм шаардагддаг. Тэр дэд бүтцийг нь хийх байгууламжуудад нь зардал гаргая аа гэсэн ийм утгатай хууль юм байгаа юм. Таны 3 дахь асуултад бол энэ гол бүсүүдэд анхаарч байрлуулах ёстой гэдэг санал нэг байна. Яг хаана гол түлхүү анхаарч өгөх ёстой вэ гэдгийг бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр ажлын хэсэг шийдэж гишүүдийн гаргаж байгаа энэ саналыг бол анхаарч байгаа. Гол хэрэглээгээ дагаж байрлуулна стратегиа бодож байрлуулна. Өмнийн бүс, төвийн бүс, зүүн бүс, баруун бүс гээд. Хойд бүс харьцангуй гайгүй нөөцтэй байдаг. Иймэрхүү байрлалтай байгаа.

Н.Учрал: Сандаг-Очир гишүүн. Дамдинням гишүүнд нэмэлт нэг минут өгье.

Г.Дамдинням: Монгол Улсад одоогийн байдлаар бас иргэдийн дунд ч асуугаад байдаг юм. Энэ тусгай зөвшөөрөл гэдэг юмаа больчооч гээд. Тэсэрч дэлбэрэх аюултай энэ бүтээгдэхүүн дээр бол тусгай зөвшөөрөл норм дүрэм, стандарт бариулахаас өөр аргагүй. Сайдын хувьд яамны хувьд тусгай зөвшөөрөл хүссэн шаардлага хангасан бүхэнд нь өгч байгаа. Би сайдаар ирснээс хойш ер нь 20, 30-ийг өгчихсөн байгаа байх. Улсын хэмжээнд 160 гаруй импортын зөвшөөрөлтэй ААН-үүд байна. Энэ ААН-үүдэд бүгдэд нь тэгш боломж олдоно. Хэн шалгуур хангаж байна тэр нь аваад л явна. Ямар нэг байдлаар өрсөлдөөн хязгаарлах зүйл байхгүй.

Н.Учрал: Сандаг-Очир гишүүн нэмэлт тодруулга.

Ц.Сандаг-Очир: Энэ эртээд Монгол Энэтхэгийн парламентын бүлгийн гишүүд бид нар Энэтхэгийн элчин сайдтай уулзсан юм. Тэгээд энэ газрын тосны үйлдвэрийн явцын талаар зарим нэг саналыг нь сонсоход энэ манай энэ үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд дээр гаалиас орж ирж байгаа гаалийн бүрдүүлэлт дээр асар их цаг хугацаа авч байна аа алдаж байна аа. Энийг Засгийн газар, Их хурал бүлэг ярьж яаравчлах асуудал дээр дэмжлэг үзүүлж өгөөч гэж албан ёсоор сан санал тавьж байна лээ.

Тэгэхгүй бол энэ нөгөө 2027 онд ашиглалтад орно гэж одоогоор ярьж байгаа энэ газрын тосны үйлдвэрийн чинь үйл ажиллагаа энэнээс болж асар их цаг хугацаа алдаж байна. Энэн дээр ажилладаг тэр боловсон хүчнүүдийн визийн мэдүүлгийг нэгхэн жилээр өгдөг. Энийг ядаж 2-оос 3 жилээр өгдөг байх асуудал дээр нь Монгол Энэтхэгийн парламентын бүлгийн гишүүд холбогдох газарт нь асуудлыг тавьж шийдүүлж өгөх тал дээр онцгой анхаарал хандуулж өгөөч.

Хэрвээ ингэж чадвал бид нар энэ газрын тосны үйлдвэрээ бас 2027 онд нь ашиглалтад өгөх чиглэлээр ажиллах бололцоо боломж байна аа гэж байгаа. Энэ дээр бас сайд бас анхаарч ажиллаж өгөөрэй.

Н.Учрал: Гонгорын Дамдинням сайд.

Г.Дамдинням: Тийм Сандагаа гишүүн маань бас яг л ажилтай нь очиж танилцсан хүний хувьд хэлж байна аа. Би газрын тос боловсруулах үйлдвэрийн импорттой холбоотой тэр ажилчдынх нь визтэй холбоотой энэ хүндрэлүүд байсныг бол Сангийн яамтай ажиллаад би 14 хоног болгон Алтанширээ дэх энэ төслийн удирдагчдаас болон Энэтхэгийн компаниудаас мэдээлэл аваад асуудлуудыг нь шийдээд ингээд явж байгаа. Маш удаашралтай байсан асуудлууд хурдтай шийдэгдээд явж байгаа. Тэгээд бид энэ дээр байнгын зүгээр зохион байгуулалтын л ажил байхгүй юу. Ер нь тэгээд энэ дээр нь туслаад явж байгаа. Визийг нь урт хугацаагаар олгох хууль эрх зүйн орчин бүрдчихсэн байгаа, хэрэгжүүлээд явж байгаа.

Н.Учрал: Сандаг-Очир гишүүн нэмэлт тодруулах уу? Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Манай шинэ Их Хурлын дарга чинь ер нь цагийг бараг тултал өгөөд бараг больё гэтэл нь хуучин цаг олдохгүй яриулсангүй гэдэг байсан. Эсрэгээрээ больё оо гэтэл цаг өгдөг болсонд бас өөрчлөлт гарсан байна аа гэж. Ер нь та бүхэн Оросын талтай ярьж үзсэн үү? Энэ Газпром компанийг ер нь цаашдаа Монгол Улсад салбар юмыг нь нээх энэ асуудал олон жил яригддаг л юм байна лээ. Энэ дээр ер нь Монгол Улс холбогдох яам Засгийн газар ер нь ямар байр суурьтай байдаг юм? Дотоодын ААН-ээ бизнесээ хамгаалуулна гээд ингэж байдаг юм уу? Аль эсвэл ямар учраас ингээд энэ асуудал дээр өдий хүртэл ямар нэг тодорхой ахиц дэвшил өөрчлөлт гарсангүй явж байна. Сая бас холбогдох Оросын ЭСЯ холбогдох Засгийн газрынхантай уулзалт хийсэн. Энэ талаар цаашдаа яригдаж байгаа зүйл байна уу? Энэ дээр холбогдох сайдын хувьд ямар мэдээлэлтэй байна?

Н.Учрал: Гонгорын Дамдинням сайд.

Г.Дамдинням: Энэ шатахуунтай холбоотой асуудал дээр энэ Газпромын хувьд бол манай улсаар дамжин өнгөрөх Сибирийн хүч 2 төслийг хэрэгжүүлэх гэж байгаа. Манай Шадар сайдаар ажиллаж байсан Амарсайхан сайд нэлээн голлож ажиллаж байсан. Нэлээн ч ахиц гаргачихсан байгаа. Тэгээд энэ компанийн төлөөлөл энд байгуулагдаад ажиллана. Газрын тос болон байгалийн хийтэй холбоотой асуудлуудыг энэ айлтай хамтраад зохион байгуулахаар ингээд ажиллаж байгаа.

Н.Учрал: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байгаа юм аа. Тэгэхлээр би бол надад нэг санал, нэг асуулт байгаа. ОХУ-аас орж ирэх шатахууны хангамж нийлүүлэлт удааширч байгаа үед бид нар магадгүй хоёрдогч, гуравдагч гарцынхаа боломжийг нэмэгдүүлэх эрэлхийлэх тал дээр ажиллах хэрэгтэй байна гэж харж байгаа. Үүний тулд бид нар Замын-Үүдийнхээ ачих буулгах стакадыг хүчин чадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа л даа. Замын-Үүдээр шатахуун орж ирж байгаа үед бөөгнөрөл гацаа

вагоны гацаа үүсэх ийм байдал ажиглагдаад байгаа. Тэгэхээр та бүгдийгээ Замын-Үүдийн ачих буулгах стакадаа сайжруулаарай. Тэрийг хурдыг нэмэгдүүлээрэй гэж ингэж хэлэх гэж байгаа юм.

Цаашлаад бид нар авто замын боомтод Гашуун сухайт, Шивээ хүрэн, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увсын боомтуудаа байнгын ажиллагаатай байх тал дээр нь анхаарах хэрэгтэй гэж ингэж хэлэх гэж байгаа юм л даа. Тэгээд ер нь бол ОХУ-аас ч тэр БНХАУ, Солонгосоос өндөр чанарын шатахуун орж ирдэг. Энэ үед бол бид нар бол энэ шатахууныхаа үнийг либералчлах хэрэгтэй байгаад байгаа юм. Ингэх юм бол энэ шатахууны хангалт нийлүүлэлтийн асуудлууд бол нэлээн шийдэгдэнэ гэж ингэж хэлж байгаа юм.

Миний асуулт бол энэ хуулийн 7.2 дээр Засгийн газар энэ хуулийн 7.1-д заасан нөхцөлөөс үл хамааран төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамж хяналтын системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна аа гэж оруулж ирсэн байгаа юм. Тэгэхлээр ер нь бол манай Газрын тосны газар гэж байгаад байгаа юм. Үүнээс гадна энэ төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ер нь яг энэ заалтаар ямар өөрчлөлт оруулж ирэхээр оруулж ирсэн бэ гэж ингэж асууж байгаа юм.

Н.Учрал: Гонгорын Дамдинням сайд.

Г.Дамдинням: Пунсалмаа гишүүн маань бас салбарын зовлон жаргалыг маш сайн мэддэг хүний хувьд яг л хэлж байна. Манай бусад эх үүсвэрээс авах чиглэлд бол бид ОХУ-аас гадна БНХАУ-аас авах хэлэлцээрүүдийг хийгээд явж байна. Удахгүй Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хувьд БНХАУ-д айлчилна. Айлчлаад энэ асуудлуудаа ярина. БНХАУ-ын хувьд бол шатахууны төрлийн бүтээгдэхүүнүүдийг экспортлохдоо бол тусгай квот гаргадаг ер нь хориглочихсон байдаг юм байна лээ. Бидний тусгайлан тавьсан хүсэлтэд бол нааштай хандаж бас энэ асуудал дээр хамтарч ажиллаж байна.

Замын-Үүд дэх ачих буулгах байгууламжийн маань хүчин чадал үндсэндээ манай улсын нийт хэрэглээний 20 хувийг хангах хэмжээнд байгаа. Зөвхөн вагоны байгууламжаар дамжуулдаг стокад буюу дамжуулан ачих гар байгаа. Автомашины гаруудыг нэмэх зайлшгүй шаардлагатай байгаа. 5 жилийн хугацаанд усан онгоцны түлш аваачаад гацаагаад хаячихсан байсан байна лээ. Савнуудыг нь дүүргээд орхичихсон байна лээ. Сая бол тэр хийчихсэн байгаа айлыг нь Лекс ойл гэж айл байгаа. Өөрөөр хэлбэл хуурамч шатахуун үйлдвэрлэдэг байсан айл гэсэн үг. Энэ айлын бүтээгдэхүүнүүдийг ав авахгүй бол энэ импортын тусгай зөвшөөрлийг чинь цуцална аа гэдэг шаардлага тавиад одоо энэ султгах ажил эрчимтэй хийгдэж байна, суллана.

Мөн бас энэ боомтуудын асуудал байгаа ГХЯ-тай хамтраад бид авто бензин зөвхөн Замын-Үүдээр л нэвтрүүлэх эрхтэй байгаа. Саяхан Шивээ хүрэнгээр автомашинаар дизелийн түлш импортлох эрхтэй болсон. Такашкенээр оруулж ирэх эрхтэй болсон. Энэ боомтууд дээрээ одоо авто бензин болон шатахууны бусад бүх төрлийн бүтээгдэхүүнүүдийг оруулж ирэх хэлэлцээрийг хийгээч гэдэг хүсэлтийг Гадаад хэргийн яаманд тавьсан. Мөн бас урд хөрштэйгөө бид нар ярилцаж байна шийдэгдэх байх аа.

7.2-ын тэр хяналтын систем гэдэг бол түрүүний яриад байсан зүйл. Өөрөөр хэлбэл улсын хэмжээнд байгаа бүх ШТС-уудад ямар хэмжээний нөөц байгаа юм яагаад өгөхгүй байгаа юм бэ гэдгийг бүрэн цахимжуулж хянадаг системийг тогтоох гэж байгаа юм. Ингээд импортын хэмжээ 50 хувиас доош орох юм бол нөөцийн хуваарилалтад төр оролцдог байх зохицуулалтыг энэ хуулиар хийх гэж байгаа юм.

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Өмнөх Засгийн газрын үед болохлоор би ямар шүүмжлэл ихээр тавьдаг байсан бэ гэхлээр яаралтай горимоор янз бүрийн хууль тогтоомжийн төсөл оруулж ирээд гишүүдийг бас хангалттай мэдээллээр хангахгүй байдлаар ийм хуулийн төслүүд батлаад байна аа гэдэг шүүмжийг маш ихээр хэлдэг байсан. Шинэ Засгийн газрын хувьд бол мөн ялгаа байхгүй энэ арга барил руу шилжиж байгаад бас дурамжхан байна. Яагаад вэ гэхлээр бид нар энэ яаралтай горимоор битгий оруулж ирээд байгаач гэдэг чинь нэг талаас гишүүд болохлоор бас нэг мэдээлэлтэй танилцах хэрэгтэй. Бэлтгэл хангах хэрэгтэй.

Дээрээс нь олон нийт мэдээлэлтэй байх ёстой. Энэ чинь нийтийн хэлэлцүүлэг явж байж энэ хуулиуд чинь батлагдах ёстой. Тэгээд энэ орж ирж байгаа хууль ч гэсэндээ ерөнхийдөө бол ийм хууль шаардлагагүй асуудлаар бүхэл бүтэн хуулийн төсөл боловсруулаад оруулаад ирж байна гэж харж байна. Яагаад вэ гэхээр ер нь өнгөрсөн хугацаанд бас ийм явдал газар авчихжээ. Засгийн газар өөрөө хариуцлагаас зугтах гэдэг юм уу өөрсдийнхөө Засгийн газар гүйцэтгэх засаглалын бүрэн эрхийн хүрээнд ийм нээлттэй боломжтой шийдвэр гаргаад явах боломжтой зүйлүүд дээр заавал Улсын Их Хурлаар хууль батлуулаад дараа нь энэ Улсын Их Хурлын баталсан хуулийн хүрээнд л бид нар үйл ажиллагаа явуулсан шүү дээ гэдэг тэр гэм зэмээ залруулах гээд байдаг юм уу. Нэг ийм сонин жишиг тогтчихжээ. Тэгээд энэ стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт гээд л нэг их сүртэй нэртэй. Тэгсэн хэрнээ ерөнхийдөө ингээд нэг цөөхөн хэдэн заалттай. Энэ шатахуун импортлогч хэдэн компаниудад л Монголбанкнаас зээл олгох гээд байх шиг байгаа юм. Тэгж тэгэнгүүтээ Монголбанкны төв банкны бүүр хараат бус байдалд бас халдаад Төв банкны хуулийн тодорхой заалтуудыг хамаарахгүй энэ тэр гэсэн тийм агуулгатай зүйл оруулж ирээд байгаа юм.

Энэ гүйцэтгэх засаглал асуудал байвал түүгээрээ шийдээч. Гүйцэтгэх засаглалынхаа эрх мэдлийнхээ хүрээнд аливаа асуудал хандаач гэж бас хэлмээр байна аа. Яагаад вэ гэхлээр дараа нь ахиад л энэ Их Хурлаар хууль баталчихдаг. Дараа нь энэ нөгөө шатахууны савны хулгай гээд л яригдах юм бол хаашаа юм Их Хурал руу заах гээд байгаа юм уу. Энэ бас ингээд л их тийм сонин эрх ашгийн зөрчил үнэртсэн л хууль орж ирж байгаа юм. Тэр тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд чинь энэ 30 гаруй жил үйл ажиллагаа явуулахдаа тэр шатахууны савнуудаа барьчихдаггүй юм уу. Тэгээд нийт хэдэн төгрөгийн асуудал яригдаад байгаа юм бэ? Хэчнээн төгрөгийн зээл олгох гээд байгаа юм гэдэг дээр яг тодорхой ийм мөнгөн дүнгийн хариулт авъя аа.

Тэгээд дээрээс нь ер нь бид нар ийм асуудалд ийм урт хугацааны байдлаар огт хандахгүй байна аа. Дандаа нэг ийм тулгасан дандаа нэг ийм асуудалд ийм гал унтраах байдлаар хандсан байдлаар хандаж байна аа. Тэгээд энэ уул уурхайн салбарын олборлолт нэмэгдээд байгаа учраас дизель түлшний эрэлт ихсэж байна аа гэж хэлж байна аа. Уул нь бид нар урт хугацааны бодлого нь юу вэ гэхлээр энэ уул уурхайн салбарт ХАА-н салбарт тоног төхөөрөмжүүдээ цахилгаанжуулах ажлыг

хиймээр байгаа байхгүй юу. Одоо машинууд, цахилгаан машинууд авч ажиллуулмаар байгаад байгаа юм. Тэгэхийн тулд бид нар бас нөгөө эрчим хүчнийхээ салбарыг хөгжүүлмээр байгаад байгаа юм. Цахилгаан станцуудаа баримаар байгаад байгаа юм. Тэгээд энэ гэх маягаар энэ юу гэдэг юм импортын түлшнээс хараат бус байдлаа шийдэхгүй. Түүнээс биш нэг богино хугацаанд нэг ийм гал унтраах маягтай асуудалд хандаад байх юм бол цаашлаад ер нь энэ шатахууны савуудыг чинь дараа нь яах юм гэх мэтчилэн ийм маш олон асуултууд байна.

Тэгээд төгсгөлд нь хэлэхэд сая ингээд 1 сарын өмнө шатахуун тасалдлаа барилаа энэ тэр гээд л байсан. Тэгэхэд бол Дамдинням сайд тийм зүйл гараагүй энэ тэр гээд л мэдээлэл өгөөд байсан. Яг үнэндээ ийм хууль оруулж ирэх гээд тэгээд тийм хомсдол үүсгээд байдаг юм уу яагаад байдаг юм бас янз бүрээр хардах ийм нөхцөл байдлууд бий болж байна шүү дээ.

Тэгээд ер нь цаашид энэ шатахууны хомсдол ямар байх юм гэдгийг та бас хэлж өгөөч? Тэгээд ер нь шатахууны үнийн хувьд бол ийм асуудал үүсэхгүй байгаад байгаа шүү дээ. Дэлхийн зах зээл дээр баррель нефт 60 орчим долларын л үнэтэй байгаа.

Н.Учрал: Жаргалан гишүүн чухал асуудал хөндөж байна шүү. Цаашдаа энэ цахилгаан машин яах юм. Сэргээгдэх эрчим хүч, хүлэмжийн хий бууруулах, энэ карбон кредит тооцох гээд олон бас ажлуудыг давхар хийж явахгүй бол ингэж гал унтрааж болохгүй гээд. Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Бас хууль хэрэггүй яаралтай горим гэхээр би Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу л оруулж ирж байгаа. Яаралтай горимоор бид нар хэлэлцэхээс өөр арга алга. Улс орны эдийн засгийн гол хөдөлгөгч хүч түлш шатахуун болчихоод байна. Бидний гол импортлогч ААН-үүд маань юу улс маань бол би хэллээ шүү дээ 95-97 хувийг Оросын холбооны Улсаас авч байна. 35 жил хийгдээгүй байсан шийдлийг л хийх гээд явж байгаа шүү дээ Жаргалан гишүүн ээ. Яагаад энэ өмнөх сайд нар оруулж ирээгүй юм би мэдэхгүй байна. Өөрийгөө сайн ажил хийж байна гэж бодохгүй байна, хийх ёстойгоо хийж байна.

Хууль яагаад хэрэгтэй байгаа юм яагаад хууль хэрэгтэй байгаа юм. Яагаад гэвэл Монголбанкнаас репо санхүүжилт гаргахын тулд зайлшгүй хууль хэрэгтэй байгаад байгаа юм. Тухайлсан нэг аж салбарыг дэмжихгүй гэдэг бодлоготой юм байна лээ. Хууль нь өөрөө тийм. Энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой, стратегийн бүтээгдэхүүнтэй холбоотой асуудал дээр тусгайлсан хууль гаргаж өгөөч гэдэг хүсэлт тавьж байгаа. Тэр нь бас зайлшгүй юм байна лээ. Энийг нь хийж өгч байна. Нийт эх үүсвэрийн тухайд бол 1 сарын хэрэглээний шатахууны нөөц хадгалах сав байх барихад бол 500 тэрбум төгрөг хэрэгтэй. Баригдсан энэ савыг дүүргэхэд 560 тэрбум төгрөг хэрэгтэй. Нийтдээ 1 их наяд орчим төгрөгийн л эх үүсвэрийн асуудал яригдаж байна. Энэ урт хугацаандаа яригдаж байна шүү. Урт хугацааны шийдэл бол ногоон эрчим хүч гэж хэллээ. Үнэн ёстой санал нэг байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас санал гаргаад манай Их Хурлын дарга Эдийн засаг, хөгжлийн сайд байхад хамтраад ажлын хэсэг гаргаад улс орны хэмжээнд тархмал эх үүсвэрийн төсөл хэрэгжүүлэхээр ярилцаад судалгааны ажилдаа орчихсон явж байна. Мөн одоо удахгүй бас уул уурхайн төслүүдийн ТЭЗҮ-үүд дээр ногоон эрчим хүчээр ажилладаг байх шалгуурыг тавья гэсэн төлөвлөгөөтэй байна.

Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас энэ цахилгаан машинуудыг дэмжих бүх төрлийн татвараас чөлөөлөх тогтоолын төслийг бэлдээд Сангийн яаманд хүргүүлчихсэн байж байгаа. Хариугаа хүлээгээд байж байна. Засгийн газрын хуралдаанаар оруулж шийднэ. Шатахуунтай холбоотой асуудал дээр бол сая АИ 92 авто бензин дээр нэлээн улс төржсөн асуудал явчихлаа.

Өдрийн манай хэрэглээ бол улсын хэмжээнд 2 мянга байсан. Одоо бид нар 4 мянгаар хийгээд өөрөөр хэлбэл хүчин чадлаа 2 дахин нэмээд байхад арай гэж тогтворжиж байна. Энэ нь өөрөө яг тийм манай шатахуун чинь өөрөө ингээд аргацааж явсаар байгаад ингээд банк шиг болчихсон юм билээ. Хүмүүс очоод очерлочихоор бүгдээрээ дагаад очерлочихдог. Тэгээд л ерөөсөө дуусчих вий дээ гэсэн ийм айдастай ийм л нөхцөл байдалд хүрчхээд байгаа. Гол шалтгаан бол савгүй. Дээрээс нь их эмжээр захиалдаггүй. Ийм л нөхцөл байдалд хүргээд хаячихсан юм байна. Шийдэцгээе хэдүүлээ өөр арга алга. Урт хугацааны шийдэл хийчих гээд л оролдоод байна. Т

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн тодруулна.

Б.Жаргалан: Тэгэхээр Дамдинням сайдын танилцуулснаар нийтдээ 1 их наяд 60 тэрбумын санхүүжилтийн асуудал яригдах юм байна. Монголбанкнаас тэр гаргах зээл нь ямар хүүтэй байх юм? Ямар хугацаатай байх юм? Тэгээд тэр компаниудад ямар шалгуур тавих юм? Энд маш олон зүйл маш ойлгомжгүй байгаад байна л даа. Тэгээд яг ямар компаниуд энэ санхүүжилтэд хамрагдах юм? Хаана хаана тэр санхүү шатахууны савнууд чинь баригдах юм гэх мэтчилэн ерөөсөө нөгөө нэг ийм маш бүрхэг хууль оруулж ирчхээд тэгээд тэрийгээ нөгөө Их Хурлыг батал гээд яаралтай горимоор оруулаад ирж байгаад чинь л би бол ер нь дургүйцээд байгаа шүү.

Тэгээд цаашдаа энэ урт хугацааны бодлогоо хэдүүлээ яримаар байна аа. Дандаа ийм гал унтраах байдлаар ерөөсөө явж болохгүй байгаад байна аа тэгээд энэ стратегийн ач холбогдолтой энэ тэр гээд л яриад эхлэхээрээ бас буруу урууддаг асуудлууд бид нарт өмнөх олон жилүүдийн хугацаанд байсан.

Тэгэхээр энэ асуудалд маш их тийм болгоомжтой хандах ёстой гэж би хувьдаа үзэж байна. Тэгээд гишүүддээ ч гэсэндээ асуудалтай бас нэлээн сайн танилцаж байгаад саналаа өгөөрэй.

Н.Учрал: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Энд Монголбанкны бодлогын хүү 12 хувь, энэ хэнд өгөхийг бол арилжааны банк шийднэ. Дамдинням шийдэхгүй, Аж үйлдвэрийн яам шийдэхгүй, төр шийдэхгүй. Хувийн хэвшил өөрсдөө арилжааны банканд очно. Арилжааны банк Монголбанкнаас тусгайлан энэ шатахуунд зориулж байгаа эх үүсвэр энэ стратегийн бүтээгдэхүүн буюу энэ шатахуунтай холбоотой дэд бүтэц сав бас эргэлтийн хөрөнгөтэй холбоотой зээлээ ААН-үүд авна. Үнэгүй мөнгө хэнд ч өгөх гээд байгаа асуудал байхгүй. Зээл авна зээлээ төлнө.

Хоёрдугаарт бол энэ байрлалтай холбоотой асуудал түрүүн бас би Их Хурлын гишүүдийн асуултад хариулсан. Тодорхой бус та бас сонсоогүй байж магадгүй. Бүсүүдэд байгуулна. Бүсүүдэд стратегийн байрлал тодорхойлж байж тавина. Манай хэрэглээ их тодорхой байдаг. Дараачийн аж үйлдвэртэй холбоотой төслүүдийн байрлалуудыг бид нар зарлачихсан байгаа. Энэ дээрээ явна аа.

Н.Учрал: Жаргалан гишүүн ийм үндэслэлтэй асуудлыг хөндөж байна. Тэгээд өнөөдөр орой Дамдинням гишүүн та Жаргалан гишүүнд тухайлан тайлбарлаж өгнө шүү хуулиа. Та 2 өнөөдөр орой уулзана. Нэн яаралтай горимоор хууль оруулж ирчхээд байна. Тийм тэгэхээр нэн яаралтайгаар уулзах хэрэгтэй. Баярлалаа. Манай чуулганы хуралдаантай хүүхдүүд, сурагчид танилцаж байна. Бүгдэд нь сурлагын өндөр амжилт хүсье. Энэ чинь ямар амнаас нэг алт унах гээд байгаа биш. Би нэг ингээд уншихад аятайхан байгаа биз дээ? Тэгээд маргаашаас нэр усыг нь оруулж ирээд энэ дээр тавиарай. Тэгээд би сайхан уншина аа.

Тэгээд дээрээс нь тэр төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлдэг байсан. Тэрийг бас сэргээнэ. Би гишүүддээ төрсөн өдрийн мэнд дэвшүүлэе. Бүгдээрээ энэ чинь бие биедээ хүндэтгэлтэй хандана шүү. Баярлалаа танай. Тойргийнхон уу? Харин тийм. Ингээд гишүүд чинь ингээд тойргийнхоо сонгогч нарыг оруулж ирээд тэгээд уншуулаад тэгээд нэг туган дээрээ зургаа авхуулаад гаргачихна хүндэтгэл шүү дээ. Төрийн ордноо бас үзэж сонирхоод хүндэтгээд гарах чинь. Тэгэхэд нь энэ нэг шилэн хоргоны цаана гаргачихсан. Уг нь энэ чинь хуучин дээрээс тонгойж хараад аятайхан байсан шүү дээ, тийм нээлттэй л болгох хэрэгтэй. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн байр сууриа илэрхийлсэн гишүүдэд баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ.

Сандаг-Очир гишүүн, Пүрэвдорж гишүүн хаачсан бэ? Үг хэлэх ёстой шүү дээ. Тийм та индэр дээр. Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүнээ дуудаарай үг хэлнэ шүү.

Ц.Сандаг-Очир: Стратегийн бүтээгдэхүүний нийлүүлэлт хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр орж ирж байгаа Засгийн газраас яаралтай горимоор орж ирсэн хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд Монголчууд саалиа бэлдэхээр саваа бэлд гэдэг. Харамсалтай нь өнгөрсөн хугацаанд бид нар нэг сайндаа 1 сарын хэрэглээг л даах хэмжээний нөөц савтай юм байна. Одоо энэ хуулийн төсөл орж ирснээр цаашдаа 2-оос 3 сарын хэмжээний хэрэглээг даах улсын хэмжээний нөөц савтай болох юм байна. Энэн дээр Монголбанкнаас арилжааны банкуудад санхүүжилтийн зээлийн эрхийг олгохоор ингэж явж байгаа юм байна аа. Тэгээд уг нь бол ийм бололцоо боломж байсан бол эртнээс заавал энэ ард иргэдээ уурлуулж, бухимдуулж, бензин шатахуунаар тасалдуулж очер дугаар үүсгэж байж ингэж арга хэмжээг мэдэрдэг биш ийм асуудал үүсэхээс урьдчилан сэргийлж энэ арга хэмжээг авдаг байвал зөвхөн энэ бензин дээр ч биш цаашдаа ер нь аливаа асуудал дээр ийм мэдрэмжтэй хандаж байвал энэ Засгийн газар сайд нар бас сайн байна аа гэж хэлэх байна аа.

Тийм учраас бид нар жил ирэх тусам улсын төсөв экспортоос хамааралтай нүүрсний экспортыг нэмэгдүүлж 5, 10 сая тонноор нэмэгдүүлж байгаа юм. Саяхан л бид нар 80 сая тонн нүүрс экспортолно гэж байсан бол 85, 90 ирэх жил 100 саяыг экспортлох энэ хэрэглээг энэ экспортыг дагаад хэрэглээ өсөж байгаа. Энэ хэрэглээг

өссөнтэй холбогдуулаад дагаад бас хэрэглээ ард, иргэдийн нийлүүлэлт эдийн засаг бас өсөж байгаа. Энэ байдал харагдаж байна.

Тийм учраас АИ 92, 95 дизель түлшний хэрэглээнүүд бүгд бүх шатдаа өсөж байгаа юм байна аа. Энийг Засгийн газар олж анзаарч харж энэ өсөж байгаа хэрэглээг даах эдийн засгийг тэлэх хэмжээнд энэ бодлогын арга хэмжээ хуулийг оруулж ирж байгаа нь бас сайшаалтай байна гэж үзэж байна. Харин цаашлаад бид нар энэ нөөц сав бүрдүүлэлтүүдийг ААН-үүдэд яг зориулалтынх нь дагуу бүсүүдэд доод тал нь дээд тал нь 1700 км-ийн алсад байгаа баруун аймгуудад 500, 600 км-т байгаа зүүн аймгуудад Улаанбаатар хотоос зөөж тээвэрлэх асуудлаас ярихдаа илүүтэй энэ бүсийн төвийн нөөц хангамжийн төвүүдийг байгуулах асуудлыг бодлогоор эрдэс баялгийн яам хийх нь зүйтэй гэж хувьдаа үзэж байна аа.

Тийм учраас энэ хуулийг бас гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна аа. Баярлалаа.

Н.Учрал: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Пүрэвдорж гишүүн байхгүй байна. Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэллээ. Гишүүд үг хэлж дууссан тул Байнгын хорооны саналаар Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна аа. Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Баярлалаа. Бүгдэд нь сурлагын өндөр амжилт хүсье ээ.

Тийм байна. Зөв зөв ойлголоо. Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна.

Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн хууль хэлэлцэх эсэхийг дэмжье. Тэгээд нэн яаралтай горимоор бас хэлэлцэж байгаа тулд гишүүд зарим нь мэдээлэлгүй байгаа. Тэгэхээр нэмэлт мэдээллүүдийг Дамдинням сайд бас өгөөд явах хэрэгтэй. Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна.

Би сайд нарыг 2 хоногийн дараа цоллоод байхаар бас Бямбацогт даргынхаа зовлонг ойлгож байгаа учраас 7 хоног дуугай байя аа. Тийм 7 хоног дуугүй байя аа. Пүүжээ гишүүн нэг үг хэлж байх уу? Пүрэвдорж гишүүн үг хэлэх үү? Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Дамдинням сайд ирцээ бүрдүүлээрэй.

Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярын урилгаар Дархан төмөрлөгийн үйлдвэрийн ажилтан албан хаагч нар Их Хурлын чуулганы хуралдааны үйл ажиллагаатай танилцаж байна аа.

Та бүхэнд ажлын амжилт сайн сайхныг хүсье ээ.

Далайн Батбаяр гишүүн хариуцлагатай сайн ажиллаж байгаа гишүүн гэдгийг та бүхэнд онцгойлон хэлье ээ. Баярлалаа.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн бас дэмжиж байгаа юм байна шүү. Үгүй үгүй энэ уулзалтыг хамтран зохион байгуулж байгаа энэ 2 та бүхэнтэй 9 хөлт туг дээр зургаа авхуулна аа.

2 минутын чөлөө олгож байна аа. Танай тойргоос сонгогдсон Гонгорын Дамдинням сайд бензиний асуудлаа шийдэх гээд хуулиа оруулж байгаа шүү. Тийм амжилт хүсье ээ.

Санал хураалтад бэлтгэе. Их Хурлын гишүүдийг урьж байна. Бямбацогт дарга.

Засгийн газрын гишүүдийг танхимд урьж байна. Засгийн газрын гишүүдийг танхимд урьж байна. Ер нь Пүрэвдорж гишүүн бас үнэн үг хэллээ шүү. Хэрвээ Тэргүүн Шадар сайд байсан хөөрхий тэнд сууж л байгаа. Тийм Пүүжээ гишүүн Тэргүүн Шадар сайд байсан бол тэнд хөөрхий сууж л байгаа. Сайд нар орж ирье. Энэ Засгийн газрын өргөн мэдүүлсэн хууль шүү.

Санал хураалт явуулъя.

Санал хураалтад бэлтгэе.

Дахиад нэг санал хураалтад бэлтгэе.

5 жилийн үндсэн чиглэлийг Тэмүүлэн гишүүний ажлын хэсэг хуралдуулж эцэслэж байгаа. Өнөөдөр Эдийн засгийн байнгын хороо 4 цагаас хуралдана. Хуулийн хугацаатай. Маргааш өглөө 10 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан эхлээд олон асуудлууд байгаа шүү. Тэр 5 жилийн чиглэлийг хуулийн хугацаанд нь батлах ёстой. Олон санал хураалттай. Тэгэхээр маргааш Засгийн газраас өргөн мэдүүлсэн 5 жилийн үндсэн чиглэл учраас энэ Их хурлын гишүүд Засгийн газрын гишүүд ажил бусад ажил албаа хойш нь тавиад чуулганы хуралдаанд идэвхтэй оролцох хэрэгтэй байна. Маргааш бараг 200 санал хураалт болно гэххэв үү. Дамдинням сайд наад хүмүүсээ дууд л даа.

Ингээд санал хураалт явуулна. Тэгээд дэмжвэл дэмжээд, дэмжихгүй бол тэр биз тийм биз. Байнгын хорооны саналаар Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

49 гишүүн дэмжиж, 42 гишүүн татгалзсан байна. 53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

15.48 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*